



ОЮУНЛАГ БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ТӨЛӨӨ

ЦАЦ

**СУРГАЛТ, СУДАЛГАА,
АРГА ЗҮЙН УЛИРАЛ
ТУТМЫН СЭТГҮҮЛ**

2020 №16/39/

- » **Э.Наранбаатар: Зэвсэгт хүчний төрийн захиргааны удирдлагын зарим асуудал**
- » **Д.Баасандамба: Зэвсэгт хүчний шинэчлэл ба цэргийн сургалт**
- » **Ц.Батбаяр: Цэргийг агаарын довтолгооноос хамгаалахын зэвсэглэл, өнөөгийн байдал, сайжруулах арга зам**
- » **Ц.Гандорж: Тулгарах байлдаан, түүний онцлогт хийсэн судалгаа**



ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИАС ЭРКЛЭН ГАРГАВ





ОЮУНЛАГ БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ТӨЛӨӨ

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:

Хурандаа Б.Өлзийхуяг ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэлийн асуудал хариуцсан дэд захирал, доктор (Sc.D), профессор

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

Ахлах дэслэгч Н.Мөнх-Очир Эрдэм шинжилгээ, инновацын хэлтсийн Нэгдсэн лабораторийн цэргийн зориулалттай лабораторийн эрхлэгч, магистр

Редакцийн гишүүд:

Хурандаа Э.Нацагдорж Эрдэм шинжилгээ, инновацын хэлтсийн дарга, доктор (Ph.D)
Дэд хурандаа Д.Мандахбаяр Сургалтын хэлтсийн дарга, доктор (Ph.D)
Б.Баатарсүрэн БХЭШХ-ийн Батлан хамгаалахын дүн шинжилгээний төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)
Хурандаа Г.Эрдэнэбаатар БХУА-ийн Цэргийн стратегийн төвийн дарга, докторант
Хошууч Л.Одмаа ЦНДС-ийн Цэргийн холбоо, кибер аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)
Х.Орхончимэг БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

Техник редакцийн гишүүд:

Д.Насанжаргал Дизайнер

Редакцийн хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, БНМАУ-ын баатар Д.Нянтайсүрэнгийн гудамж, 16 дугаар хороо, Улаанхуаран

Утас/факс: 976 11 480172

Шуудангийн хайрцаг: 13300

Веб хаяг: www.mndu.gov.mn

Цахим шуудан: tsats@mndu.gov.mn

Олон улсын индекс: ISSN 2313-8076

Эрхлэх байгууллага: Монгол Улсын Үндэсний Батлан хамгаалахын их сургууль

Хэвлэх үйлдвэр: ҮБХИС-ийн Хэвлэх үйлдвэр



FOR INTELLECTUAL AND CREATIVE THINKING

EDITORIAL BOARD

Editor-In-Chief

Colonel B.Ulziikhuyag Deputy Director for Research and social partnership Prof. (Sc.D)

Deputy Editor-In Chief

First Lieutenant N.Munkh-Ochir Chief of Laboratory for Military uses of Unified Laboratory of Department for Research and innovation, MNDU

Editorial Panel

Colonel E.Natsagdorj Chief of Department for Research and innovation, MNDU, Ph.D
Lieutenant Colonel D.Mandakhbayar Chief of Training Department, MNDU, Ph.D
Colonel G.Erdenebaatar Chief of Military strategic center of Defense Management Academy, MNDU
Major L.Odmaa Senior Lecturer of Military Signaling and cyber security Department of Joint Military School, MNDU, Ph.D
B.Baatarsuren Research fellow of Center for Defense Analyses of Institute for Defense Studies, MNDU, Ph.D
Kh.Orkhonchimeg Research fellow of Center for Security and Defense Studies of Institute for Defense Studies, MNDU, Ph.D

Technical Editor

Nasanjargal.D Designer, Illustrator

Address:

Mongolian National Defense University
Nyantaisuren Street, Bayanzurkh District, Ulaanbaatar, Mongolia, 13300

Phone: 976 11 480177

Fax: 976 11 480172

Mail box: 13300

Website: www.mndu.gov.mn

E-mail: news@mndu.gov.mn

ISSN: 2313-8076

Host: Mongolian National Defense University

Published by: Defense Press



ҮНДЭСНИЙ БАТЛАН
ХАМГААЛАХЫН
ИХ СУРГУУЛИАС
ЭРХЛЭН ГАРГАВ.

2020
№16/39/

СУРГАЛТ,
СУДАЛГАА, АРГА
ЗҮЙН УЛИРАЛ
ТУТМЫН
СЭТГҮҮЛ

ДУГААРЫН ТОВЧООН

Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал:

Э.Наранбаатар: Зэвсэгт хүчний төрийн захиргааны удирдлагын зарим асуудал	6
Д.Идэшноров: Үндэсний аюулгүй байдалд нийгмийн сэтгэл зүйн үзүүлэх зарим нөлөөлөл	11
Ж.Жамсрандорж: Мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга зам	16

Батлан хамгаалах боловсрол, цэргийн сургалт:

Д.Баасандамба: Зэвсэгт хүчний шинэчлэл ба цэргийн сургалт	19
Р.Энхболд: Орон нутгийн хөгжил, орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах суурь болох нь	26
Х.Орхончимэг: БНХАУ-ын батлан хамгаалах боловсролын чиг хандлага	34
С.Юндэн: Цэргийн эмнэлгийн газар зүй	37
П.Цэдэв: Гамшгийн үед ОХУ-ын онцгой байдлын /РСЧС/ удирдах байгууллагуудын харилцан ажиллагааны туршлага	45
Б.Нэргүй, Т.Уранчимэг: Зэвсэгт хүчний хүний нөөцийн бүртгэл мэдээллийн систем, түүний онцлог, хэрэглэх арга зүй	53
Г.Энхжаргал: Цэргийн цахим сургалтын орчинг сайжруулах арга зам	59


Цэргийн зэвсэглэл, техник, инновац судлал:

Ц.Батбаяр: Цэргийг агаарын довтолгооноос хамгаалах зэвсэглэл, өнөөгийн байдал, сайжруулах арга зам	62
Н.Хүдэрбат: Хас бэлгэдэл тэмдгийн хэрэглээ Зэвсэгт хүчинд ...	71

Шинжлэх ухаан судлал, дайны туршлага сургамж:

Ш.Паламдорж: "Цагийн байдлыг тогтоох" хэмээх нэр томъёоны тухай шүүмж	77
Ц.Гандорж: Тулгарах байлдаан, түүний онцлогт хийсэн судалгаа	82
С.Пүрэвдорж: Терроризм үүсэж буй учир шалтгаанд хийсэн шинжилгээ	88

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ЗАРИМ АСУУДАЛ



Э.НАРАНБААТАР /ҮБХИС-ийн БХУА-ийн цэргийн удирдлагын төвийн ахлах багш, хурандаа/

2000 онд ЦИС-ийг "Цэргийн холбооны офицер, радио холбооны ашиглалтын инженер" мэргэжлээр, 2009 онд БХУА-ийг "Стратеги-тактик, команд штабын офицер" мэргэжлээр тус тус төгссөн. Цэргийн ухааны магистр, ҮБХИС-ийн докторант.

Түлхүүр үг: Удирдлага, Субъект, Төрийн захиргаа,
Зэвсэгт хүчний төрийн захиргааны удирдлага

Key words: Management, Subject, State administration, State administration
management of the Armed forces

Хураангуй. Зэвсэгт хүчний төрийн захиргааны удирдлага нь Зэвсэгт хүчнийг хүний нөөц, зэвсэг техникээр хангах, төрөл бүрийн нөөцийг бэлтгэх, цэргийн амьдрал үйл ажиллагааг хангах асуудлууд юм.

Төрийн захиргааны удирдлагын зорилго нь Зэвсэгт хүчний байгуулалтын үндсэн зарчимд тулгуурлана. Үүнд:

- ✓ Зэвсэгт хүчний өдөр тутмын амьдрал, үйл ажиллагааны эрх зүйн хэм хэмжээг хууль тогтоох байгууллагаар тогтоолгох;
- ✓ Цэргийн албаны үйл ажиллагааны эрх зүйн хэм хэмжээг төрийн хууль тогтоомжоор өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тогтоох;
- ✓ Төрийн хууль тогтоомж, бусад эрх зүйн хэм хэмжээг Зэвсэгт хүчний хэмжээнд мөрдүүлэхэд эн тэргүүнд чиглэнэ.

Зэвсэгт хүчнийг захиргааны удирдлагаар хангах гэдгийг улс орныг батлан хамгаалах талаар төрөөс гаргасан үзэл баримтлал, батлан хамгаалах бодлогын үндэс, хууль эрх зүйн хүрээнд төрийн захиргааны субъектүүд болон батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тодорхой үе шатанд бодлого, төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх үйл ажиллагаа гэж тодорхойлж болох юм.

Зэвсэгт хүчний төрийн захиргааны удирдлагын салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь батлан хамгаалах бодлогын хэрэгжилтэд

төрийн захиргааны төв байгууллагаас хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгч байх асуудал юм.

Зэвсэгт хүчний төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлдэг үндсэн субъектуудын эрх зүйн хэм хэмжээ, тэдний эрх үүргийн уялдаа холбоог тодорхойлоход нийтлэлийн зорилго оршино.

Зэвсэгт хүчний төрийн захиргааны удирдлагын зарим асуудал

Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуулинд "Зэвсэгт хүчний төрийн захиргааны удирдлага" гэж Зэвсэгт хүчинд холбогдох хууль тогтоомжийг мөрдүүлэх, бүрэн эрхийнхээ хүрээнд эрх зүйн хэм хэмжээг тогтоох, хэрэгжилтийг хангах, Зэвсэгт хүчинд иргэний хяналт тавих үйл ажиллагааг... хэмээн тодорхойлсон байдаг.



1 дүгээр зураг. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга



Зэвсэгт хүчний Төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх субъектуудыг Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулинд "Төрийн цэргийн байгууллын төрийн захиргааны удирдлагыг Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, Монгол Улсын Засгийн газар, батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн" хэмээн заажээ.

Түүнчлэн Зэвсэгт хүчний төрийн захиргааны удирдлагыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гэсэн субъектууд хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлнэ. Тэдгээрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх эрх мэдлийн хэм хэмжээг тус бүрд нь авч үзье.

Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчнийг төрийн захиргааны удирдлагаар хангаж буй байдал.

Ерөнхийлөгч нь хууль санаачлагч субъектын нэг бөгөөд Улсын Их Хурлын баталсан хууль, шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих эрхтэй байдаг.

Тэрээр хууль санаачлагчийн хувьд 2001 онд "Үндэсний аюулгүй байдлын тухай" хуулийг, 2015 онд "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс" хэмээх төрийн бодлогын баримт бичгийг, 2016, 2020 онд "Батлан хамгаалах тухай", "Зэвсэгт хүчний тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиудыг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулсан байдаг.

Монгол Улсын Ерөнхийлөгч нь Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн хувьд бүх нийтийн буюу хэсэгчилсэн дайчилгаа зарлах, дайны байдал зарлах тухай шийдвэрийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, цэргийг бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх, байлдааны ажиллагаа эхлүүлэх шийдвэр гаргах, зэвсэгт тэмцлийг ерөнхий удирдлагаар хангах зэрэг онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Түүнчлэн Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх талаар Засгийн газарт чиглэл өгөх, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг Улсын Их Хуралтай зөвшилцөж томилох, улсын болон цэргийн дайчилгааны материаллаг

нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавих зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр хуульд заасан нь Зэвсэгт хүчнийг төрийн захиргааны удирдлагаар хангахад чиглэсэн түүний тодорхой бүрэн эрх мөн.

Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөр, Зэвсэгт хүчний Жанжин штабын стратегийн үндсэн төлөвлөгөөнүүд болон Зэвсэгт хүчний амьдрал, үйл ажиллагааны нийтлэг хэм хэмжээг тогтоосон "Цэргийн нийтлэг дүрэм" Монгол Улсын Ерөнхийлөгчөөр батлагдаж хүчин төгөлдөр болдог.

Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн хувьд "Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрэм"-ийг зарлиг гарган баталж мөрдүүлж байна. Цэргийн цол олгох журам, дээд офицерын цолны зэрэглэлийг Монгол Улсын Ерөнхийлөгч тогтооно.

Ийнхүү Монгол Улсын Ерөнхийлөгч бол Зэвсэгт хүчнийг төрийн захиргааны удирдлагаар хангах өргөн бүрэн эрхийг хэрэгжүүлж буй удирдлагын гол субъект болох нь харагдаж байна

Монгол Улсын Засгийн газар Зэвсэгт хүчнийг төрийн захиргааны удирдлагаар хангаж буй байдал

Улс орны "Батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах"¹ нь Зэвсэгт хүчнийг төрийн захиргааны удирдлагаар хангах Засгийн газрын үндсэн бүрэн эрхэд хамаарч байна.

Засгийн газрын энэхүү үндсэн бүрэн эрх нь Зэвсэгт хүчнийг төрийн захиргааны удирдлагаар хангах талаарх түүний



2 дугаар зураг. Монгол Улсын Засгийн газрын хуралдаан

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2-ын 6 дахь хэсэг



тодорхой бүрэн эрхийг нөхцөлдүүлдэг юм. Эдгээр тодорхой бүрэн эрхийг "Засгийн газрын тухай"², "Батлан хамгаалах тухай"³, "Зэвсэгт хүчний тухай"⁴, "Дайны байдлын тухай"⁵, "Дайчилгааны тухай"⁶ зэрэг Зэвсэгт хүчний байгуулалт, үйл ажиллагааг зохицуулсан хуулиудаар тогтоожээ. Эдгээр хууль тогтоомжуудыг судлан үзвэл улс орны батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх талаар Монгол Улсын Засгийн газрын хүлээсэн тодорхой бүрэн эрхийг дараах байдлаар ангилж болох байна. Үүнд:

1. Улс орны батлан хамгаалах тогтолцоог бүрдүүлэх,
2. Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх гэсэн хоёр үндсэн чиглэлээр авч үзэж болно.

Засгийн газар нь улс орноо батлан хамгаалах тогтолцоог бүрдүүлэх бүрэн эрхийн хүрээнд:

- Улс орныг дайны байдалд шилжүүлэх ерөнхий төлөвлөгөөний төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулах;
- Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгаврыг батлах;
- Улсыг батлан хамгаалах асуудлаар төрийн захиргааны гүйцэтгэх байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх.

Засгийн газар нь Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх бүрэн бүрэн эрхийнхээ хүрээнд:

- Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх арга хэмжээ авах;
- Цэргийн анги, байгууллагыг байгуулах, татан буулгах асуудлыг Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчтай зөвшилцөн шийдвэрлэх;
- Цэргийн анги, байгууллагын байршилтыг тогтоож, батлан хамгаалах хэрэгцээний эзэмшил газрын зөвшөөрөл олгох;
- Улсын болон цэргийн дайчилгааны

материаллаг нөөцийн хэмжээг тогтоож, түүнийг бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг зохион байгуулах;

- Жил бүр цэргийн жинхэнэ албанд татах, дайчилгааны сургууль, цугларалтад оролцуулах хүний тоо, цэрэг татлага явуулах хугацааг Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчтай зөвшилцөн тогтоох;
- Цэрэг, цэрэг–техникийн хамтын ажиллагааны асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд бусад улсын Засгийн газартай хэлэлцээр байгуулах;
- Зэвсэгт хүчнийг зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүнээр хангах арга хэмжээ авах;
- Гадаад улсаас авах цэргийн зэвсэг, байлдааны техникийн төрөл, тоог тогтоох, Улсын Их Хурлын зөвшөөрлөөр санхүүжүүлэх;
- Иргэдийг эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд төрийн бүх шатны болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлж, цэрэг, иргэний харилцааг төлөвшүүлэх;
- Иргэдээс цэргийн үүргээ биелүүлэх хүсэл, сонирхол, эрмэлзлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Зэвсэгт хүчнийг төрийн захиргааны удирдлагаар хангаж буй байдал

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд улс орныг батлан хамгаалах бэлтгэл, бэлэн байдлын асуудлыг эрхэлнэ.

Батлан хамгаалахын сайд нь Засгийн газрын гишүүний хувьд улс орныг батлан хамгаалах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах бөгөөд батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох, зэвсэгт хүчнийг бэхжүүлэх саналыг Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулах, Ерөнхий командлагчид өргөн мэдүүлнэ. Батлан хамгаалах асуудал

² Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 13 дугаар зүйл

³ Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1.2, 13 дугаар зүйл

⁴ Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 12 дугаар зүйл.

⁵ Монгол Улсын Дайны байдлын тухай хуулийн 10, 15 дугаар зүйл.

⁶ Монгол Улсын Дайчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйл.



3 дугаар зураг. Монгол улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд

эрхэлсэн Засгийн газрын гишүүн Зэвсэгт хүчнийг төрийн захиргааны удирдлагаар хангах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Зэвсэгт хүчнийг:

- ✓ Бодлогын удирдамжаар хангах;
- ✓ Үйл ажиллагааг нь зохицуулах;
- ✓ Бодлогын хэрэгжилтэд хяналт тавина.

Зэвсэгт хүчнийг бодлогын удирдамжаар хангах чиг үүргийнхээ хүрээнд Батлан хамгаалахын сайд Зэвсэгт хүчний байгуулалтын нийгэм, эдийн засаг, эрх зүйн үндсийг хангах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг зохион байгуулахаас гадна Зэвсэгт хүчнийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах журам тогтоож, удирдамж гаргана. Түүнчлэн цэргийн нийтлэг дүрмүүдийн төслийг боловсруулж батлуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барих, цэргийн шинжлэх ухаан, технологийн дэвшлийг хангах, Зэвсэгт хүчнийг зэвсэг, цэргийн техникээр нөхөн хангах, шинэчлэн сайжруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, батлан хамгаалах асуудлаар бусад улстай хамтран ажиллах талаар Засгийн газраас олгосон эрхийн хүрээнд хэлэлцээр байгуулах, батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төслийг Засгийн газарт оруулах, батлагдсан төсвийг хуваарилах зэрэг цэргийн бодлого, төрийн захиргааны удирдамжийн чанартай өргөн цар хүрээтэй бүрэн эрхийг хэрэгжүүлж байна.

Батлан хамгаалахын сайд Зэвсэгт хүчний үйл ажиллагааг зохицуулах бүрэн эрхийнхээ хүрээнд офицер /дээд офицероос бусад/, ахлагчийн албан тушаалын ангилал, цолны зэрэглэл,

тэдгээрийн алба хаах журмыг тогтоох, гэрээгээр цэргийн алба хаах иргэнийг сонгон шалгаруулж элсүүлэх журам батлан мөрдүүлэх, батлан хамгаалах салбарын боловсон хүчнийг сургаж бэлтгэх, цэргийн анги, байгууллагын үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг шинээр авах, шилжүүлэх, данснаас хасах, устгах асуудлыг шийдвэрлэх гэх мэт цэргийн албаны харилцаа, хэм хэмжээг тогтооход чиглэсэн удирдлага, зохицуулалтын олон бүрэн эрхийг эдэлнэ.

Батлан хамгаалахын сайд цэргийн бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж үнэлгээ өгөх бөгөөд үүний тулд батлан хамгаалах хууль тогтоомж, батлан хамгаалах асуудлаар Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон өөрийн шийдвэрийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид шалган танилцаж, биелэлтийг хангах талаар үүрэг, даалгавар өгч гүйцэтгүүлнэ.

Эдүгээ Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлд Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн, тайван цагийн бүтэц, бүрэлдэхүүнээрээ байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх чадвар бүхий цэргийн анги, салбарыг байгуулах гэж заажээ.

Ийнхүү батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн бол Зэвсэгт хүчнийг төрийн захиргааны удирдлагаар хангах үүрэгтэй үндсэн субъектын нэг болж байна.

Дүгнэлт.

Монгол Улсын Засгийн газар нь зэвсэгт хүчний амьдрал, үйл ажиллагааны олон чухал хэм хэмжээг хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тогтоодог. Тухайлбал цэргийн алба хаагчийн албаа хаах гол баталгаа болж буй албан тушаалын сарын үндсэн цалингийн сүлжээ, цэргийн цолны, мэргэжлийн зэргийн, түүнчлэн төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийн хувь хэмжээг тогтоохын дээр цэргийн хоногийн хоолны болон дүрэмт хувцас, хэрэглэлийн нормыг баталж мөрдүүлдэг.

Батлан хамгаалахын сайд нь Батлан хамгаалах яамыг тэргүүлж, үүнтэй холбогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлж байна. Удирдлагын шинэ тогтолцоогоор



Батлан хамгаалах яам нь урьдын цэргийн яамны чиг үүргээсээ ангижирч, тодруулж хэлбэл зэвсэгт хүчнийг цэргийн мэргэжлийн удирдлагаар шууд хангах чиг үүрэг хүлээхээ болж, улс орныг батлан хамгаалах бодлого, үйлжиллагааг нэгтгэн төлөвлөх, уялдуулан зохицуулах цоо шинэ чиг үүрэг хүлээх болов. Өөрөөр хэлбэл Батлан хамгаалах яам дан ганц цэргийн асуудал эрхэлж байснаа удирдлагын шинэ

тогтолцоогоор эх орноо батлан хамгаалах улс орны бэлтгэл, бэлэн байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн цогц арга хэмжээний стратегийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг төлөвлөн зохион байгуулах өргөн цар хүрээтэй чиг үүрэг хүлээсэн төрийн захиргааны төв байгууллага болон шинэчлэгдэж байна.

Ашигласан материал:

1. Дашзэвэг Ц., Цэргийн удирдлагын үндэс. УБ., 2003;
2. Улаанхүү Ч., Цэргийн удирдлага. УБ., 2005;
3. Батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны удирдлага /Эрдэм шинжилгээний төслийн тайлан/. ҮБХИС. БХЭШХ. УБ., 2012;
4. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл., ЭШХ-ийн фонд., УБ, 2008;
5. <https://www.legalinfo.mn/law/details/367?lawid=367>;
6. <https://www.legalinfo.mn/law/details/11382?lawid=11382>.



ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НИЙГМИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ҮЗҮҮЛЭХ ЗАРИМ НӨЛӨӨЛӨЛ



Д.ИДЭШНОРОВ /УБХИС-ийн Сургалтын хэлтсийн Цэрэг-стратегийн бэлтгэл, шаталсан сургалт хариуцсан мэргэжилтэн, доктор (Ph.D), хошууч/

АНУ-ын Батлан хамгаалах хэлний хүрээлэнд "Гадаад хэлний сургалтыг төлөвлөн зохион байгуулах" богино хугацааны менежментийн сургалт, АНУ-ын Батлан хамгаалах хэлний хүрээлэнгийн "Англи хэлний багшийн үндсэн дамжаа" ХБНГУ дахь "Жеорж Маршалл" "Аюулгүй байдал судлалын төв" -Аюулгүй байдлын үндсэн дамжаа.

Түлхүүр үг: Нийгмийн сэтгэл зүй, тогтворгүй байдал, сөрөг хүчин зүйлс, ёс зүй, мэдээллийн урсгал, дотоод аюулгүй байдал

Key words: Internal security, social psychology, social morality, negative impact on social psychology, social instability, information-psychological attacks

Үндэсний аюулгүй байдлыг түүнд учирч болох аюул заналын эх үүсвэрийн оршиж байгаа байрлал болон улс хоорондын нутаг дэвсгэрийн хил хязгаартай уялдуулан дотоод ба гадаад аюулгүй байдал гэж ангилдаг бөгөөд ийм ангилал нь үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлыг шийдвэрлэх аливаа үзэл баримтлалын хандлагыг нарийн тодорхой ангилахад үлэмж ашиг тустай байхын зэрэгцээ дотоод болон гадаад аюулгүй байдлыг хангах арга, хэлбэр, арга зам хоорондоо тэс өөр байдагтай холбоотой, түүнчлэн дотоод, гадаад аюулгүй байдал нь харилцан хамааралтай бие биендээ нөлөөлдөг зүй тогтолтой байдгийг судлаач онцолсон байна¹. Үндэсний аюулгүй байдлын ерөнхий бүдүүвчийг зураг дээр харууллаа.



Үндэсний аюулгүй байдлын ерөнхий бүдүүвч

Энэ хамаарал зүй тогтлын үүднээс нийгмийн сэтгэл зүйг авч үзвэл тэр үндэсний аюулгүй байдлын дотоод

аюулгүй байдлыг хангахад амин чухал үүрэгтэй бөгөөд түүнд нөлөөлөх хүчин зүйлс нь дотоод, гадаад аюул заналтай аль аль нь холбоотой байдаг. "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд" дотоод аюулгүй байдлын үндсийг "Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллагыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, **нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг** хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн" гэж тодорхойлсны зэрэгцээ нийгмийн сэтгэл зүй түүний хангахад гүйцэтгэх үүргийг "Нийгмийн ёс суртахуун, сэтгэл зүйн төлөвшил, үнэт зүйлсийн нэгдмэл байдлыг хангах нь **үндэсний аюулгүй байдал, эв нэгдэл, зөвшилцлийг хангах суурь болно**"² гэж илэрхийлсэн байдаг.

Нийгмийн ёс суртахуун, сэтгэл зүйн хүрээнд улс төрийн алдаа завхрал, эдийн засгийн доройтол, ажилгүйдэл, ядуурал, хүнс тэжээлийн дутагдал, хар тамхинд донтох явдал, боловсрол, эрүүл мэндийн уналт, мэдээлэл-сэтгэл зүйн дайралтын өртөлт, экологийн сүйрэл, соёл иргэншил,

¹ Уржин. О.Үндэсний аюулгүй байдлын онолын зарим асуудал. Монгол Улсын аюулгүй байдал: онол арга зүй, орчны шинжилгээ. БХЭШХ.,УБ., 2019,т. 216, 25-35,25.

² "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.3 дэх заалт мөн 3.3.3.2, 3.3.3.3, 3.3.3.4, 3.3.4 дэх заалтууд, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт



удмын сангийн бохирдол зэрэг олон асуудал байна.

Үндэсний сэтгэл зүй төлөвшихөд нөлөөлөх хүчин зүйлсийг эерэгээр шийдэх арга хэмжээ талаас нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд дараах заалтууд орсон байна. Үүнд:

- "Эх орон үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх бодлогыг төр, иргэн хэвлэл мэдээллийн салбар хамтран хэрэгжүүлнэ";
- "Үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшлийн баталгаа болсон үндэсний эв нэгдэл, нийгмийн зөвшилцлийг бэхжүүлж, улс орон нийгмийг хагалан бутаргах дотоодын зөрчил, тэмцэлд хүргэх аливаа үйл явдлаас урьдчилан сэргийлнэ";
- "Иргэдийг үндэс угсаа, шашин шүтлэг, үзэл бодлоор ялгаварлан гадуурхах, нутгархах үзлийг дэврээх, энэ шалтгаанаар хүний эрх, эрх чөлөөг зөрчих, улмаар үндэсний эв нэгдлийг сарниулж, дотоодын тогтворгүй байдалд хүргэж болох илрэлтэй хатуу тэмцэл хийнэ";
- "Ардчилсан тогтолцооны тулгуур болох улс төрийн намуудын төлөвшил, дотоод ардчиллыг дэмжиж, улс үндэстэн хийгээд нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг нь өндөржүүлнэ. Үндэсний язгуур эрх ашгийн үүднээс улс төрийн намын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зөвшилцөлд хүргэх механизмийг хөгжүүлнэ";
- "Төрийн бодлого боловсруулах, төрд хяналт тавихад төрийн бус байгууллагын тэгш оролцоо, зөвшилцлийг хангах замаар иргэний нийгмийн төлөвшлийг дэмжинэ. Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, төр-иргэний нийгмийн хамтын ажиллагааны бүтээлч арга, хэлбэрүүдийг

хөгжүүлнэ";

- "Хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлагатай мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана";
- "Нийгэмд хууль ёс, дэг журам, сахилга хариуцлага суларч эмх замбараагүй байдал бий болохоос сэргийлнэ";

гэсэн заалтуудыг дурдаж болох юм.

Өнөө үед дээрх заалтуудаас хамгийн их анхаарал татсан: "**Хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлагатай мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана**"; гэсэн заалтын хүрээнд авч үзье.

Нийгмийн сэтгэл зүйн тогтворгүй байдал нь улс орны улс төр, эдийн засаг, ажилгүйдэл ядуурал, ёс зүйгүй мэдээллийн урсгалаас ихээхэн шалтгаалдаг. Иймд нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэхэд төрийн зүгээс ухаалаг бодлогоор оролцох шаардлага бодитой бий болоод байна. Уг үзэл баримтлалын дагуу хийж гүйцэтгэсэн ажил, авсан арга хэмжээ төр засгийн болон судалгааны байгууллага, судлаач, эрдэмтдийн түвшинд байгаа хэдий ч анхаарал татсан, тулгамдсан асуудал цөөнгүй байсаар байна.

Тухайн улсын хүн амын оюун санаа, ертөнцийг үзэх үзэл, нийгмийн сэтгэл зүйд гаднаас үзүүлж буй үл ажиглагдах эрсдэл, нөлөөний талаар судлаачид өөр өөрийн байр суурийг илэрхийлсэн байдаг. Тухайлбал, "Сэтгэл зүйн түрэмгийллийн талаар" Сэтгэл зүйн түрэмгийлэл гэдэг нь түрэмгийлэгч улс зорилтот улсынхаа нийгэм, улс төрийн тогтолцоонд мэдээлэл-харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр нь дамжуулан өөрсдийн үнэт зүйлс, үзэл суртлын нөлөөгөө бэхжүүлэх, хяналт тогтоох, улмаар нийгмийн сэтгэлзүйд нь нөлөөлөн зорьсон (хүссэн) хэв загвартаа уусгах замаар ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх ажиллагааг хэлнэ" гэж Оросын судлаач А.В.Манойло тодорхойлсон³ байдаг.

³ МанойлоА. В. Роль культурно-цивилизационных моделей и технологий информационно-психологического воздействия в разрешении международных конфликтов, 2009



Иймд нийгмийн сэтгэл зүйн үндэсний аюулгүй байдалд үзүүлж буй нөлөөллийн талаарх олон улсын туршлага, сургамжаас үзэхэд нийгмийн сэтгэл зүйг мэдээллийн янз бүрийн эх үүсвэрээр дамжуулан бусниулж, үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх дараах онцлогууд гарч байна. Жишээ нь:

- Бусад улсын үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгсэл, медиа орон зайд нялзаан түгээж буй үнэт зүйл, үзэл суртлын түрэмгийлээ өөрийн орны хүн амын нийгмийн ухамсарт суулгах;
- Мэдээллийн түрэмгийллийн үед бай нь болсон улс орон дахь улс төрийн үйл явц ба улс төрийн дэглэмийн үр дүнгийн талаарх өөрт ашигтай тайлбарыг бүрдүүлж цацах;
- Мэдээллийн довтолгоонд өртөгч улсын хүн амд төрийн удирдлагын байгууллага, үндэстний улс төрийн элитийн нэр хүндийг гутаах замаар тэдэнд итгэх итгэлийг алдагдуулах;
- Үндэсний ашиг сонирхлыг баримтлагч төрийн бодлогыг дэмжигч тоглогчдын мэдээлэл харилцааны орон зайг, нийгмийн үзэл бодол бүрдүүлэх үйл явцаас шахан зайлуулах;
- Улс төрийн уламжлалт үнэт зүйл, нийгмийн тогтсон үзэл бодлыг задлан нурааж, оронд нь гадаадын хувилбарыг суулгах, өөрөөр хэлбэл үндэсний үнэт зүйл-оюун санааны орон зайг өөрчлөн кодлох;
- Нийгмийн анхаарлыг түрэмгийлэгч улсад ашигтай нийгэм улс төрийн сэдэвт мэдээлэлд чиглүүлэх замаар эрх баригч улс төрийн дэглэмд шаардлагатай сэдвийг бүрдүүлэх;
- Виртуал орон зайд эсэргүүцлийн сүлжээний нийгэмлэг, нийгмийн үзэл бодолд улс төрийн виртуал лидерүүд бүрдүүлэх;
- Эсэргүүцэгч сүлжээний нийгэмлэгээс төрийн удирдлагын байгууллагуудад нийгмийн дарамт шахалт үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх "бай" болсон улс болон түрэмгийлэгч улсын хүн амд "хувьсгалт нөхцөл

байдал"-ын виртуал сэтгэгдэл төрүүлэх;

- Хүн амд эсэргүүцлийн зан авирын олон нийтийн загвар бүрдүүлэх;
- Олон нийтийг интернет орон зайд дайчлах, тэдний эсэргүүцлийн идэвхийг олон нийтийн эсэргүүцлийн явуулгын хэлбэрээр илрэх оффлайн орон зайд шилжүүлэх;
- Медиа орон зай дахь эсэргүүцлийн идэвхжлийг "ардын хувьсгал" хэлбэрээр ухуулан сурталчлах, тайлбарлан таниулах гэх зэрэг нийгмийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх оролдлогууд хийгдэж байна.

Мэдээллийг "зэвсэг" болгон ашиглах үеэс эхлэн "мэдээллийн дайн" гэсэн нэр томъёо бий болсон. Мэдээллийн дайныг явуулахад доорх аргуудыг хэрэглэдэг байна. Үүнд:

Суртал ухуулга, сурталчилгаа⁴:

Суртал ухуулга, сурталчилгаа бол мэдээллийн дайны салшгүй хэсэг гэж үздэг бөгөөд улс төрийн харилцааг тогтворгүй болгож, сөргөлдөөнийг бий болгоход ашигладаг. Улс төрийн сөргөлдөөний үед суртал ухуулга, сурталчилгааг ашиглан иргэний нийгэмд зөрчилдөөнийг үүсгэдэг. Мөн шашин, үндэстэн ястны хооронд хагарал үүсгэх зорилгоор өдөөсөн зарим үйл ажиллагаа нь тухайн орны улс төрийн системийг нураах хэмжээнд ч хүргэдэг.

Хуурамч мэдээлэл:

Хуурамч мэдээлэл ашиглан хуурч төөрөгдүүлэх ажиллагааны эцсийн зорилго нь эсрэг талыг өөрийн талд ашигтай шийдвэр гаргуулах, эсвэл ашиггүй шийдвэр гаргуулахгүй байхад оршдог.

Зориуд зохион байгуулсан арга ажиллагаа: Тусгай ажиллагаа, хуйвалдаан, мэдээллийн орчинг эзлэн авах, олон нийтийн оюун санааг эзэмдэх, тархи угаах "манипуляц", үзэл суртлын хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, хорлон сүйтгэх суртал ухуулга, өнгөт хувьсгал гэх зэргийг онцолж болно.

Кибер халдлага: Мэдээллийн дайны онцлог бол Кибер халдлагыг өргөн ашиглах, нийгмийн сүлжээг идэвхтэй ашиглах, бусад орны хэвлэл мэдээллийн

⁴ МанойлоА. В. Роль культурно-цивилизационных моделей и технологий информационно-психологического воздействия в разрешении международных конфликтов 2009



системийг хяналтдаа авч зорилтот мэдээллийг цацах зэргээр нийгмийн сэтгэлзүйд сөргөөр нөлөөлөх олон аргыг хэрэглэдэгт оршино.

Космополитизм: Космополитизмийг үндэсний тусгаар тогтнол, үндэсний соёл урлаг, уламжлал, ёс заншлыг үгүйсгэх, устгах зорилгоор гаргаж ирсэн урсгал гэж ойлгож болох юм. Мэдээллийн дайн ба космополитизм хоорондоо тасралтгүй холбоотой. Дэлхийд шинэ дэглэм тогтоох үзэл суртлын тэмцэл явагдаж байгаа өнөө үед улс орнуудыг задлан бутаргах, өөрсдийн ноёрхлыг тогтооход космополитизм, абстракционизм зэрэг барууны урсгал хүчтэй зэвсэг болсон. Жишээ нь, космополитизм бол урлагийн салбарт хүчтэй нөлөөлдөг хэлбэр юм.

Авангардизм: Энэхүү урсгал нь үндэсний уламжлалыг доромжлох, гутаах, урлагаас ёс зүйг салгах, хайр сэтгэл аугаа үзэл санааг үгүйсгэн, эрэгтэй эмэгтэй хүний харилцааг амьтны харилцааны хэлбэртэй төстэй мэтээр дүрслэх болсон.

Сионизм: НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1975 оны 30 дугаар чуулганаас гаргасан тогтоолд сионизмийг "арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл" гэж тодорхойлж байжээ.

Алкоголизм: "Согтуу ард түмнийг удирдахад хялбар" гэж Оросын нэгэн эрх баригч хэлж байжээ. Архичин ард түмэнд ирээдүй үеийн асуудал болон улс орон ямар замаар явах нь хамаагүй байдаг.

Дүгнэлт. Дэлхий нийтийг даяарчлалд дуудаж, холбогч гүүр нь болж, цаг хугацааг газрын байршил, соёл, иргэншлээс үл хамааран секунд, минутаар товчлох боломжийг олгож буй зүйл болох мэдээлэл, түүнийг дамжуулагч технологийн дэвшил хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг монголын залуучууд тойрч гараагүй. Харин ч улам бүр ойртон нөхөрлөж, бүх талын мэдээлэл хүлээн авах, түгээх, төлөвших болсон. Өнөөдөр мэдээлэл технологийн харилцаанд нэвтрэх боломж чөлөөтэй болсон нь сайшаалтай хэдий ч манай орны хувьд зарим талаар нийгмийн сөрөг үзэгдлүүд бий болоход нөлөөлж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдэг тухайн үеийн нийгмийн оюун санааны хэрэгцээ шаардлагын илэрхийлэл байж,

олон түмний санаа бодолд нөлөөлөхүйц мэдээллээр цэнэгжүүлэн тэжээгч, оюуны болоод нийгмийн харилцааны чухал хэрэглэгдэхүүн байдаг. Өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр гадаад соёлын ухуулга сурталчилгаа газар авч, үдэш бүрийн эх хэл дээрх телевизээр гадны олон ангит кино тасралтгүй шинээр гарч, түүгээр ч зогсохгүй хүн бүхэн гадаад оронд гарах, сайхан амьдрах тухай чихэнд хоногштол ярилцаж, бие биедээ нөлөөлсөөр байгаа нь эх орон, үндэс угсаагаараа бахархах үзлийг дарангуйлж байна.

Мэдээллийн энэхүү чөлөөт хөгжлийн явцтай зэрэгцэн ялангуяа залуу үеийнхээ оюун санааны дархлааг бий болгох нийгмийн бодлого, оновчтой арга барилыг хэрэгжүүлэх шаардлагатай байгаа юм.

Нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн бодлогын түвшинд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Эх оронч үзлийг төлөвшихөд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүч чадлыг ашиглах, редакцийн зүгээс ийм чиглэлийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлого боловсруулахад нь сэдэлжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Залуучуудаас хэвлэл мэдээллийн хамгийн их сонирхдог мэдээ, нэвтрүүлэгт эх оронч үзэлтэй холбоотой боловсрол танин мэдэхүйн чанартай нэвтрүүлгийн агуулгыг өөрчлөх, тоог нэмэх;
- Сэтгүүлчдийн эрх үүрэгт эх оронч хандлагыг төлөвшүүлэх, ур чадварыг сайжруулах чиглэлийг мэргэжилтэн бэлтгэх шатнаас нь эхлэн сургалтын хөтөлбөрт оруулж өгөх;
- Үзэгчдийн хамгийн ихээр үзэх дуртай нэвтрүүлэгт эх орноороо бахархах, үнэ цэнийг мэдрүүлсэн өнгө аяс оруулж өгөх, харин эх орноо хөгжүүлэх чиглэл бүхий зарим нэвтрүүлгийг хэлбэрийн хувьд нь хөгжөөнт цэнгээнт маягтай болгох;
- Сонин хэвлэлээр ард олныг эх орноо хайрлах үзлийг өргөнөөр



сурталчлах;
Өөрөөр хэлбэл эх орныхоо талаар
хэт шүүмжилсэн гутранги агуулгатай зүйл
нийтлэхээс зайлсхийж уриалга гаргах

төрийн зүгээс урамшуулан дэмжих зэрэг
дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэх
саналыг хүргүүлж байна

Ашигласан материал:

1. Үржин.О.Үндэсний аюулгүй байдлын онолын зарим асуудал. Монгол Улсын аюулгүй байдал: онол арга зүй, орчны шинжилгээ. БХЭШХ.,УБ., 2019,т. 35,25-25 ,216.
2. "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.3 дэх заалт мөн ,3.3.3.3 ,3.3.3.2 3.3.4 ,3.3.3.4 дэх заалтууд, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт.
3. Манойло А. В. Роль культурно-цивилизационных моделей и технологий информационно-психологического воздействия в разрешении международных конфликтов.М., 2009.



МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ЗАМ



Ж.ЖАМСРАНДОРЖ /ҮБХИС-ийн БХУА-ийн стратегийн төвийн ахлах багш, хурандаа/

2001 онд БХИС-ийг "Хилийн албаны ажилтан-Эрх зүйч" мэргэжлээр, 2017 онд ОХУ-ын ЕЦА-ийг "Цэргийн анги, нэгтгэлийн удирдлага" мэргэжлээр тус тус төгссөн. Цэргийн ухааны магистр, докторант.

Түлхүүр үг: Цэргийн удирдлагын автоматжуулсан систем, кибер аюулгүй байдал, удирдлагын төв

Key words: Military management automatic system, cyber security, Management center

XX зууны төгсгөл, XXI зууны эхэн үеэс дэлхий даяар мэдээллийн технологийн салбар түргэн хурдацтай хөгжиж, Монгол Улс ч мөн цаг үеэсээ хоцорсонгүй.

Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газраас 2019 онд гаргасан судалгаагаар дэлхийд гар утас хэрэглэгч 5.1 тэрбум, интернет хэрэглэгч 4.3 тэрбум, сошиал мэдээ хэрэглэгч 3.4 тэрбум, гар утсаар сошиал мэдээ хэрэглэгч 3.4 тэрбум хүн байгаа бол манай улсад гар утас хэрэглэгч 3.8 сая, үүнээс ухаалаг утас хэрэглэгч 2.4 сая, интернет хэрэглэгч 2.9 сая хүн байна. Энэ нь хүн амын тоотой харьцуулахад **мэдээллийн технологи**¹ манай улсад эрчимтэй хөгжиж байгааг илэрхийлж буй юм.

Мөн интернет хэрэглэгч нэг иргэн сард дунджаар 5 сэтгэгдэл бичиж, 16 пост лайк дарж, 3 пост шэйр хийж, 12 сурталчилгааны мэдээлэл үздэг гэсэн тоон үзүүлэлт гарчээ.

Энд анхаарал татаж буй зүйл нь дээрх тоон мэдээллийг бүрдүүлэхэд тодорхой хувь нь төрийн байгууллага, түүний алба хаагчдын тоон үзүүлэлт байгаа явдал юм. **Өөрөөр хэлбэл** төр, төрийн байгууллагууд, төрийн алба хаагчид идэвхтэй хэрэглэгч төдийгүй харилцаанд орохдоо мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, дижитал ертөнцөд зөв ажиллаж, амьдрахыг шаардаж буй дохио сануулга юм.

Ялангуяа төрийн цэргийн болоод

тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд, тэдгээрийн алба хаагчдын мэдээллийн аюулгүй байдал нь анхаарал татаж байна. Хэдийгээр гар утас, интернет хэрэглэх, мэдээллийн технологийн техник хэрэгсэл, програм хангамжтай ажиллах нь хувь хүн (ажилтан) болоод байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцэж буй боловч түүний мэдээллийн аюулгүй байдлыг тэдгээрт (хувь хүн, байгууллага) найдан орхих нь эрсдэл дагуулж буй бөгөөд үүнийг төр, засгийн түвшинд цогцоор авч үзэн, судалж, шийдвэрлэх нь чухал.

Цаашилбал төрийн цэргийн байгууллагуудын хэмжээнд авч үзэн, кибер цэрэгтэй болох замаар нэн даруй шийдвэрлэх цаг үеийн шаардлага гарч байна.

Ингэхдээ орчин үеийн чиг хандлагыг судалж, тэдгээртэй ижил түвшний технологийн шийдэл, хамгаалалтыг хийх ёстой бөгөөд өнөөдөр АНУ, Франц, ОХУ, БНХАУ нь энэ салбарт тэргүүлэх байр суурьтай оролцож байна. Тухайлбал, АНУ нь 1960 оноос цэргийн **удирдлагын автоматжуулт**²-ыг хөгжүүлж "С" системд тулгуурлан хөгжүүлж ирсэн бөгөөд өнөөдөр C4ISR түвшин буюу Computer (компьютер), Control (хяналт), Command (удирдлага), Communication (холбоо) Intelligence (тагналт), Surveillance and Reconnaissance (тагнан туршуулын хяналт) хүрээнд удирдлагын автоматжуулсан систем болгон ашиглаж байна.

¹ Мэдээллийн технологи гэдэг нь Америкийн Мэдээллийн Технологийн Холбооны (ИТАА) тодорхойлсоноор "Компьютер дээр суурилсан мэдээллийн систем, програм хангамж болон техник хангамжийн дизайн, хөгжүүлэлт, хэрэгжүүлэлт, хангамж болон удирдлагыг судлахыг хэлнэ"

² Мэдээлэл, тооцооллын техник хэрэгслийг ашиглаж, цэргийг удирдах байгууллагын ажлыг хөнгөвчлөх үйл ажиллагааг цэргийн удирдлагын автоматжуулалт гэнэ.

Энэхүү систем нь жишээ нь C2 байвал Command (удирдлага)-Control (хяналт) эсвэл Communication (холбоо, мэдээлэл) – Computer (компьютер) эсвэл бүр C3 Command (удирдлага) – Control (хяналт) – Communication (холбоо, мэдээлэл) байж болох буюу өөрөөр хэлбэл удирдлага-хяналт, холбоо мэдээлэл, компьютер, холболт зэргийг автоматжуулсан байж болно гэх мэтчилэн тухайн нэгжийн эсвэл ажиллагааны онцлогт тааруулж автоматжуулалтыг зохион байгуулж болдгоороо давуу талтай байдаг.

Мөн эсрэгээр энэ нь халдлагад өртөх магадлалаа нэмж байдаг.

Орчин үеийн чиг хандлага нь улс орнууд цэргийн үйл ажиллагаа бүхий бүх нэгжүүддээ нэгдмэл удирдлагын төвүүдийг байгуулж байна.

Удирдлагын төвийн үйл ажиллагааны амин сүнс нь өөрийн болоод тухайн байгууллагын алба хаагчдын сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал³ бөгөөд байгууллагын сүлжээний орчинд боловсруулагдаж буй бүх төрлийн мэдээллийг найдвартай хамгаалах зайлшгүй шаардлагатай.

Ингэхдээ бие даасан үйлдлийн систем хөгжүүлэх болон тусдаа интранет сүлжээ үүсгэх нь илүү найдвартай гэж үздэг.

ОХУ-ын Касперский агентлаг нь 2018 онд дэлхийн улс орнууд дахь цэргийн удирдлагын төвүүд рүү хийгдэх халдлагууд ихээр нэмэгдэж буй талаар болон Монгол улс нь Кибер аюулгүй байдлын индексээр дэлхийн 164 орноос Этиоп, Афганистан, Сирийн дараагаар 103 дугаарт жагссан талаар илтгэсэн.

Дашрамд дурдахад манай улс руу 2013 онд "Хааны эрэлд" олон улсын хамтарсан сургуулийн үеэр халдлага хийх гэсэн оролдлого болон 2014 онд хамгийн их вирус тархсан 10 улсын тоонд орсон, 2017 онд төрийн албан хаагчдын цахим шуудан ихээр халдлагад өртсөн зэрэг нь кибер халдлагад өртөх хамгийн өндөр эрсдэлтэй орнуудын тоонд Монгол улс тооцогдож байна.

Иймд төр, ялангуяа **төрийн цэргийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг нэгдсэн удирдлагын төвүүд байгуулах замаар хангаж**, улмаар үндэсний аюулгүй байдлын мэдээллийн нэгдмэл аюулгүй байдлыг хангах учиртай.

Энэ талаар үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын "3.6. Мэдээллийн аюулгүй байдал: Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн" гэж тусгасан нь энэхүү чиг үүргийг төрийн оролцоотой хэрэгжүүлэх нь зохистой болохыг заасан юм.

Ингэхдээ улс эх орны хэмжээнд системчилж, бага нэгжээс дээд шатны нэгж рүү, алба хаагчаас байгууллагын бүтэц рүү, төрийн цэргийн байгууллагаас Үндэсний аюулгүй байдлын зөвлөл рүү гэх мэтээр босоо шугамаар, босоо удирдлагаар асуудлыг шийдвэрлэх нь зохистой юм. Өөрөөр хэлбэл эхнээс нь систем байдлаар нэгдмэл цогц хяналтад Монгол улсын мэдээллийн аюулгүй байдлыг хангах учиртай.

Мэдээллийн систем⁴ бол биднийг хүрээлэн буй системүүдийн нэг төрөл бөгөөд түүний бусад системүүдээс ялгарах гол онцлог бол зөвхөн өгөгдөл мэдээлэлтэй ажилладаг. Иймээс мэдээллийн системийг ерөнхий байдлаар нь байгууллага, хүний үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, шийдвэр гаргалтыг үр ашигтай, оновчтой байлгах, нөөцийг үр ашигтайгаар зөв хуваарилах гэсэн зорилгод хүрэхийн тулд хүрээлэн буй орчноосоо өгөгдөл, мэдээллийг хүлээн авч боловсруулаад тодорхой мэдээллийг нь буцаан өгдөг.

Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд бүх төрлийн мэдээ, мэдээлэлтэй харьцаж, боловсруулт, үнэлэлт, дүн шинжилгээ хийдэг тул нэгдмэл мэдээллийн удирдлагын автоматжуулсан

³ "Мэдээллийн аюулгүй байдал" гэдэгт гадны болон дотоодын сөрөг нөлөөллөөс үл хамааран мэдээлэл, түүнийг дэмжих дэд бүтцийн Нууцлагдсан байдал (confidentiality), Бүрэн бүтэн байдал (Integrity), Хүртээмжтэй байдал (Availability)-ийг хангаж, өөрийгөө хөгжүүлэх чадвараа хадгалж буй мэдээллийн орчны тогтвортой байдлыг ойлгоно.

⁴ Мэдээллийн систем нь хүн, технологи болон өгөгдөл мэдээллийг цуглуулах, дамжуулах, хадгалах, сэргээх, төрөл бүрийн хэлбэрээр дүрслэх, гаргах үйл ажиллагаа буюу процессууд -ын нэгдэл юм.



системийн тусламжтай үйл ажиллагаа явуулах нь илүү болохыг бусад орны туршлагаас харж болно.

Мөн жишээ татахад 2014 онд ашиглаж эхэлсэн ОХУ-ын Үндэсний батлан хамгаалах удирдлагын төв нь 6 хэлээр орчуулдаг хиймэл оюун⁵ бүхий тусгай зориулалтын систем ойролцоогоор секундэд 50 ширхэг Лениний номын сантай тэнцэх хэмжээний мэдээллийг боловсруулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тэд уг төвөө Пентагон эсвэл Францын Балар дахь удирдлагын төвөөс нэг дахин илүү гэж үздэг. Оросын арми дэлхийд хамгийн хүчтэй цэргийн супер компьютер ашиглаж байна. Ажиллах механизм нь жил жилээр идэвхээ алдахгүй хүчин чадал нь нэмэгдэж байхаар суурилагдсан зэрэг нь хөрш зэргэлдээ оршин байдаг улсын хувьд биднээс энэ чиглэлд үйлдэл хийхийг, цаг үеийн зайлшгүй шаардлагын дагуу цэргийн удирдлагын автоматжуулсан системийг цогц байдлаар нэвтрүүлэх асуудал зүй ёсоор тавигдаж байна.

Мэдээлэл, холбооны техник хэрэгслийн хөгжил нь цэргийн урлагт томоохон өөрчлөлт оруулж байна. Програмын удирдлагат сансрын холбооны болон богино, хэт богино долгионы радио станцууд, аппаратурууд, оптик кабелийн шугам сүлжээ зэргийг Зэвсэгт хүчний (төрийн цэргийн байгууллын Ж.Ж) тогтолцоонд нэвтрүүлснээр цэргийн стратеги, оператив, тактикийн түвшинд байлдааны ажиллагааг олон улсын болон өөрийн орны дэд бүтэц, холбооны сүлжээг ашиглан, удирдлагын байр дээрх холбооны аль ч хэрэгслээр өөр хоорондоо холбогдож, байлдааны тушаал (удирдамж, шийдвэр Ж.Ж) захирамж, цагийн байдлын өөрчлөлт, ажиллагааны хувилбар, дайснаас үзүүлэх бүх төрлийн

нөлөөллийн тухай мэдээлэл, команд дохиог компьютерийн сүлжээг ашиглан дамжуулах, хүлээн авах бололцоотой болж, цэргийн холбооны хүчин чадлыг эрс нэмэгдүүлж, шуурхай, тасралтгүй, тогтвортой, уян хатан, өндөр нууцлалтай ажиллах боломжийг нэмэгдүүлсээр байна⁶.

Ийнхүү үндэсний хэмжээнд асуудал дэвшигдсэн тохиолдолд практикт тулгардаг бэрхшээл нь

Нэгдүгээрт, боловсон хүчний асуудал юм. Энэ чиглэл нь дотроо олон салбарлах бөгөөд ялангуяа газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтнүүд нь ихэвчлэн энгийн эсвэл гадаадад мэргэжил эзэмшсэн байдаг. Энэ нь манай улсын цэргийн сургалтын тогтолцоо, сургалтын бодлоготой хараахан холбогдож чадаагүй байна.

Хоёрдугаарт, програм хангамжтай холбогдоно. Харьцангуйгаар энэ асуудал шийдвэрлэгдэх боломжтой авч, мэдээллийн аюулгүй байдал түүнтэй холбоотой дэд бүтэц нь ихээхэн хүндрэл дагуулдаг.

Гуравдугаарт, технологийн шийдэл, техник хангамжийн асуудал. Дотоодын үйлдвэрлэл явуулж чаддаггүй нь гол хүндрэл боловч төрийн худалдан авах ажиллагаа нь дотоодын импортлогч компани хоорондын хурц өрсөлдөөнөөс шалтгаалж найдвартай байдалд эргэлзээ төрүүлдэг зэрэг юм.

Одоо цагт эдгээр бэрхшээл нь цаг хугацаа, орон зай шаардсан, ухаалаг, дэс дараатай, эрэмбэтэй шийдэл гаргахыг хүлээж байна. Эцэст нь дүгнэхэд Үндэсний мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга зам нь төрийн цэргийн байгууллагуудын удирдлагын төвүүдээр дамжин, кибер цэргийн оролцоотойгоор хэрэгжих нь зайлшгүй юм.

⁵ Хиймэл оюун (англ. Artificial Intelligence, AI) нь компьютерын програм хангамжаар бүтээгдсэн хүний сэтгэхүйг дууриалгасан ба бараг ижил түвшинд хүргэсэн технологийн төрөл ба аливаа хүний хийдэг үйл ажиллагааг удирдахад зориулагддаг болно.

⁶ Равжаа Д., Эрдэм шинжилгээний бүтээлийн дээжис., 114х., УБ., 2018., Соёмбо принтинг., ISBN:978-99978-4-474-3



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ БА ЦЭРГИЙН СУРГАЛТ

Д.БААСАНДАМБА /БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын даргийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, доктор (Ph.D), хурандаа/

Түлхүүр үг: Цэргийн сургалт, сургалтын тогтолцоо, шинэчлэл

Key words: Military training, training system, reform

Оршил. Батлан хамгаалах шинэчлэлийн хүрээнд "...өндөр түвшинд бэлтгэгдсэн мэргэжлийн цэрэгт суурилсан орчин үеийн зэвсэглэл, техникээр хангагдсан чадварлаг зэвсэгт хүчинтэй болох замаар зэвсэгт хүчний хөгжлийг эрчимжүүлэн улс орныг батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх¹..." зорилтыг хангахад эрх зүй, бодлого, төлөвлөлтийн зарим ажил, арга хэмжээг чиглүүлж, тодорхой ахиц гарсан. Дээрх зорилтууд нь судалгаа, дүн шинжилгээ, эрх зүйн шинэчлэл, бодлого, стратегийн ба үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл гэсэн үе шатуудаар дамжин хэрэгждэг.

2020 онд стратегийн төлөвлөлтүүдийг шинэчлэх зорилтыг салбарын болон Зэвсэгт хүчний удирдлагаас дэвшүүлж байгаа нь тэргүүлэх ач холбогдолтой хэдий ч "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийн 2.2.1 дэх зэвсэгт хүчний эрх зүйн орчныг боловсронгуй болгож, стратегийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг шинэчлэн мөрдүүлэх зорилтын хувьд анхаарах шаардлага тулгарч байна.

Мэргэжлийн чиг баримжаатай Зэвсэгт хүчнийг байгуулж, бэхжүүлэх цэргийн байгуулалтын хөгжлийн үйл явц зохих хэмжээнд шинэчлэгдэж байна. Зэвсэгт хүчнийг мэргэжлийн цэрэгт суурилсан төрийн цэргийн үндсэн хүч болгон хөгжүүлэх эрх зүй, зохион байгуулалтын үндэс бүрдсэн. Энэхүү шинэчлэлийг эрчимжүүлэхийн тулд стратегийн төлөвлөлтийн хүрээнд зайлшгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээний нэг нь цэргийн сургалтын тогтолцоог мэргэжлийн цэргийн жишигт дүйцүүлж, өөрчлөлт оруулах асуудал зүй ёсоор багтана.

Орчин үед Зэвсэгт хүчнийг мэргэжлийн болгон хөгжүүлэх үзэл

баримтлалыг дэлхийн 70 орчим орон сонгон аваад байна. Үүнд: АНУ, Канад, Их Британи, Голланд, Франц зэрэг өрнөдийн орнуудаас гадна, дорнодын 8, Ази, Австралийн 14, Африкийн 19 оронд энэ чиг хандлагыг барьж байгаа ажээ². НАТО-гийн 24 улсын Зэвсэгт хүчний 15 нь мэргэжлийн болж, цэрэг татлагаас бүр мөсөн татгалзаад байна.

Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчин гэсэн ойлголт нь түүний байлдааны үндсэн бүрэлдэхүүний зонхилох хэсгийг мэргэжлийн цэргийн анги, салбар, бие бүрэлдэхүүн эзэлдэг, тэдгээрийг сургаж, бэлтгэх тогтолцоо нь мэргэжлийн армийн сургалтын зарчим, стандартад дүйцсэн байхад оршино.

Зэвсэгт хүчнийг бүрдүүлэх тогтолцоо нь цэргийн сургалтын агуулга, хэлбэр, арга зүй, тогтолцоог тодорхойлох бөгөөд "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-т зааснаар мэргэжлийн армийн сургалтын суурь зарчмуудад үндэслэн сургалтын тогтолцоог өөрчлөх үндсэн чиглэлийг үндэслэн дараах байдлаар тогтоож болох юм. Үүнд:

- зэвсэгт хүчний хүний нөөцийн бодлогыг шинэчилж, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийн зохистой харьцааг тогтоож мөрдүүлэх;
- цэргийн сургалтын тогтолцоог боловсронгуй болгож, цэргийн алба хаагчийн албан тушаалын болон цэргийн мэргэжлийн зэргийн үндсэн шалгуур үзүүлэлтийг шинэчлэн тогтоож мөрдүүлэх;
- цэргийн сургалтын материаллаг баазыг үе шаттайгаар шинэчилж бэхжүүлэх;

¹ Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр, 2.1., Засгийн газрын 2017 оны 80 дугаар тогтоолын хавсралт

² Серебрянников.В, Дерюгин. Ю, Социология Армии.т.304



- үндэсний цэргийн мэргэжлийн боловсролын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, сургалтын агуулга, хэлбэрийг шинэчлэх зэрэг юм.

2019 онд "Батлан хамгаалахын хүний нөөцийн бодлого"³ шинээр батлагдан гарсан нь Зэвсэгт хүчний хүний нөөцийн бодлогыг шинэчлэлийг хэрэгжүүлэх боломж бүрдэж, бие бүрэлдэхүүнээр нөхөн хангах үйл ажиллагаа, цэргийн мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага, хандлага, бие бялдар, сэтгэл зүйн өндөр бэлтгэлтэй хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх үйл явцыг нэгдмэл бодлогоор зохицуулах суурь нөхцөл тавигдсан.

Энэхүү бодлогын баримт бичгийн хүрээнд "Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах журам", "Батлан хамгаалахын хүний нөөцийн урт хугацааны төлөвлөгөө (2020-2025 он)" батлагдан гарч, ЗХЖШ, төрлийн цэргийн командлалууд дунд хугацааны, цэргийн нэгтгэл, анги, байгууллагууд богино хугацааны хүний нөөцийн төлөвлөгөө боловсруулах үйл явц эхлэлээ тавьж, боловсрол, мэдлэг, мэргэжлийн ур чадвар, туршлага, хандлага, бие бялдар, сэтгэл зүйн өндөр бэлтгэлтэй хүний нөөцийг бэлтгэх үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлага, хяналт сайжрах үндэс бүрдсэн.

Орчин үеийн зэвсэгт тэмцлийн шинж чанар өөрчлөгдөж, түүнийг бэлтгэн явуулах арга, хэлбэр шинэчлэгдсэн, Зэвсэгт хүчний өмнө уламжлалт болон уламжлалт бус үүргүүд тавигдах болсон, орон нутгийн хамгаалалтын бэлтгэл, зохион байгуулалтыг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн зэрэг нь цэргийн сургалтын тогтолцоог боловсронгуй болгох үндсэн шалтгаан болж байна. Эндээс цэргийн сургалтын тогтолцоог шинэчлэх замаар сургалтын төлөвлөлт, арга зүй, технологийг мэргэжлийн армийн жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, бие бүрэлдэхүүнийг сурган мэргэшүүлэх, анги, салбарын жигдрэлт, харилцан ажиллагааг хангах, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх, офицеруудыг олон

улсын цэргийн төлөвлөлтийн арга барилд сургах, томилгоот бие бүрэлдэхүүний гадаадын цэргийн багтай харилцан ажиллах чадварыг нэмэгдүүлэх хэрэгцээ урган гарна.

Шинэчлэлийн бодлого - цэргийн сургалт

XXI зуунд аюулгүй байдлын олон асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн цэргийн оролцоо, үүрэг нэмэгдэж байгаа тул дэлхийн улс орнууд олон жилийн туршид Зэвсэгт хүчний хуримтлуулсан хүчин чадлыг алдагдуулахгүйгээр, орчин үеийн дэвшилтэд арга, хэлбэр, техник, технологийг өргөн ашиглан цэргийн шинэчлэлийг мэргэжлийн армийн жишигт нийцүүлэн хийж, олон талын үүрэг биелүүлэх чадавхыг хангах бодлогыг өөр өөрийн өвөрмөц онцлогтойгоор хэрэгжүүлэх болсон.

Барууны орнуудад хийгдэж буй өөрчлөлтийн гол цөм нь өөртөө бүх төрлийн цэргийн хүчийг багтаасан цомхон бүлэглэл, түүний бүх түвшний удирдлагыг хангах удирдлагын шинэ тогтолцоо бүрдүүлэх (эсвэл байгаа тогтолцоогоо шинэчлэн өөрчлөх) асуудалд төвлөрч байна. Өөрөөр хэлбэл, бүрэлдэхүүндээ нисэх хүчин, тэнгисийн цэрэг, хуурай замын цэргийг багтаасан, удирдлага, тагнуул, мэдээллийн нэгдмэл тогтолцоо бүхий цэргийн бүлэглэлүүдийг байгуулах, тэдгээрийг сургаж бэлтгэх асуудалд анхаарлаа хандуулж байна. Ийм тогтолцоонд шилжих алхмыг АНУ, Их Британи, Герман, Канад зэрэг орнууд эхэлсэн бөгөөд тэдгээрийн араас барууны төрхөөр цэргийн байгуулалтаа хэрэгжүүлдэг бусад орнууд (Австрали, Австри, Бельги, Грек, Энэтхэг, Итали, Шинэ Зеланд, Португали, Польш, Румын, Словак, Сингапур, Швецари, Швед, Чех, Финлянд, өмнөд Африк, Япон г.м.) өөрийнхөө Зэвсэгт хүчинд хэрэгжүүлж эхэлсэн⁴.

Гадаадын улс орнуудын мэргэжлийн армийн туршлагаас үзэхэд жижиг салбаруудаар бие даан тактикийн болон галын үүрэг илүү гүйцэтгэх болсонтой уялдан цэргийн алба хаагчдыг нэг бүрийн

³ "Батлан хамгаалахын хүний нөөцийн бодлого", Батлан хамгаалахын сайдын 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/70 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

⁴ Паламдорж.Ш, бусад. Мэргэжлийн Зэвсэгт хүчин, түүний хөгжлийн хандлага. УБ.,2010 он. т.210.



бэлтгэлээс эхлэн бүлэг, тоот, экипаж, тасаг, салаа, ротын жигдрэлтийг хангахад анхаарч, тактикийн үндсэн нэгж болох батальоны бэлтгэлд чухал ач холбогдол өгч, салбаруудын бие биенээ халхлах, харилцан ажиллагаагаа уялдуулан зохицуулах чадварыг нэмэгдүүлэх сургалт бэлтгэлийг илүү чухалчилж байна.

Мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчний онцлог нь байнгын бүрэлдэхүүн, гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч гэсэн холимог тогтолцооны зарчмын үндсэн дээр бие бүрэлдэхүүнээр нөхөн хангах тогтолцоотой, мэргэжлийн болон ерөнхий боловсролын түвшин өндөртэй, ямар ч үүргийг чадварлаг гүйцэтгэх офицерын бүрэлдэхүүнтэй, мэргэшсэн бага тушаалын дарга, захирагчтай, нийт бие бүрэлдэхүүн нь мэргэжлийн ур чадвар, ёс суртахуун, сэтгэл зүй, бие бялдрын өндөр бэлтгэлтэй байх явдал юм.

Мэргэжлийн армийн онцлогт нийцүүлэн цэргийн сургалтын тогтолцоог шинэчлэх нь:

- дайн, зэвсэгт мөргөлдөөний сургамж, Зэвсэгт хүчний гүйцэтгэх болох үүрэг, хөгжлийн чиг хандлагыг судалж, дүгнэлт хийх;
- сургалтын бодлого, стратегийг шинэчлэн тодорхойлж, түүнд сургалтын агуулга, арга зүй, орчны болон үнэлгээний стандартыг

нийцүүлэх;

- сургалтын төлөвлөлтийг боловсронгуй болгон өөрчлөх;
- сургалтын удирдлага, бүх талын хангалт, төлөвлөгөөт, гүйцэтгэлийн харилцан уялдааг хангах;
- сургалтын орчин, технологийн нөхцөлийг сайжруулах төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх цогцолбор арга хэмжээнүүдээс бүрдэнэ.

Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөрүүдэд цэргийн сургалтын талаар дэвшүүлсэн зорилт, арга хэмжээнүүдэд бодлогын шинжилгээ, гүйцэтгэлийн үнэлгээ хийх асуудал учир дутагдалтай явж ирсэн, стратегийн зорилтын хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжих чанарын болон тоон үзүүлэлтүүд байхгүй, хүрэх түвшин, үр дүнг хэт ерөнхий тодорхойлж ирсэн нь цэргийн сургалтад тогтолцооны өөрчлөлт хийх боломжийг бууруулсан байна.

"Нийтийн арми"-ийн үеийн сургалтын мөн чанар нь хугацаат цэргийн алба хаагчдын сургалтад тэргүүлэх ач холбогдол өгсөн, түүний сургалтад мэргэшсэн цэргийн алба хаагчдынхаа сургалтыг дагалдуулсан, сургалтын үечлэл түүнд захирагдсан шинжтэй сургалт байсан⁵. Иймээс сургалтын тогтолцоонд нэг бүрийн мэргэжлийн бэлтгэл, тасаг,

"Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"		"Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"	
Хөтөлбөрт цэргийн сургалтын талаар дэвшүүлсэн зорилт			
Зэвсэгт хүчний үндсэн үүргийнхээ зэрэгцээ НҮБ-ийн энхийг сахиулах ажиллагаанд оролцох, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах, нийтийг хамарсан байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн томоохон осол, уламжлалт бус бусад аюулын үед хүмүүнлэгийн үүрэг гүйцэтгэх чадвартай, мэргэшсэн болгон хөгжүүлэх		Өндөр түвшинд бэлтгэгдсэн мэргэжлийн цэрэгт суурилсан орчин үеийн зэвсэглэл, техникээр хангагдсан чадварлаг зэвсэгт хүчинтэй болох замаар зэвсэгт хүчний хөгжлийг эрчимжүүлэн улс орныг батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх	
Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр баталсан дэд төсөл, хөтөлбөр			
"Сургалтын материаллаг бааз" дэд төсөл Төслийн нийт өртөг 5,8 тэрбум		Байхгүй	
Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний боловсруулалтын түвшин			
Суурь түвшинг зөв тодорхойлсон эсэх	Үгүй	Суурь түвшинг зөв тодорхойлсон эсэх	Үгүй
Үр дүн, хүрэх түвшинг зөв тодорхойлсон эсэх	Үгүй	Үр дүн, хүрэх түвшинг зөв тодорхойлсон эсэх	Үгүй
Шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлсон эсэх	Үгүй	Шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлсон эсэх	Үгүй

⁵ Мэргэжлийн цэрэгт суурилсан сургалтын тогтолцооны онцлог., Амгаланбаатар.Б, Паламдорж.Ш.



тоот, салбарын жигдрэлтийг хангах, сургалтын цагийн ачааллыг нэмэгдүүлэх хэрэгцээ байна.

Сургалтын ачааллыг нэмэгдүүлэхэд нэгтгэл, анги, салбаруудын өдөр тутмын үйл ажиллагааны зохион байгуулалтыг өөрчлөх, сургалтын орчин технологийн нөхцөлийг сайжруулах, бүх талын хангалтыг нэмэгдүүлэх шаардлагатай. Сургалтын ачааллыг нэмэгдүүлэхэд хээрийн дадлага, сургалтын төвүүдэд явагдах бүх төрлийн сургууль, хичээл, дадлагуудыг нэмэгдүүлэх нь илүү үр нөлөөтэй. Тухайлбал, ОХУ-ын хувьд сүүлийн жилүүдэд салбарын сургалтын эрчмийг нэмэгдүүлэхийн тулд бүх хээрийн сургалтын төвүүдийн ашиглалтыг 80 хувиас илүү хэмжээнд хүргэж, Зөвлөлтийн үеийн болон барууны орнуудын армийн туршлагад үндэслэн зөвхөн хээрийн сургалтад шаардлагатай сум, галт хэрэглэлийн зарцуулалтыг гэхэд 5 дахин нэмсэн байна⁶. Түүнчлэн офицерын сургалтын хүрээнд янз бүрийн байгаль, цаг уурын нөхцөлд, агаар, ус, хуурай газарт үүрэг биелүүлэх чадварыг нэмэгдүүлэхэд сургалтын цагийн ихээхэн хувийг зарцуулахаар хөтөлбөр, төлөвлөгөөнд өөрчлөлт хийжээ.

Цэргийн сургалтын тогтолцоог шинэчлэх зарим асуудал

Цэргийн сургалтын тогтолцооны онцлог нь түүний шинж чанар, бүрэлдэхүүн хэсэг, тоо, чанарын болон төрөл бүрийн үзүүлэлтээрээ бусад тогтолцооноос ялгарч байдаг. Тухайлбал, цэргийн сургалтын тогтолцоо нь өөртөө удирдлагын, хүн хүчний, материал техникийн, мэдээллийн зэрэг нэгдмэл зорилго, тодорхой зүй тогтол бүхий харилцан уялдаатай үйл ажиллагааны цогц болдог⁷. Түүний тогтолцооны бүх элементүүд нь цэргийн алба хаагчдыг сургаж, мэргэшүүлэх, сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, Зэвсэгт хүчний өмнө тавигдсан үүргийг биелүүлэх бэлтгэл, бэлэн байдлыг хангах гэсэн гурван үндсэн чиглэлд захирагдаж байдаг. Иймээс цэргийн сургалтын тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг

авч үзэхдээ дараах асуудалд анхаарах шаардлагатай болно. Үүнд:

Нэгдүгээрт, цэргийн алба хаагч нэг бүрийн сургалт, тасаг, тоот, экипаж, салаа, салбарын жигдрэлтийн болон төрөл мэргэжлийн анги, салбаруудын хамтарсан бэлтгэл, тэдгээрийн төрөл, хэлбэр, сургалтын арга зүй;

Хоёрдугаарт, зэвсэгт хүчнийг хэрэглэх бэлтгэл, бэлтгэл байдлыг хангах, цэргийн сургалтыг удирдан зохион байгуулах, түүнийг төлөвлөх, үр дүнг үнэлэх үйл явц;

Гуравдугаарт, сургалтыг бүх талаар дэмжих, түүнийг тасралтгүй, чанартай явуулахад шаардлагатай материал, техникийн хангалтын үндэс зэрэг болно.

Олон улсын практикт цэргийн сургалтын тогтолцоог боловсруулж мөрдөхдөө:

- бие бүрэлдэхүүний бүтцийн ангилал, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар, албан тушаалын зэрэглэл, алба хаасан хугацаагаар нь ялгавартай хандах;
- зэвсэгт хүчний ай, төрөл, тусгай мэргэжлийн цэрэг, тэдгээрийн нэгтгэл, анги, салбарын зохион байгуулалт, зэвсэглэл, үүрэг гүйцэтгэх онцлогийг харгалзан үзэх;
- Улс орны батлан хамгаалах бодлого, цэргийн номлол, цэргийн шинжлэх ухааны хөгжил, цэрэг-улс төрийн цагийн байдал, болзошгүй цэргийн аюул занал, зэвсэгт тэмцлийн шинж чанар, цэргийн ажиллагааны ирээдүйн чиг хандлагад нийцсэн сургалтын агуулга, арга зүйг тооцох зарчмыг баримталж байна.

Сургалтын агуулгын шинэчлэл:

Тогтолцооны өөрчлөлтийн өөр нэг анхаарах асуудал нь сургалтын арга зүй, төлөвлөлт, агуулгын шинэчлэлийг мэргэжлийн армийн жишигт нийцүүлэх үйл явц нь цэргийн алба хаагч, нэгж, салаа, салбар, анги бүрийн "нэн чухал үүргийн жагсаалт"-ыг боловсруулах явдал юм. Бид өмнө цэргийн сургалт бэлтгэлийн стандартаар сургалтын агуулга, судлагдахууны хүрээнд заавал

⁶ <https://rg.ru/2019/09/23/oficerov-nauchat-kachestvenno-voevat-v-liubyh-usloviiah.html> Спецназ при любой погоде.

⁷ Хромов.А.О. Тенденции развития боевой подготовки войск (сил) военного округа в современных условиях. Военная мысль. 2019, №10, стр.121

гүйцэтгэх ур чадвар, ажиллагаа, мэдвэл зохих зүйлсийн минимум шаардлагыг тогтоож ирсэн. Гэвч сургалтын стандартын минимум шаардлагад захирагдан түүний түвшинг ахиулах талаар дорвитой ахиц гарахгүй хэвээр байна. Түүнчлэн "Цэргийн алба хаагчдын мэргэжлийн зэргийн ангилал, тавигдах шаардлага"⁸-ыг баталж, мөрдүүлж байгаа хэдий ч энэ нь мэргэжлийн зэрэгтэй офицер, ахлагч нарын эзлэх хувь маш бага байгаа нь ч үүний нэг нотолгоо болно.

Нэн чухал үүргийн жагсаалт нь цэргийн алба хаагч, нэгж, анги, салбарын байлдаанд заавал гүйцэтгэх тодорхой, хэмжигдэхүйц, ялгаатай үйл ажиллагаа ба үйлдэл⁹ бөгөөд энэ нь тодорхой стандарт, шалгуур үзүүлэлт, байлдааны дүрэм, заавруудад үндэслэнэ.

Нэн чухал үүргийн жагсаалтаар "зорилтот", "үр дүнд суурилсан" сургалтын хөтөлбөрийн агуулгыг тодорхойлж,


түүнийг хэрэгжүүлэх хугацаа, уг хугацаанд боловсруулах норматив дадлагын нөхцөл, дадлага сургуулийн нөөц боломж, арга, ажиллагаанд уялдсан төлөвлөлтийг үнэлгээний хамт хийж, цэргийн алба хаагчийн мэргэжлийн ур чадвар ("Ч а д а м ж")-ын элементүүдийг оновчтой тогтоож, анги, салбарын жигдрэлт, бэлэн байдлын заавал хүрсэн байх түвшинг тогтоодог байна.

Энэхүү "Нэн чухал үүргийн жагсаалт"-ыг рот, батареины захирагч нар гаргаж, батальон, дивизионы захирагч хянан баталдаг бөгөөд энэ нь нэг талаар сургалтын стандартыг, нөгөө

талаар цэргийн алба хаагч, анги, салбарын шалгуур үзүүлэлтийг төлөөлдөг. Зарим мэргэжлийн армиудад цэргийн сургалтын номлол, бодлогыг тодорхойлж, үр дүнг тооцдог бие даасан нэгж, эрдэм шинжилгээний байгууллагатай байх ба тэр нь орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний сургамжийг судалж, сургалтын бодлогыг тодорхойлон сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулж, үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгч байгаа туршлагыг бид авч үзэх асуудал юм.

Сургалтын орчин, технологийн нөхцөлийн шинэчлэл: Цэргийн алба хаагчдын сургалт, анги, салбарын жигдрэлт, штабын бэлтгэлийг орчин үеийн өндөр технологийг өөртөө агуулсан материал, техник хэрэгсэл, төхөөрөмжлөгдсөн байгууламж бүхий сургалтын материаллаг баазгүйгээр зохион байгуулах боломжгүй¹⁰.

Цэргийн сургалтын орчин,



Зураг 1. Нэн чухал үүргийн жагсаалт боловсруулах аргачлал

⁸ Батлан хамгаалахын сайдын 2012 оны ... дугаар тушаал.

⁸ <https://www.globalsecurity.org/military/library/policy/army/fm/25-100/chap2.htm>, Chapter 2. Mission Essential Task List (METL) Development.

¹⁰ Руководство по боевой подготовке в Вооруженных Силах.–Минск: МО РБ, 2014



технологийг мэргэжлийн армийн жишигт ойртуулахын тулд:

- Сургалтын төв, дадлагын байр, талбай, хотхонуудыг орчин үеийн цахим, симуляци, интерактив тоног, төхөөрөмж, цогцолбор тренажеруудаар өргөтгөж, сургал-тын идэвхитэй, үр дүнтэй, эдийн засгийн хэмнэлттэй байдлыг дээшлүүлэх;
- Анги, салбарын өдөр тутмын үйл ажиллагааны ачаалал, хөдөлмөр хуваарилалт, аж ахуйн ажилд оролцох хувь хэмжээг зөв зохицуулах замаар сургалтын ачаалал, цагийн хүрэлцээг нэмэгдүүлэх;
- Мэдээллийн технологийн ололтыг сургалтад тууштай нэвтрүүлэх;
- Цэргийн сургалтын тогтолцоо, цэргийн мэргэжлийн стандарт, агуулга, технологийг Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн байлдааны болон бусад үүрэг гүйцэтгэх чадавх бүхий, өндөр мэргэшсэн Зэвсэгт хүчний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгон төгөлдөржүүлэх;
- Анги, байгууллагын цэргийн сургалт хариуцсан албан тушаалтнууд, сургагч нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулан мэргэшүүлж, мэргэшсэн сургагч нарыг бэлтгэх тогтолцоог бий болгох, тэдний шинжлэх ухаанч, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
- Зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчдад суралцах, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах.

Ирээдүйн цэргийн сургалтын хандлага нь уламжлалт ангийн хичээл, хээрийн дадлага, багшийн заах арга барил, нэг бүрийн бэлтгэл, анги, салбарын жигдрэлтийг улам боловсронгуй, илүү идэвхитэй болгохыг шаардаж байна. Технологийн автоматжуулалт нь сургалтын материал, техник хэрэгсэл, сурах бичгийн ашиглалт, багшийн зааварчилгаа өгөх, сургах ажиллагааг улам дээшлүүлж байгаатай холбоотой юм.

"Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-т цэргийн сургалтыг хөгжүүлэх талаар тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг хангахад командлал, нэгтгэл, ангиудаг тодорхой төсөл, хөтөлбөр дутуу байгааг залруулж, төлөвлөсөн ажил, арга хэмжээнүүдийн чанар, цар хүрээ хязгаарлагдмал байгааг анхаарах цаг болсон.

Цаашид зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх дунд хугацааны төсөл, хөтөлбөр (2020-2024 он)-т цэргийн сургалтыг хөгжүүлэх талаар тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, эрх зүй, төсөв, санхүү, материалын болон хүний нөөцийн талаар оновчтой хуваарилалт, хүртээмжтэй нөхөн хангалтын бодлогыг баримтлах; цэргийн сургалтыг хөгжүүлэх зорилгоор боловсруулсан дэд төсөл, арга хэмжээнүүдийн тооцоо, судалгааг дахин хянах, хэрэгжих бодит боломж, нөөцийг тогтоох; Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, мэргэжлийн цэргийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн цэргийн сургалтын арга зүйг боловсронгуй болгох шаардлага урган гарч байна.

Ашигласан материал:

1. "Батлан хамгаалахын хүний нөөцийн бодлого", Батлан хамгаалахын сайдын 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/70 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт.
2. Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр, 2.1., Засгийн газрын 2017 оны 80 дугаар тогтоолын хавсралт.
3. "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр". Батлан хамгаалах судлал сэтгүүл. УБ.,2006. №6.т.3.
4. ЭХЖШ. "Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн ерөнхий журам". 2008 он;
5. Цэргийн сургалт бэлтгэлийн ерөнхий журам.УБ., 2017.
6. Ванчигсүрэн.Д, Энхтүвшин.Б. "Краткий толковый словарь эдукологических понятий". 1994.т.97-101.
7. Доед.У,Цэрэндолгор.Ц.Сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүйн асуудалд, дээрх номны хууд.т.60-63.
8. Лхагважав.Ч,Нэргүй.Н, Сургалтын арга зүйн хөгжил: Чиг хандлага, шийдлийн үндэслэл, Сургалтын арга зүй.т.5-33.
9. Паламдорж.Ш. бусад. Мэргэжлийн Зэвсэгт хүчин, түүний хөгжлийн хандлага. УБ.,2010.т.210.
10. Образцов П. И., Косухин В. М. Дидактика высшей военной школы: Учебное пособие. Академия Спецсвязи России, 2004 . стр.317.
11. Серебрянников.В, Дерюгин. Ю, Социология Армии.т.304.
12. Хромов.А.О. Тенденции развития боевой подготовки войск (сил) военного округа в современных условиях. Военная мысль. 2019, №10, стр.121
13. Van Martin, "Doctrine, Training and Military Education in the U.S. Army", 2004.
14. Paradigm Change in Military Education and Training., Bell, Herbert H.; Reigeluth, Charles M.
15. Армия России в 2017 году. Что нового?. <http://vvesti.com/army/armiya-rossii-v-2017-godu>
16. В Вооруженных Силах Российской Федерации начинается новый учебный год. <http://function.mil.ru/news>

ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ СУУРЬ БОЛОХ НЬ



Р.ЭНХБОЛД /ЗХЖШ-ын Бодлого, стратеги төлөвлөлтийн газарт Стратегийн төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн, доктор, хурандаа/

2000 онд БНХАУ-ын Хуурай замын цэргийн академийн тусгай хүчний сургууль, 2001 онд БХИС-ийн Ерөнхий зориулалтын цэргийн сургуулийг ерөнхий цэргийн командын офицер-Төрийн захиргааны ажилтан мэргэжлээр, АНУ-ын Батлан хамгаалах хэлний институт, явган цэргийн офицерын үндсэн дамжаа, ОХУ-ын Ерөнхий цэргийн академийг оператив-тактик, нэгтгэл, ангийн удирдлага мэргэжлээр тус тус төгссөн. ОХУ-д "Мотобуудлагын бригадын байлдааны боломжийг тооцох аргачлал" сэдвээр цэргийн шинжлэх ухааны магистр, Аюулгүй байдал судлалын доктор.

Түлхүүр үг: Орон нутгийн хамгаалалтын бэлтгэл, хөгжил, тогтвортой хөгжил, эрчим хүч, дэд бүтэц, хүний хөгжил

Key words: Preparation of the territorial defense theory, development, sustainable development, electricity, infustructure, human development

Хураангуй: *Орон нутгийн хамгаалалт нь орон нутгийн хөгжлөөс хамаарна. Тийм учраас орон нутгийн хамгаалалтыг бэхжүүлэх, түүний бэлтгэлийг хангахын тулд хөгжлийн асуудлыг хамтад нь авч үзэх нь бидний өмнө тулгамдаад буй асуудал болоод байна. Орон нутгийн эдийн засаг, төсөв, хөрөнгө оруулалт, нийгмийн байдал, удирдлага, дэд бүтэц, хүн амын боломж нэмэгдэж, хүмүүс хөгжиж байж л өөрийгөө хамгаалах нөхцөл, боломж нэмэгдэх нь тодорхой юм.*

Орон нутгийн хамгаалалт нь орон нутгийн хөгжлөөс хамаарна. Тийм учраас орон нутгийн хамгаалалтыг бэхжүүлэх, түүний бэлтгэлийг хангахын тулд хөгжлийн асуудлыг хамтад нь авч үзэх нь бидний өмнө тулгамдаад буй асуудал болоод байна. Орон нутгийн эдийн засаг, төсөв, хөрөнгө оруулалт, нийгмийн байдал, удирдлага, дэд бүтэц, хүн амын боломж нэмэгдэж, хүмүүс хөгжиж байж л өөрийгөө хамгаалах нөхцөл, боломж нэмэгдэх нь тодорхой юм. Юуны өмнө хөгжил гэдэг юу болох талаар олонх эрдэмтэд санал нийлдэг тодорхойлолтыг авч үзье. Нийгмийн тогтолцооны бүхий л шатны байгуулал, хандлага, бодлогын түвшинд ахиц гаргахад чиглэсэн хөдөлгөөнийг хөгжил гэж үзэж болох ба энэ нь дотроо хүний хөгжил, нийгмийн хөгжил, эдийн засгийн хөгжил, тогтвортой хөгжил гэх

зэргээр хуваагдаж болох ажээ.

Хүн төрөлхтөн шинжлэх ухаан, технологийн хувьсгалд тулгуурлан аж үйлдвэржсэн нийгмээс мэдээлэлжиж, даяаршиж буй нийгэмд шилжиж байна. Дэлхий дахины эдийн засаг, зах зээлийн харилцаанд мэдээлэл, хүн, барааны шилжилт хөдөлгөөн, бүтээгдэхүүн, үйлчилгээний хил хязгааргүй урсгал явагдаж, түүнд суурилсан даяаршлын цоо шинэ нөхцөл байдал бүрдэж байгаагаас улс орнууд хүн, нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтийн хэтийн бодлогоо даян дэлхийн болон бүс нутгийн хөгжлийн үйл явцтай нягт уялдуулан тодорхойлох болов.

Ийм нөхцөлд Монгол Улсын хөгжилд дэлхийн, ялангуяа Ази тив, Төв болон Зүүн хойд азийн бүс нутгийн хөгжлийн хандлага, даяаршлын эерэг болон сөрөг хүчин зүйлсийн нөлөөллийн аль алийг нь тооцож, хөгжлөө эрчимтэй бөгөөд тогтвортой болгохын тулд урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, стратегиа зөв тодорхойлох шаардлага тулгарч байна. Даяаршлын нэг давуу тал болох шинэ техник, инноваци, технологи эзэмшиж, түүнийг нутагшуулж чадсан улс орнууд хөгжлийн давуу байдлыг олж авч байна. Ирээдүйн технологийн чиг хандлага зөвхөн зарим технологийн дэвшлийг хурдасгах төдийгүй, мэдээлэл, био технологийн хам нөлөөний



үйлчлэлээр аж амьдралын бүхий л хүрээнд хувьсгал хийх юм.

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээс хойш нийгмийн өмнөх тогтолцооны үеийн төрийн төвлөрсөн төлөвлөгөөт зохицуулалтаас зах зээлийн харилцааны зохицуулалтын хууль, зүй тогтол үйлчилдэг болсон билээ. Хэдийгээр нийгмийн өөр тогтолцоонд шилжсэн ч эдийн засаг, санхүүгийн хязгаарлагдмал нөөцийг зөв зохистой хуваарилах болон үр ашигтай зарцуулахад хөгжлийн бодлого төлөвлөлт чухал ач холбогдолтой юм.


Монгол Улсын хөгжлийн хандлага нь дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн хөгжил эрчимжиж, манай орны гадаад эдийн засаг, худалдааны орчин нөхцөл тааламжтай болж, бүс нутгийн болон дэлхийн зах зээлтэй хялбар холбогдож, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ дэлхий дахинд таниулах боломж нэмэгдэж байна. Манай орны хүүхдүүд анхан шатны сургуульд хамрагдалт сайн, бичиг үсэг тайлагдалтын түвшин өндөр, вакцинжуулалтын хамрагдалт сайн, 1000 хүнд ногдох эмчийн тоо харьцангуй өндөр, хүн амын насны бүтэц зөв, макро эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирч байгаа, хөрш орнууд болох ОХУ, БНХАУ-ын томоохон зах зээлтэй ойр, ашигт малтмалын нөөц их, ховор ан амьтан, ургамлын төрөл зүйл, баялаг бүхий өргөн уудам газар нутаг зэрэг нь хөгжлийн давуу тал болж байна.

Харин хөгжлийн сул тал нь хүн амын

өсөлт удаан, наслалт харьцангуй богино, нярай хүүхдийн болон эхийн эндэгдэл их, хүн амын тоо цөөн, тархай бутархай байршилтай, боловсролын чанар хангалтгүй, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түвшин доогуур, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанараар дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар сул, уур амьсгал нь эрс тэс, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл цаг уурын өөрчлөлтөөс хэт хамааралтай, эрчим хүчний хангамж бага, найдваргүй, дэд бүтэц сул хөгжсөн, тивийн болон бүс нутгийн олон улсын гол зам, харилцаанаас алслагдсан, далайд шууд гарах гарцгүй, ажилгүйдэл, ядуурал их, гадаад худалдаа, түүний дотор экспортын бүтэц өрөөсгөл, хөрөнгө санхүү, валютын нөөц хязгаарлагдмал, эдийн засаг нь уул уурхай, хөдөө аж ахуйн цөөн бүтээгдэхүүнээс хамааралтай зэрэг асуудлууд юм.

Монгол Улс 1990 онд ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэний дараах хэсэг хугацаанд хүн амын амьжиргааны түвшин огцом доройтож, ДНБ-ий өсөлт 1994 он хүртэл дунджаар хасах 4,4 хувьд хүрч байв. Харин 1995 оноос эхлэн эдийн засаг аажмаар сэргэж, удаан боловч тогтвортой өсч эхэлсэн бөгөөд 2003 онд нэг хүнд ногдох ДНБ 1990 оны түвшинд эргэж хүрчээ. (1 дүгээр зураг)

Монголын эдийн засаг 2000-2009 онд жилд дунджаар 6 хувиар өссөн нь энэ үед Монгол Улс ашигт малтмалын



1 дүгээр зураг. Монгол Улсын ДНБ-ий 2001-2019 оны үзүүлэлт (сая.төг)¹

¹ Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны 2020.02.17-ны өдрийн үзүүлэлт



хэд хэдэн томоохон ордыг ашиглалтад оруулсантай холбоотой байдаг. 2011 онд Монгол Улсын ДНБ огцом өсөлттэй гарсан ч БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарч, Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалт буурсан, дэлхийн зах зээл дээр эрдэс баялгийн үнэ огцом унасан зэргээс үүдэн Монголын эдийн засгийн өсөлт 2012 оноос саарч эхэлсэн.

Манайд байгаа ажилгүйдэл, амьжиргааны түвшин, инфляци нь бидний хөгжил, өнөөгийн нийгэмд тулгарч буй хамгийн том сорилтууд болоод байна. Гэсэн хэдий ч хот, суурин газартай харьцуулахад хөдөө орон нутагт ядуурал өндөр хэвээр байгаа ба бүс нутаг бүрт харилцан адилгүй байна. Ядуурлын түвшин 2010 онд баруун болон хойд бүс нутагт хамгийн өндөр байсан бол төвийн бүс, Улаанбаатар хотод хамгийн бага байжээ.

Монгол Улсын байгалийн нөөц, түүний дотор газар зүйн байршил, газар нутгийн хэмжээ, газрын бүрхэвч, уур амьсгал, усны нөөц нь сорилт, боломжийн аль алийг нь дагуулж байна. Газар зүйн байршлын хувьд худалдааны гол чиглэлүүдээс алслагдмал байдлаас гарах аргагүй бөгөөд хөрсний доройтол, байгалийн гамшгийн нийгэм-эдийн засгийн асар өндөр үр дагавар дагуулдаг. Хэдийгээр Монгол Улс олон улсын голлох зах зээлүүд, хүн ам ихтэй төвүүдээс хол байрладаг ч тээврийн зардал нь зарим улсуудын түвшинтэй ойролцоо байна.

Монгол Улс нь алт, зэсийн баяжмал, нүүрс болон бусад ашигт малтмалын баялгаасаа арвин үр шим хүртэх боломжтой. Гэвч эдийн засгийн болоод байгаль орчны тогтвортой байдлыг хангахын тулд байгалийн баялгийн ашиглалтын оновчтой менежмент шаардлагатай юм. Эх газрын эрс тэс уур амьсгал, зудын ойр давтамж зэрэг нь хөдөө аж ахуйн салбарт хохиролтой тусч, Улаанбаатар хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг хурдасгаж байдаг. Гэхдээ энэ бүх тохиолдолд Монгол орны байгалийн нөөц нь нэмэлт хүчин зүйл гэхээс суурь шалтгаан болохгүй байгаа нь ажиглагдаж

байна. Жишээлбэл, бэлчээрийн даац хэтрэлт нь газрын хөрсний онцлогоос бус харин газрын харилцааны зохицуулалт тааруугаас үүдсэн асуудал юм.

Даатгалын тогтолцоо сайн хөгжөөгүйгээс гадна байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх бэлтгэл хангалтгүй байгаа тул зудын эдийн засаг, нийгмийн үр дагавар улам ноцтой болж байна. Үүний нэгэн адил, усны нөөцийн хомс байдал нь эдийн засгийн бодит салбар, орлого багатай иргэдийн хувьд ус, ариун цэврийн байгууламжийн зардал өндөр байгаад нөлөөлдөг. Эдгээр үзүүлэлтэд үндэслэн дүгнэвэл Монгол Улсын хувьд байгалийн нөөц нь эдийн засгийн хөгжлийг шууд хязгаарлагч хүчин зүйл биш юм.

Цахилгаан эрчим хүчний хүртээмж дунджаас дээгүүр байгаа хэдий ч харьцуулан судалж буй орнуудтай жишихэд эрчим хүчний дэд бүтцийн чанар, найдвартай байдал тааруу байна. Түүнчлэн, цахилгаан үүсгүүр дангаараа болон хамтран эзэмшдэг компаниудын тоо харьцуулсан улсуудын дунджаас илүү байгаа ба үүсгүүрээс авч байгаа цахилгааны хэмжээгээр харьцуулсан улсуудыг тэргүүлж байгаа юм. Энэ мэт хүндрэл бэрхшээлүүд байгаа хэдий ч эрчим хүчний асуудал Монгол Улсын өсөлтийг хязгаарлагч хүчин зүйл биш юм. Сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахын тулд эрчим хүчний үйлдвэрлэл нэмэгдэж байгаа бөгөөд зөвхөн ачаалалтай үеийн хэрэглээг хангах зорилгоор бага хэмжээний эрчим хүч импортоор авч байгаа юм. Одоо байгаа хүчин чадлыг сайжруулахын тулд эрчим хүчний худалдаа явуулах, томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөөд байгаа ба цахилгаанаас хамааралтай салбарууд өсч хөгжсөөр байна².

Тээврийн дэд бүтцийн чанарын асуудал, экспортын ялимгүй өндөр зардал зэргийг авч үзвэл тээвэрлэлтийн асуудал зарим салбарын хөгжлийг, тухайлбал, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэргийг хязгаарлаж байх боломжтой³. Сүүлийн жилүүдэд замын сүлжээ тасралтгүй сайжирч ирсэн ба гол чиглэлийн ихэнх зам хатуу хучилттай болсны дээр тээврээс

² Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж буй хүчин зүйлсийн судалгаа. (Эдийн засгийн өсөлтөд шууд нөлөө үзүүлж буй хүчин зүйлст хийсэн дүн шинжилгээ) 2016 он. 101 тал;

³ Мөн тэнд. 115 тал;



хамааралтай эдийн засгийн салбарууд өсөлттэй байна. Уул уурхайн зарим үйл ажиллагааны хувьд тээвэрлэлтийн өртөг өндөр байж болох ч улс орны хувьд асуудал болохуйц хэмжээнд байгаа гэсэн сөрөг хандлага ажиглагдахгүй байгаа юм. Гэвч тээврийн хүртээмжийн асуудал, жишээ нь, уул уурхайн салбарт орд газрууд хүртэл төмөр замын хүрэлцээ, алслагдмал орон нутаг хотын захын гэр хороололд байна.

Монгол Улс эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогодоо орон нутгийн хөгжлийг дэмжих зорилтыг тууштай баримтлах, чухамдаа суурин болон нүүдлийн амьдралын хэв маягийг оновчтой хослуулах замаар хүн амын нутагшилт, суурьшилтын таатай нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа билээ. Үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад гол нөлөөтэй, хөгжлийн ирээдүйтэй нутаг, хот сууринг хөгжүүлж эхлэх аваас түүнд ойр байгаа нутаг ч даган хөгжих болно. Үүний дүнд бүс нутгийн аж ахуйн бие даасан байдал хангагдах болно.

Монгол Улсын Засгийн газраас орон нутгийг хөгжүүлэх талаар тогтвортой хөгжлийн бодлого баримталж, УИХ-аас "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" бодлогын баримт бичгийг баталсан⁴. Тогтвортой хөгжил гэдэг нь хойч үеийнхээ хэрэгцээ, шаардлагаа хангах боломжийг хязгаарлахгүйгээр өнөө үеийнхээ хэрэгцээ, шаардлагыг хангахад чиглэгдсэн хөгжил юм. (2 дугаар зураг) Нөгөө талаар тогтвортой хөгжил гэдэг нь ирээдүй хойч үеийнхээ хэрэгцээ, боломжийг алдагдуулахгүйгээр өнөөдрийн хэрэгцээг хангадаг байхыг хэлж болно⁵.

Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд орон нутгийн эдийн засгийн өсөлтийг байгаль орчинд ээлтэй байдлаар хангах,



2 дугаар зураг. Тогтвортой хөгжлийн гурвалжин

өсөлтөөс буй болсон үр өгөөжийг нийгэмд тэгш хүртээмжтэй хуваарилах замаар нутгийн өөрийгөө хамгаалах чадавхыг бэхжүүлэх нь чухал болоод байна.

Тогтвортой хөгжлийн талаарх олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн зарчим бол байгаль орчин, нийгэм, эдийн засаг гэсэн 3 үндсэн тулгуур асуудал ижил түвшинд хангагдаж байх явдал юм. Эдгээр гурван асуудал бие биенээсээ хамааралтай, харилцан шүтэлцээтэй бөгөөд тогтвортой хөгжлийн бүрэлдэхүүн хэсгүүд юм. Яагаад гэвэл бид агаараар амьсгалж, ус ууж, хоол хүнс идэж, байгалийн байлгийг хэрэглэж байна. Энэ бүгдийг байгаль дэлхий өгч байгаа учир байгаль орчныг эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн гол суурь гэж тодорхойлж болох юм⁶.

Тогтвортой хөгжлийн загварын хүрээнд орон нутгийн дунд болон урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь нь дараах байдлаар тодорхойлогдоно. (3 дугаар зураг)

1 Дэд бүтцийг хөгжүүлэх	2 Бие даасан байдлыг хангах	3 Иргэдийн амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх
-Эрчим хүч -Зам тээвэр -Мэдээлэл харилцааны сүлжээ -Нийгмийн үйлчилгээ	-Удирдлагын -Эдийн засгийн -Санхүүгийн	-Ажлын байрыг нэмэгдүүлэх -Ядуурлыг бууруулах -Орлогын нэмэлт эх үүсвэрийг бий болгох

3 дугаар зураг. Орон нутгийн тогтвортой хөгжлийн суурь

⁴ "Төрийн мэдээлэл" сэтгүүл. №6 (915).

⁵ "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол;

⁶ Michelle E. Jarvie "Brundtland report" 1987. UN. Publication by world commission on environment and development;

⁶ НҮБ-ын Статистикийн комиссын нарийн бичгийн даргын дэргэдэх дээд түвшний ажлын хэсгийн тайлан. 2016. 4 тал;



Дээрх байдлаас харахад төрөөс явуулж буй тогтвортой хөгжлийн бодлого нь орон нутгийг хөгжүүлэхэд иргэдийг сургах, хүмүүжүүлэх, мэдээлэл, сэтгэл зүйн чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангахад шууд хамааралтай нь тодорхой байна.

Монгол Улс нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад бодлогын үзэл баримтлал, эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжил, тэгш, хүртээмжтэй өсөлтийг хангахад чиглэсэн зорилго, зорилт, хүрэх үр дүнг нөөц, эх үүсвэртэй нь уялдуулан тооцсон хөгжлийн загварт суурилсан хөгжлийн үзэл баримтлалыг баримтална⁷. Ирээдүйн хөгжлийн гол зорилт нь байгаль орчин, нийгэм, эдийн засаг, засаглал гэсэн дөрвөн чиглэлээр хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Аймгуудын хөгжлийн дээрх ялгаатай байдал нь орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, зохион байгуулахад дараах байдлаар нөлөөлж байна. Тухайлбал төвийн бүсийн аймгуудад ажлын байрны олдоц илүү, дэд бүтэц харьцангуй сайтай, улсын чанартай авто болон төмөр замтай холбогдсон, газар тариалан болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэл явуулдаг, бараа, материал, шатахууны үнэ хямд байгаа нь алслагдмал аймгуудаас хөгжлөөр илүү байгааг харуулж байна.

Эдгээр аймгууд санхүүгийн хувьд харьцангуй бие даасан, төрөл бүрийн сургалт явуулах материаллаг баазтай ойрхон байрладаг, улсын чанартай авто болон засмал замаар холбогдсон зэрэг хүчин зүйлс нь орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, нөөцийг бүрдүүлэхэд хялбар, сургалт явуулахад таатай нөлөө үзүүлж байна. Харин өмнөд бүсийн зарим аймгууд нь төв орон нутгаас хол, гадны улс оронтой хиллэдэг, хүн ам сийрэг, дэд бүтэц, зам харилцаа сул хөгжсөн зэрэг нь орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангахад сөргөөр нөлөөлж байгаа юм. Тийм учраас стратегийн чиглэл дайран өнгөрдөг, хил залгаа зарим аймгуудын хөгжлийг төрийн бодлогоор дэмжих, тэнд хийгдэх бүтээн байгуулалтын ажлыг

батлан хамгаалах эрх ашигт нийцүүлэх, орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх нь чухал байна.

Монгол Улсын нутаг дэвсгэр, түүний баялаг, газар тариалан, мал, аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, оюуны чадавхыг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж хөгжлийн түвшинг ойртуулах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэх үйл ажиллагаа нь орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах зорилгод нийцэж байх нь чухал байна.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг түлхүү хөгжүүлэх, түүгээр дамжуулан бүс нутаг, хот, хөдөөгийн хөгжлийн нэгдмэл болон харьцангуй бие даасан тогтолцоонд суурилсан бүс нутгийн эдийн засаг, нийгмийн цогцолборуудыг бүрдүүлэх төрийн бодлого, үйл ажиллагаа нь орон нутгийн хамгаалалт болон Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг эдийн засгийн бүсүүдийн хуваарилалттай нийцүүлэн амжилттай хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн үндэс болох болно хэмээн судлаачийн зүгээс үзэж байна.

Орон нутгийн хамгаалалттай холбогдол бүхий бас нэг анхаарал татсан асуудал бол Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд, тэдгээрийн орчмын нутгийн хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний хэт бөөгнөрөл, удирдлагын төвлөрөл, экологийн тэнцлийн алдагдлыг сааруулж, бүсүүдийн хөгжлийн түвшинг эрэмбэ дараатай дээшлүүлэх төрийн бодлого нь орон нутгийн хамгаалалтын нөөц, бололцоог нийт нутаг дэвсгэрт тэнцвэртэйгээр бүрдүүлэх, ялангуяа алслагдсан болон хил хязгаар нутагт өөрийгөө хамгаалах чадавхыг бий болгоход чухал түлхэц өгнө.

Хот, хөдөө орон нутгийн хөгжлийн ялгааг багасгах, төвлөрлийг сааруулах, үндэсний эдийн засгийн өсөлт, хуримтлалын чадавхыг нэмэгдүүлэх, газарт түшиглэсэн гадаадын хөрөнгө оруулалтыг байршуулах зэрэг стратегийн

⁷ Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны 2020.02.17-ны өдрийн үзүүлэлт;



үндэсний зорилтуудын хэрэгжилт нь эцсийн дүндээ орон нутагт орон нутгийн хамгаалалтыг амжилттай бүрдүүлэх, орон нутагт байрлаж буй Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын сургалт, бэлтгэл, материал, хэрэгслийн хангалтад ч эерэг нөлөө үзүүлэх юм.

Түүнчлэн хөдөө, орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх хүрээнд хэрэгжүүлэх хүний хөгжлийн бодлогын үр дүнд төв рүү чиглэсэн их нүүдэл тодорхой хэмжээгээр саарч, хүн ам бүс нутгуудад харьцангуй жигд таран суурьших нөхцөл бүрдэн, улмаар дайчилгааны нөөц бүрэлдэхүүн, цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг орон нутагт жигд тараан байршуулах нөхцөл бий болох юм.

Ер нь аливаа улс орон өөрийн хөдөө, орон нутгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогодоо батлан хамгаалах эрх ашгийг заавал нухацтай тооцдог ба энэ нь эргээд улс орны тогтвортой хөгжлийн баталгаа болдог зүй тогтолтой байдаг. Хөдөө, орон нутагт байрлаж буй цэргийн нэгтгэл, анги, салбарыг зарим төрлийн материал хэрэгслээр хангах асуудлыг орон нутгийн хамгаалалтын удирдлага, зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэж байх санал байдгийг үндэслэлтэй, ач холбогдолтой гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Түүнчлэн улсын болон орон нутгийн хөгжил, аймаг, нийслэлийн өрсөлдөх чадвар, хүний хөгжил, орон нутгийн хөгжилд Зэвсэгт хүчний оруулж болох хувь нэмрийн талаар авч үзэх хэрэгтэй. Ингэхийн тулд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, бүс нутаг, хот байгуулалтын уялдаа, байгаль орчны тогтвортой байдлыг хангах замаар орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг бүсчилсэн байдлаар тодорхойлж⁸, хөгжлийн төлөвлөлт хийсэн байх шаардлагатай байна.

Орон нутгийн хамгаалалтад үндэслэсэн батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бий болгохдоо аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй албадыг орон нутагт бэхжүүлэх, бүсчилсэн хөгжлийн удирдлага,

хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хүний хөгжил, бүсийн эдийн засаг, нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд анхаарч, энэ хүрээнд орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах юм.

Иргэдийн чинээлэг аж амьдралын урьдчилсан нөхцөл нь эдийн засгийн тогтвортой өсөлт тул орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, зорилго, зорилтуудыг гадна талдаа дэлхий ертөнцөд гарч буй эдийн засаг, улс төр, нийгэм, хүмүүнлэг, соёл, хүн ам зүйн болон шинжлэх ухаан, технологийн орчин нөхцөлд гарч болох өөрчлөлтүүдтэй, дотоод талдаа улс орны өмнө тулгараад буй, цаашид тулгарч болох асуудлуудыг өөрийн орны онцлог нөхцөл байдалд нийцүүлж авч үзэх нь зохистой байна.

Дараагийн нэг асуудал нь орон нутгаа хөгжүүлэхийн тулд Монгол хүн буюу иргэнээ хөгжүүлэх нь чухал асуудал болж хувирчээ. Хүний хөгжил гэдэг нь хүний, эдийн засгийн, нийгмийн, улс төрийн болон соёлын гэх мэт сонголтуудыг өргөжүүлэх үйл явц юм. Хүний хөгжлийн эцсийн зорилго нь улам их баялаг бүтээх эсвэл өндөр түвшинд хүргэхэд бус харин сонголт хийх өргөн бололцоог хүн бүхэнд хүртээх асуудал юм. Хүний хөгжил бол үйл явц хийгээд үр дүн юм. Өөрөөр хэлбэл нэг талаас хүний хөгжил нь сонголтуудыг өргөжүүлэх үйл явц, нөгөө талаас тэрхүү сонголтуудыг өргөжүүлснээр хүргэх үр дүн гэж ойлгож болно. Тийм учраас хүний хөгжил нь ярихад тун энгийн юм шиг ойлголт атлаа алс хэтийн үйл хэрэгт чухал ач холбогдолтой.

Монгол Улсын хүний хөгжил нь батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэлийн үндэс⁹ мөн тул нийт иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах, тэдэнд боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэх, эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх, бие бялдрын хийгээд сэтгэл зүйн бэлтгэлтэй болгох нь орон нутгийн хамгаалалтын бэлтгэлжилтийн үндсэн арга хэмжээ юм. Улс орнуудын хөгжлийг дан ганц эдийн засгийн үзүүлэлтээр хэмжих бус тухайн улсын иргэдийн амьдралын чанар, эдэлж буй боломж, тухайн чанартай

⁸ Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж буй хүчин зүйлсийн судалгаа. (Эдийн засгийн өсөлтөд шууд нөлөө үзүүлж буй хүчин зүйлст хийсэн дүн шинжилгээ) 2016 он. 101 тал;

⁹ Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс. 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт;



амьдралд хүрэх эрх чөлөөг нь харгалзан хэмждэгээрээ хүний хөгжлийн индекс онцлог юм.

Монгол Улс 2018 онд 92 дугаар байрт жагсаж, хүний хөгжлийн өндөр үзүүлэлттэй орнуудын тоонд багтсан авч ижил бүлгийн орнуудаас гурав дахин бага орлоготой байна. Мөн нийгмийн тэгш бус байдлыг харгалзуулан авч үзвэл бидний 92 дугаар байрны үзүүлэлт даруй 14 хувиар буурна¹⁰. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад орлогын тэгш бус байдал их гэсэн үг юм. Хамгийн их орлоготой 20 хувь нь хамгийн бага орлоготой 20 хувиасаа дунджаар 5 дахин их орлогын зөрүүтэй байдаг.

Монголчуудын дундаж наслалт 69.5 ба энэ нь хүний хөгжлийн маш өндөр орны үзүүлэлттэй орнуудын дундажтай харьцуулахад даруй 10 жилээр бага байгаа юм. Бид дунджаар 15.5 жил суралцдаг бөгөөд энэ нь хүний хөгжлийн маш өндөр үзүүлэлттэй орнуудаас дөрвөн жилээр бага, дундаж үзүүлэлттэй орнуудтай харьцуулахад гурван жилээр илүү ажээ¹¹. Тийм учраас хүнээ хөгжүүлэх замаар орон нутгаа хөгжүүлэх, үүнд цэргийн бид бүхэн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах нь зүйтэй юм.

Хөдөө, орон нутагт иргэдийг эрүүлжүүлэх, боловсрол, мэргэжил эзэмшүүлэх, хүүхэд залуусыг цэрэг-эх оронч үзлээр хүмүүжүүлэх зорилго бүхий олон төрлийн арга хэмжээнүүдийг батлан хамгаалах чадавхыг дээшлүүлэх шаардлагатай уялдуулан зохион байгуулах нь чухал байна.

Тэгээд ч орон нутгийн хамгаалалтын зорилго нь орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах, улсын батлан хамгаалах хүчин чадлыг нэмэгдүүлэх, түүний дотор Зэвсэгт хүчний байгуулалтын шинэчлэлийг дэмжих нөхцөлийг бүрдүүлэхэд орших юм.

Орон нутгийг хөгжүүлснээр хөгжлийн төлөвлөлтийг боловсронгуй болгож, хөгжлийг түргэсгэх, эдийн засгийн өсөлтийг хөгжлийн хүчин зүйл болгох, хөдөө нутагт мэдлэгт суурилсан эдийн засгийн үндсийг тавих, хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгах, мөн

түүнчлэн орон нутгийн хамгаалалтын хүч хэрэгсэл, нөөцийг бүрдүүлэх, сургалт бэлтгэлийг тасралтгүй явуулах зэрэг ач холбогдолтой юм.

Аймаг, орон нутгийн өнөөгийн байдал судалгаа хийж үзэхэд орон нутгийн хөгжил нь харилцан адилгүй байна. Тухайлбал байгалийн баялаг, хилийн боомт (урд хөршийн) бүхий өмнөд чиглэлийн аймгуудад уул уурхай түлхүү хөгжиж, түүнийгээ дагаад цахилгаан, төмөр болон авто зам, дэд бүтцийн ажлууд хийгдэж байна. Харин хотоос алслагдмал, байгалийн баялаг багатай, хил залгаа аймгуудад хөгжил тааруу, бараа бүтээгдэхүүний үнэ өндөр байна. Цаашдаа Монгол Улсын стратегийн чиглэлийг дайран өнгөрч буй аймгуудын хөгжлийг төлөвлөж, дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлуудыг явуулахдаа батлан хамгаалах эрх ашигт нийцүүлж хийвэл орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангахад түлхэц болно.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон нутгийн хамгаалалтыг аймагтаа зохион байгуулах замаар батлан хамгаалах эрх ашгийг хамгаалах, батлан хамгаалах үйл хэрэгт хувь нэмрээ оруулж байгаа явдал юм.

Дүгнэлт: Орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулахад аймаг, орон нутгийн хөгжлийн түвшин, газар зүйн байршил, хүн ам, аж амьдралын онцлог, эдийн засгийн чадавх нь нөлөөлж байна. Тухайлбал төвийн бүсийн аймгууд нь санхүүгийн хувьд харьцангуй бие даасан, төрөл бүрийн сургалт явуулах материаллаг баазтай ойрхон байрладаг, улсын чанартай авто болон засмал замаар холбогдсон зэрэг хүчин зүйлс нь орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, нөөцийг бүрдүүлэхэд хялбар, сургалт явуулахад таатай нөлөө үзүүлж байна.

Харин өмнөд бүсийн зарим аймгууд нь төв орон нутгаас хол, гадны улс оронтой хиллэдэг, хүн ам сийрэг, дэд бүтэц, зам харилцаа сул хөгжсөн зэрэг нь орон нутгийн хамгаалалтын зохион байгуулах, бэлтгэлийг хангахад сөргөөр нөлөөлж байна. Иймд хил залгаа зарим аймгуудын хөгжлийг төрийн бодлогоор дэмжих,

¹⁰ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Монгол Улсын хүний хөгжлийн 2018 оны индекс;

¹¹ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн 2018 оны тайлан;



тэнд хийгдэх бүтээн байгуулалтын ажлыг батлан хамгаалах эрх ашигт нийцүүлэх, орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх нь чухал байна.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нар

орон нутгийн хамгаалалтыг аймагтаа зохион байгуулж байгаа нь Монгол Улсын батлан хамгаалах эрх ашгийг хамгаалах, батлан хамгаалах үйл хэрэгт хувь нэмрээ оруулж байгаа явдал юм.



БНХАУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХ БОЛОВСРОЛЫН ЧИГ ХАНДЛАГА

Х.ОРХОНЧИМЭГ /БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)/

Түлхүүр үг: Үзэл санаа, Зорилго, Бүх нийтийн батлан хамгаалах боловсрол

Key words: Ideas, Goals, Universal defense education

Өнөөдөр дэлхий дахины шинжлэх ухаан, технологи, улс төр, нийгмийн өөрчлөлтүүд нь улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлыг ойлгож мэдрэн, аливаа асуудлыг оновчтой шийдвэрлэх чадвартай, тогтсон байр суурьтай, боловсролтой иргэдийг бэлтгэн төлөвшүүлэхийг шаардаж байна.

Аливаа улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь ард иргэддээ эх орноо батлан хамгаалах үзэл, ур чадвар хэрхэн төлөвшүүлсэнээс хамаарна. Тухайн улсын ард иргэдэд эх оронч, үндэсний үзэл, итгэл үнэмшил, төлөвшил, батлан хамгаалах боловсрол эзэмшүүлснээр аюулгүй байдлаа хангах нэг нөхцөл бүрдэх учиртай.

БНХАУ батлан хамгаалах боловсролын хууль боловсруулан мөрдөж, бүх нийтэд системтэйгээр олгож байна. Ингэснээр улсын дотоод аюулгүй байдлын үндсийг бүрдүүлнэ гэж үзэж, ард иргэдийн бэлтгэл сургуулийг шат шатанд нь хангаж буй бөгөөд манай улсын тухайд дэлхийн улс орнууд тэр дундаа хөрш орнуудын боловсролын агуулга, туршлагыг судлах нь чухал ач холбогдолтой. Иймд энэ өгүүлэлд БНХАУ ард иргэдээ эх орноо батлан хамгаалах боловсролыг хэрхэн олгож буй чиг баримтлалын онцлогийг гаргахаар зорив.

Батлан хамгаалах боловсрол ердийн ба төвлөрсөн боловсрол гэсэн 2 хэлбэртэй.

БНХАУ-ын "Улсын батлан хамгаалалтын боловсролын хууль"-ийн 4 дүгээр заалтад "ердийн (тогтмол) боловсрол ба төвлөрсөн боловсролыг уялдуулах, түгээх, замаар гол үзэл баримтлал болгон боловсролын онолыг боловсролын үйл ажиллагаатай уялдуулах зарчим болгоно"¹ хэмээн заажээ. Иймд ердийн (тогтмол)

боловсрол ба төвлөрсөн боловсрол тэдгээрийн уялдаа холбооны тухай тодруулан авч үзье. Энэ тухайд "Улсын батлан хамгаалалтын боловсролыг олгохдоо ердийн боловсрол ба төвлөрсөн боловсролын хоёр хэлбэрийг уялдуулах нь чухал ач холбогдолтойг онцлон дурджээ. Энэ 2 боловсролын гол зорилго нь:

1. Ердийн (тогтмол) боловсрол бол радио телевиз, кино жүжиг, сонин сэтгүүлд улсын батлан хамгаалахын боловсролын хөтөлбөр, үзэл санааны чиглэлийг тогтмол сурталчлах замаар боловсролын хүртээмжийг дээшлүүлж, хүмүүсийн амьдрал ахуйд байнгын хэвшмэл мөрдлөг болгож, ард иргэдийн эх орноо батлан хамгаалах мэдлэг, ур чадварыг үр дүнд хүргэнэ.
2. Төвлөрсөн боловсрол бол тухайн агуулгыг улсын батлан хамгаалахын үйл ажиллагаатай уялдуулж, боловсролын суралцах ангийг байгуулж, дайчлалтын хэлбэрийг батлан хамгаалалтын онол мэдлэгийн боловсролтой холбох замаар үр дүнд хүргэхэд оршино. Төвлөрсөн боловсролын хэрэгцээг хангасан төслийг явуулж, боловсролын зорилго, агуулга, эрэлт хэрэгцээ ба стандартад нийцүүлж, боловсролын үр дүнг аажмаар ил тод болгох хэрэгтэй гэж тус тус заажээ.

Дээрх 2 боловсролын харилцан уялдааг "ердийн (тогтмол) боловсрол ба төвлөрсөн боловсрол 2 бол харилцан нөхцөлдсөн бүхэл бүтэц мөн. Хоёр талаараа харилцан салж болшгүй. Ердийн (Тогтмол) боловсрол бол төвлөрсөн боловсролын үндэс суурь мөн. Төвлөрсөн боловсрол бол ердийн

¹ 全民国防教育.读本.北京.2009.页90.



(тогтмол) боловсролыг хэрэгжүүлэх гарц. Ердийн боловсролыг нийт ардад улсын батлан хамгаалалтын үзэл бодлыг буй болгох урьдал нөхцөл болгох юм. Хэрвээ төвлөрсөн боловсрол байхгүй бол улсын батлан хамгаалалтын онол ба улсын батлан хамгаалалтын мэдлэгийн боловсролыг системтэйгээр явуулах аргагүй юм. Улсын батлан хамгаалалтын үзэл баримтлалыг олгох үйл явцыг шат дараатайгаар зохион байгуулахдаа хөгжлийн зорилттой уялдуулж, нийгэм, эдийн засгийн өсөлттэй холбож чадахгүй бол улс орны батлан хамгаалах үйл ажиллагааны эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй юм. Гагцхүү ердийн (тогтмол) боловсролыг төвлөрсөн боловсролтой уялдуулж байж үндэстэй нэвтрүүлэхгүй бол улс орныг батлан хамгаалах зорилтод үйлчлүүлж чадахгүй юм. Ердийн (тогтмол) боловсролыг төвлөрсөн боловсролтой яаж уялдуулвал зохих вэ?. Нэг талаар үр дүн ба шийдэх арга барилын хоорондын диалектик харьцааг зохицуулж, харилцан дээшлүүлсэн нөхцөлөөр холбогдох юм. Үүнээс гадна орон зайн зөв хувиарлалтаар боловсролын үүргийг зохистой хослуулсан ердийн (тогтмол) боловсрол ба төвлөрсөн боловсролын харилцан нөхцөлдөх зүй тогтлыг хайх нь чухал юм² хэмээн тодотгожээ.

Боловсрол талаас нь харвал батлан хамгаалах боловсролыг бүх нийтийн болон үндсэн боловсрол хэмээн хоёр төрөлд хувааж болно. Бүх нийтийн боловсролын агуулгад нийт иргэдэд олгох боловсролыг оруулж, үндсэн боловсролын агуулгад анги, байгууллага, нэгжүүдэд олгох боловсролыг багтаан авч үзсэн байна. Үүнд:

"Бүх нийтийн боловсрол бол нийт ардад явуулах боловсрол мөн. Агуулгад нь улсын батлан хамгаалалтын бүтээн байгуулалт ба цэрэг дайны онол, мэдлэг, чадварыг оруулдаг. Мөн эх оронч үзэл, улсын батлан хамгаалалтын хуулийн дүрэм, "Гурван сэргийлэлт" (Цөмийн зэвсэг, хэт даврагчид, дайсны цэргийн гэнэтийн довтолголт)-ийн мэдлэгийн боловсролыг багтаадаг байна.

Үндсэн боловсрол бол анги бүлгэм,

байгууллага нэгжүүдэд олгох боловсрол. Улсын батлан хамгаалалтын бүтээн байгуулалт ба дайны тусгай онолын мэдлэг, чадварыг олгоно. Жишээлбэл төрийн байгууллагын ажилтан, удирдах албан тушаалтан, өрхийн цэрэг, бэлтгэл алба хаагчид, их дээд, дунд сургуулийн сурагчид ба ардын чөлөөлөх арми, зэвсэгт хүчний армийн дарга дайчид, улсын батлан хамгаалалтын цэргийн үйлдвэрлэлийн шинжлэх ухаан технологийн байгууллага ба үйлдвэрлэлийн нэгжийн ажилтнуудад олгоно.

Бүх нийтийн боловсрол ба үндсэн боловсрол хоорондоо нягт уялдаатай. Бүх нийтийн боловсрол урт хугацаанд олгогдоно.

Бүх нийтийн боловсрол байхгүй бол улсын батлан хамгаалалтын боловсролын үндэс суурь үгүй гэсэн үг юм. Улсын батлан хамгаалалтын үзэл санаа, улсын батлан хамгаалалтын зорилгыг ард нийтийн ухамсарт шингээж чадахгүй юм.

Үндсэн боловсрол бол бүх нийтийн боловсролын суурин дээр боловсролыг дээшлүүлэх арга зам юм. Үндсэн боловсролыг явуулж чадаагүй бол тэдгээр онцгой бүлгэм ба ажилтанд үүрэг хариуцлага оногдуулж чадахгүй юм. Улс орноо хамгаалах мэдлэг боловсролыг хэрэгтэй цаг үедээ олгож чадахгүй бол үр дүн гарахгүй юм. Түүнчлэн улсаа батлан хамгаалах үүргээ хариуцлагатайгаар биелүүлэх чадвар алдагдана. Иймд батлан хамгаалах боловсролыг "Улсын батлан хамгаалалтын боловсролын хууль"-д тогтоосон заалтын ёсоор бүх нийтийн боловсрол ба үндсэн боловсролыг бодит байдалтай уялдан тохирсон бүтцийг бүрдүүлэх хэрэгтэй³ хэмээн тодорхойлон бичжээ.

Батлан хамгаалах боловсролын агуулгыг дотор нь онолын боловсрол ба практик боловсрол гэсэн хоёр талаас нь авч үзэж оруулж болох юм. Онолын боловсролын агуулгад улсын цэргийн байгуулалтын онол, мэдлэг, хууль эрх зүй, дайны онол, тактик техникийн онол, цэрэг дайны шинжлэх ухаан технологийн онол зэргийг багтаадаг.

Практик боловсролд цэргийн байгуулалт, дайны бэлтгэл, дасгалжуулалт, хээрийн сургуулилт зэрэг болно.

² 全民国防教育.读本.北京.2009.页90.

³ 全民国防教育.读本.北京.2009.页91.



Онолын боловсрол ба практик боловсрол нь хоорондоо харилцан холбоотой нэгдмэл бүтэц мөн. Улсын батлан хамгаалалтын онолын боловсролыг практик боловсролоос тусдаа авч үзвэл үндэслэлгүйн дээр онолын хоосон хийсвэрлэл болох юм. Түүнчлэн онолын боловсрол бодитой болохгүй.

Улсын батлан хамгаалалтын үйл ажиллагааг онолын боловсрол дээр суурилахгүй бол практик боловсрол үр дүнгүй болно. Гагцхүү онолын боловсрол ба практик боловсролыг хооронд нь нягт уялдуулах юм бол улсын батлан хамгаалалтын боловсролын зөв оновчтой чиг баримтлалыг бий болгож чадна.

Онолын боловсрол ба практик боловсролын уялдааг хангахад диалектик харилцааг харгалзах хэрэгтэй. Хэрвээ онолыг анхаараад тактикийг анзаарахгүй бол онол хэдий сайн байлаа ч хэрэглээ болохгүй. Иймээс ерийн байдалд практик боловсрол гол болж онолын боловсролд үндэслэж байгаа юм. Практик нь онолыг удирдлага болгодог. Онолын ба практик боловсрол бүгд харилцан холбогдож улсын цэргийн байгуулалт, дайны бэлтгэл, дасгалжуулалт ба дайны бодит хэрэгт зохицуулж, хоёр талын харилцан нөхцөлдөх байдлыг улсын батлан хамгаалалтын боловсролын хөгжилтэй батаас бат холбох нь чухал юм⁴ гэж тодорхойлон бичжээ.

Энэ бүхнийг эцэст нь дүгнэхэд БНХАУ батлан хамгаалах боловсролын хууль боловсруулан мөрдөж, бүх нийтэд батлан хамгаалах боловсролыг системтэйгээр олгож байна.

БНХАУ Батлан хамгаалах боловсролоо ердийн ба төвлөрсөн боловсрол гэсэн 2 хэлбэртэйгээр олгож, ердийн боловсролоор радио телевиз, кино жүжиг, сонин сэтгүүлд улсын батлан хамгаалахын боловсролын хөтөлбөр, үзэл санааны чиглэлийг тогтмол сурталчлах замаар боловсролын хүртээмжийг дээшлүүлж, хүмүүсийн амьдрал ахуйд байнгын хэвшмэл мөрдлөг болгож, ард иргэдийн эх орноо батлан хамгаалах мэдлэг, ур чадварыг үр дүнд хүргэхээр тусгасан бол төвлөрсөн боловсролоор батлан хамгаалалтын онол мэдлэгийг боловсролтой холбох замаар үр дүнд хүргэхээр зорижээ.

Батлан хамгаалах боловсролыг боловсрол талаас нь харвал бүх нийтийн болон үндсэн боловсрол хэмээн хоёр төрөлд хувааж бүх нийтийн боловсролын агуулгад нийт иргэдэд олгох боловсролыг оруулсан бол үндсэн боловсролын агуулгад анги, байгууллага, нэгжүүдэд олгох боловсролыг багтаан авч үзсэн байна. Мөн батлан хамгаалах боловсролын агуулгыг дотор нь онолын боловсрол ба практик боловсрол гэж хуваан онолын агуулгад улсын цэргийн байгуулалтын онол, мэдлэг, хууль эрх зүй, дайны онол, тактик техникийн онол, цэрэг дайны шинжлэх ухаан технологийн онол зэргийг багтааж, практик боловсролд цэргийн байгуулалт, дайны бэлтгэл, дасгалжуулалт, хээрийн сургуулилт зэргийг оруулдаг байна.

Улс эх орноо хамгаалах, иргэн бүрийн оролцоог хангасан бэлтгэл сургуулилтыг ийнхүү шат дараатайгаар системтэйгээр олгож байна.

Ашигласан материал:

1. 大学军事理论教程. 龚泗琪. 大学军事理论教材. 电子工业出版社出版的图. 2010年
2. 全民国防教育. 读本. 北京. 2009年
3. 霍凤鸣. 大学生国防教育. 高等教育出版社出版的图书. 2007年
4. 张力. 国防教育. 2007年
5. 大学军事理论常识. 清华大学出版社出版的图书. 2007年
6. 大学军事教程. 人民出版社出版的图书. 2009年
7. 朱建明. 高校军事理论教程. 2009年
8. 孙培雷. 军事理论与军事技能.
9. 张万年. 当代世界军事与中国国防. 2010年
10. 王道伟、李杜卿. 军事文化. 2011年

⁴ 全民国防教育. 读本. 北京. 2009. 页92.



ЦЭРГИЙН ЭМНЭЛГИЙН ГАЗАР ЗҮЙ



С.ЮНДЭН /Анагаах ухааны доктор, профессор, бэлтгэл хурандаа/

Түлхүүр үг: Уулын өвчин, хөлдөлт, наранд цохиулах, усгүйжих хөм шинж, нуралт, дарагдалт, түлэгдэл.

Key words: high altitude disease, frostbite, heat stroke, dehydration, chemical and thermal burn

Товчутга: Цэргийн албанхаагчдын цэргийн хөдөлмөр ахуйг географын хүчин зүйл, онцлогт тохируулан хангах, байлдааны ажиллагааны театр болон тухайн дэвсгэр нутгийн эмнэлэг-газар зүйн онцлогийг цэргийн эмнэлгийн хангалтыг зохион байгуулах нь цэргийн эмнэлгийн газарзүйн ухааны гол зорилт юм. Цэргийн эмнэлгийн газар зүйн судалгааны ойлголтуудыг цэргийн эмнэлгийн практик ажиллагаанд үр дүнтэй ашиглах нь өвчтөн, шархтанг татан гаргах анхны болон яаралтай тусламжийг үзүүлэх, шархтаныг асрах сувилах, эмнэлгийн шат дамжлагуудад тээвэрлэн гаргах зэрэг анги салбаруудын хэмжээнд явагдах байлдааны ажиллагаанд илүү хамааралтай нь манайд мөрдөгдөж байгаа орон нутгийн хамгаалалтын үзэл баримталын үед маш өндөр ач холбогдолтой.

Summary: *The main aspect of medical geography is providing logistical support for military service members depending on working place geographical aspects, specifications is high demand and the main purpose of military medical geography is provide support for battle theatre depending on geography and terrain. To understand concepts of medical health geography will help to provide medical care on ground, medical evacuation for high echelon, medical treatment, rehabilitation and to fully take control over the battle operations, therefore it is very important for us, cause of concept of regional domestic warfare, which is we follow in our country.*

Цэргийн эмнэлгийн газар зүйн

судалгааны үндэс

Цэргийн эмнэлгийн газарзүй гэдэг нь цэргийн бие бүрэлдэхүүний эрүүл мэндийн байдалд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох, түүнчлэн байлдааны ажиллагааны үеэр эмнэлгийн тусламжийг зохион байгуулах, эдгээр нутаг дэвсгэрт цэрэг байршуулах зорилгоор тодорхой нутаг дэвсгэрийн байгаль ба нийгмийн нөхцөл байдлыг судалдаг цэргийн анагаах ухаан болон эмнэлгийн газарзүйн нэгдэл юм.

Тодорхой нутаг дэвсгэрийн цэргийн эмнэлэг-газар зүйн судалгааны зорилго нь судлагдаж буй нутаг дэвсгэрт цэргүүдэд эмнэлгийн тусламжийг хамгийн оновчтой зохион байгуулах талаар зөвлөмж боловсруулахад оршино.

Цэргийн эмнэлгийн газар зүйн судалгааны ойлголтуудыг цэргийн эмнэлгийн практик ажиллагаанд үр дүнтэй ашиглах нь өвчтөнд анхны болон яаралтай тусламжийг үзүүлэх, шархтныг асран сувилах, эмнэлгийн шат дамжлагуудад тээвэрлэн гаргах зэрэг анги салбаруудын хэмжээнд явагдах байлдааны ажиллагаанд илүү хамааралтай нь манайд мөрдөгдөж байгаа орон нутгийн байлдааны үзэл баримталын үед маш өндөр ач холбогдолтой.

Анагаах ухааны газарзүйн өнөөгийн тулгамдсан асуудлыг судалж үзэхэд анагаах ухаан, экологи, газарзүйн шинжлэх ухааны салбаруудын уулзвар дээр хүн амын эрүүл мэнд ба амьдрах орчны тогтолцоог судлахад салбар хоорондын харилцан үр дүнтэй холбон үзэж байгаа нь энэхүү шинжлэх ухааны хурдацтай хөгжиж байгаатай холбоотой.

Анагаах ухааны газарзүй нь анагаах, экологи, газарзүйн шинжлэх ухааны



уулзвар дээр тэдгээрийн судалгааны үр дүнд суурилан хүн амын эрүүл мэнд, амьдрах орчны тогтолцоог судалдаг шинжлэх ухааны салбар юм. Сүүлийн жилүүдэд энэ салбарын хөгжил хурдацтай явагдаж байна.

Эмнэлзүйн газарзүйн бүсчлэл, загварчлал, хүрээлэн буй орчны чанарын үнэлгээ зэрэг шинэ чиглэлүүдийг хөгжүүлэх нь хүрээлэн буй орчин, нийгмийн эрүүл мэндийн байдалд хяналт тавих бүс нутгийн тогтолцоог бий болгохоос гадна байгаль орчны үр дүнтэй бодлогыг боловсруулахад оршино.

Анагаах ухааны (цэргийн эмнэлгийн) газарзүй нь шинжлэх ухааны салбар болон хөгжсөн түүх

Газарзүйн нөхцөл байдал, ялангуяа байгаль орчны нөхцөл байдал нь хүрээлэн буй орчны хүний эрүүл мэндэд шууд нөлөөлдөг хамгийн их нөлөө бүхий хүчин зүйлүүдийн нэг юм. Энэ баримтыг эмч нар эрт дээр үеэс мэддэг байсан. Тиймээс аль хэдийн Гиппократ (МЭӨ460-377) "Агаар, ус ба хөрсний тухай" номондоо байгаль орчны хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл ба өвчинтэй хэрхэн холбоотой талаарх ажиглалт, онолын хэлэлцүүлгийг гаргасан байдаг. Хожим нь "хүрээлэн буй орчны онол" -ыг Аристотель философийн үүднээс боловсруулан авч үзсэн байдаг.

Удаан хугацааны туршид, өвчний тархалтын талаарх мэдээлэл болон хүний өвчний өвөрмөц шинж тэмдгүүдийн улс (нутаг дэвсгэр) хоорондын ялгааны талаарх мэдээлэл ихээр хуримтлагдсан байв. Улс орон, тив хоорондын харилцаа хөгжихийн хирээр анагаах ухаан, газарзүйн нөхцөл байдал өөрчлөгдөж, урьд өмнө мэдэгдэж байгаагүй өвчлөлийн хэлбэрүүд гарч, тивүүдийн хооронд "өвчний солилцоо" явагдаж байв. Энэ бүх хуримтлагдсан материалыг нэгтгэх, дүн шинжилгээ хийх шаардлага бий болсон. Мөн анагаах ухаан, газарзүйн асуудлуудыг илэрхийлсэн шинжлэх ухааны бүтээлүүд хэвлэгдэж байв.

Европ дахь анхны анагаах ухаан-газарзүйн судалгаа нь 18-р зууны дунд үеэс эхэлдэг (Гевитт, 1754; Прингл, 1746). Эдгээр нь голдуу колоничлолын нутаг дэвсгэр эсвэл цэргийн ажиллагаа

явагдахаар төлөвлөж буй бүс нутагтай холбоотой анагаах ухаан-газарзүйн тайлангууд байв. 1792-1795 онуудад анагаах ухааны газарзүйн талаарх анхны гурван боть гарын авлага (Л. Финке) хэвлэгдсэн нь нэгэнт шинжлэх ухааны бие даасан салбар болж, эцсийн хэлбэрт шилжсэнийг гэрчилсэн юм.

Цэрэг дайны арвин баялаг туршлагатай монгол цэргийн түүхэн баримтуудад цэргийн ба цэргийн эмнэлгийн газар зүйтэй холбоотой тэмдэглэгдэж үлдсэн олон зүйл бидний үед хүрч ирсэн байна. Цэргийн түүхч доктор Х.Шагдар дайн тулааны ялалтыг монгол цэргүүдийн байгальд зохицох хатуужил тэвчээртэй холбон, үүний жишээнд Зэв, Сүбгэгдэй нарын Тэнгэр уул, Кызылкумын цөлийг туулсан 8000 км-ын аялан байлдааныг нэрлэжээ.

Цэрэг дайны ажиллагааны стратеги, тактикт байгаль цаг уур, газар зүйн нөхцөл, хүн ам, үндэстний болон нийгэм-эдийн засгийн онцлог зэргийг тусгах асуудалд нэн чухал. Түүхэн дайн тулааны үеийн газар зүй, цаг агаарын хүчин зүйл байлдаж байгаа бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, анги салбаруудын байлдах чадварт хэрхэн нөлөөлөх талаар судалгаа дэлхийн том дайнуудын туршлага харуулдаг. Дэлхийн I, II дайн, Английн Энэтхэгт хийсэн аян дайн, Вьетнамын дайн, Кавказын бүсэд болсон цэргийн ажиллагаа, Африк тивд хэрэгжүүлж байгаа энхийг сахиулах ажиллагаа зэрэг Арабын хойгийн үйл явдал зэрэг олон жишээнд дээр хийх эмнэлэг газар зүйн судалгаа шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой. Цэргийн эмнэлгийн хангалтыг байлдааны ба тайван цагт зохион байгуулахад эмнэлэг газар зүйн шинжлэх ухааны ололтуудыг нэвтрүүлэх ажил дэлхийн II дайны үед эрчимтэй өрнөж байсан нь ЗХУ-д эх орны дайны түүхэн ялалтыг авчрахад чухал үүрэгтэй байсан гэж судлаачид үздэг.

1937 оны үеэс Японы зүгээс Монгол улсын нутаг дэвсгэрт хийсэн удаа дараагийн халдлагын үеэр худаг ус хордуулах, халдварт өвчин тараах үйлдлүүдийг Японы талаас удаа дараалан хийж байсан бөгөөд 1945 оны чөлөөлөх байлдаанд Говь-Хянганы нурууг туулсан хүнд бэрх маршийг хийж Долнуур



Жэхе хотуудыг чөлөөсөн нь уулын аялан байлдах экспедицийн туршлага болсон. Ердийн хөсөг уналга, ачлагыг уулийн бүсийн байлдааны ажиллагаанд ашиглахын давуу талыг харуулсан нь одоо ч ач холбогдлоо алдаагүй. Орчин үед уулын, цөлийн зэрэг өвөрмөц газар зүйн нөхцөлд, зарим улс орны цэргийн ажиллагааны практикт ердийн хөсгийг машин техникийн оронд ашиглах дадлага сургуулилт хийсээр байна. Үүний нэг тод жишээ нь 2019 онд манай оронд явагдсан "Морин марафон" цэргийн олон улсын тэмцээн билээ.

Манай орны зарим нэгэн газар нутгийн болон цаг агаарын онцгой нөхцөл дэх эмнэлэг газар зүйн онцлогууд:

Монгол орны хувьд өргөн уудам нутаг дэвсгэр, хүн амын сийрэг суурьшилт, хотууд дахь хүн амын төвлөрөл, дэд бүтцийн хөгжил ба эдийн засгийн хөгжлийн түвшин ба хүчин чадал харьцангуй сул, газар зүйн бүсүүдийн ба цаг уурын ялгаа зааг их, газар нутгийн хувьд дэлхийн хүчирхэг хоёр гүний хүрээлэлд оршдог, шатахуун болон эрчим хүчний хувьд тэднээс хамаарал ихтэй, эдийн засгийн зарим үзүүлэлтээр Хятад улсаас хамааралтай, армийн бие бүрэлдэхүүний тоо цөөн, шинэ төрлийн зэвсэглэл, техникийн хангамж бага зэрэг олон онцлогийг дурьдаж болно.

Нөгөөтэйгүүр төвийг сахисан энх тайван ч улс төрийн бодлоготой, монгол цэргийн байгальд дасан зохицох чадвар, бие бэлтгэл, тэсвэр хатуужлийн хувьд сайн, зэвсэгт тэмцлийн онол хэрэгжээд орон нутгийн ажиллагаанд хэвшиж буй нөхцөл, үндэстний болон шашны ялгаа зааг бага зэрэг эерэг талууд байна.

Цэргийн эмнэлгийн газар зүйн судалгааны ойлголтуудыг цэргийн эмнэлгийн пратик ажиллагаанд үр дүнтэй ашиглах нь өвчтөн шархтай хүмүүсийг татан гаргах анхны болон яаралтай тусламжийг үзүүлэх, асрах сувилал, эмнэлгийн шат дамжлагуудад тэвэрлэн гаргах зэрэг анги салбаруудын хэмжээнд явагдах байлдааны ажиллагаанд илүү хамааралтай нь манайд мөрдөгдөж байгаа орон нутгийн байлдааны үзэл баримтлалд маш өндөр ач холбогдолтой юм.

Уулын бүсийн эмнэлэг газар зүйн онцлог. Уулын бүсийн онцлог нь

бартаа ихтэй учир авто тээврийн хэрэгсэл ашиглах боломж бага, үзэгдэх орчин хязгаарлагдмал, нисдэг тэрэг мэт агаарын тээврийн дайсанд хөнөөгдөх магадлал ихтэй, хүн амын суурьшил бага, холбооны хэрэгслийн хүчин чадлыг бүрэн ашиглах боломж хязгаарлагдмал, зам харилцаа муу, өдөр шөнийн температурын зөрөө ихтэй зэрэг нөхцөлийг эмнэлгийн хангалтад зайшгүй тооцох шаардлага үүсдэг. Уулын районд байлдааны ажиллагаа явуулсан туршлагаас нийт бие бүрэлдэхүүний 20% нь байлдааны бус гэмтэл бэртэл, өвчлөлд нэрвэгддэг гэсэн судалгаа байгаа нь байлдааны бус эмнэлгийн хохирлын дундаж үзүүлэлтээс хоёр дахин өндөр байгаа нь анхаарал татаж байна.

Ийм нөхцөлд өвчтөн шархтанд эмнэлгийн тусламж үзүүлэх, татан гаргах нөхцөл эрс хүндрэх тул анхан шатны ба яаралтай тусламжийг шат ахиулан үзүүлэх нөөц, эмнэлгийн тусламж үзүүлэх үүрэг хүлээсэн цэрэг ба ариун цэврийн зааварлагч эмч нарын мэдлэг, дадлага, чадварын төвшин өндөр байхаас эмнэлгийн хангалтын үр дүн шууд хамааралтай. Уулын нөхцөлд байлдааны ажиллагаа явуулахад өөд газар авирах, хувийн болон бусад бүх зэвсэг, галт хэрэгслийн нөөц, хүнс оромж болон явган байлдахад шаардлагатай бусад бүх ачааг хувааж үүрэх тул хүний биеийн хүчний ачаалал эрс ихсэж, хоногийн энерги алдагдал 4000-4500 ккал хүрнэ. Афганистанд хийсэн дайны туршлагаас харахад 7-10 хоногийн уулын байлдааны төгсгөлд бие бүрэлдэхүүний 40-50%-д биеийн жингийн алдагдал 5-10кг хүрч байсан байна. Өндөр уулын бүсэд байдлааны ажиллагаа явагдах үед урьд илрээгүй зүрх судасны архаг өвчин сэдэрх явдал даргалах бүрэлдэхүүн буюу 40-өөс дээш насны хүмүүст илрэх нь элбэг тохиолдоно.

Уулын нөхцөл хүний биеийн нөлөөлөх шалтгаан дунд хүчилтөрөгчийн дутмагшил онцгой байрыг эзлэнэ. Хүчилтөрөгчийн хангамж хүний биед буурах нь бүх эрхтэнүүдийн хүчилтөрөгчийн өлсгөлөнг үүсгэх ба ялангуяа төв мэдрэлийн тогтоцоонд илүүтэй нөлөөлнө. Энэ үе даралт ихсэх, зүрх дэлсэх, хөдөлгөөний



идэвхи сулрах, ядрах, огих, хамраас цус гарах шинжүүдээр илрэх бөгөөд 5-10 энэ шинжүүд хоногийн дараа аажмаар илрэнэ. Далайн түвшнээс 2500 м-ээс дээш өндөрт бие бүрэлдэхүүний 20-25%-д "уулын өвчин" үүсэх бөгөөд ялангуяа десантын болон агаарын тээврээр авчирсан бүрэлдэхүүний дунд илүүтэй хүндээр илэрч, зүрх судасны цочмог дутмагшил, гипоксийн гаралтай комоор хүндрэн нас барах аюултай. Уулын өвчин үргэлжлэх үед уушигны хийн солилцооны үзүүлэлт өндөр байхаас гадна, эритроцитоз, гемоглобины хэмжээ өссөн үзүүлэлттэй байдаг.

Агаарын парциаль даралт буурах үед сапрофит анаэроб микробын идэвхижил ихсэж, шарх халдварлагдах, эдийн тэжээллэг буурах зэрэг нь шархны эдгэрэлт болон шархтаны биеийн засралд муугаар нөлөөлж эхний 3-5 хоногт багтан эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламжийг бүрэн хэмжээгээр үзүүлээгүй тохиолдолд хүндэрч нас барах аюултай.

Эмнэлгийн хангалтын ажиллагаанд уулын эмнэлэг-газар зүйн нөхцөл олон талаар нөлөөлнө. Юуны өмнө өвчтөн шархтныг эрж хайх, цуглуулах ажил хүндрэлтэй 2-3 дахин удаашралтай явагдах бөгөөд шархтанг ийм нөхцөлд галын шугамаас татан гаргахад буудагч-зөөгч, ариун цэврийн зааварлагч нараас биеийн хүчний маш их ачаалал шаарддаг. Иймээс шархтанд анхны тусламж ба эмчийн тусламж үзүүлэх цаг оройтох, эмнэлгийн тусламж үзүүлсэн хүмүүсийн тоо буурах зэрэг сөрөг үзүүлэлтүүд нь эмнэлгийн хангалтын үр дүнд муугаар нөлөөлнө.

Уул хавцлын экран үүсгэх нөлөө нь холбооны хэрэгсэл ашиглах бололцоог эрс бууруулж, удирдлагын арга хэмжээнд саад учруулна. Уулын нөхцөлд байлдааны ажиллагааны үед үүссэн өвчтөн шархтны 80%-ийг зөөх түших зэрэг аргаар татан гаргах шаардлагтай болох бөгөөд зөөгч асрагч, ариун цэврийн зааварлагчдын хурд цагт 0,5-1км хүртэл удаашрна. Эгц уруу өгсүүр газарт нэг шархтанг 3-4 хүн зөөх тохиолдол элбэг. Иймээс нэг салбарын ариун цэврийн зааварлагчид 6-8 хүн, батальонд 20-30 хүн зөөгч асрагчаар нэмж тусалцуулах шаардлага үүснэ. Автотехникийн дундаж хурд 15-25км/цаг, зарим хэсэгт 5-10км/цаг байна.

Энэ тооцооноос үзэхэд нэг машины хоногийн гүйлт нь 60-80км-ээс илүүгүй гэж тооцно. Энэ нь эмнэлгийн татан гаргалтын хугацааг сунгаж, өвчтөн шархтны эмнэлгийн үе шатлалын тусламж оройтсоноос гарах хүндрэл бэрхшээлийн шалтгаан болно. Зам комендантын постуудтай харилцан ажиллах, татан гаргалтын 2-3 цаг тутамд бүлээцүүлэх цэргийг байгуулах шаардлага ч үүснэ.

Говь талын эмнэлэг газар зүйн онцлог. Тал хээр, говь цөлийн газар зүйн нөхцөл нь манай орны нутаг дэвсгэрийн голлох онцлог бөгөөд ихэвчлэн газар зүйн ийм районд байлдааны ажиллагаа явуулах талууд эрмэлздэг.

Говийн районд өдөртөө 45°C хүртэл халах нь ердийн үзэгдэл бөгөөд майхан, авто-хуягт техник дотор халуун 55-60°C хүртэл хална. Газрын хөрс, элс чулуурхаг гадарга 70°C хүрч халах бөгөөд авто-хуяг техник бусад хэрэгслийн металл гадаргуу 80°C хүртэл хална. Харин өвлийн цагт говьд 50°C хүртэл хүйтрэнэ. Иймээс энэ бүсэд нарших буюу наранд цохиулах, наранд түлэгдэх, ангах хуурайших, усгүйжих хам шинж нилээд элбэг тохиолдоно. Харьцангуй чийлэг дунджаар 20%. Жилийн дундаж атмосферийн тундас 250мм-ээс бага, өдөр шөнийн температурын хэлбэлзэл нь 40-20°C байх тохиолдолд шөнөдөө даарах, салхи цохих зэрэг эмгэгүүд элбэг тохиолдоно. Цөлийн районд шороон ба элсэн шуурга элбэг тохиолдоно.

Хүн амын суурьшил 1км² газарт 1-2 хүн оногдох боловч зарим баян бүрдэд хүн амын бөөгнөрөл нягт байдаг ба мал амьтны бөөгнөрөл нэмэгдэж халдварын эрсдэл нэмэгддэг. Замын тэмдэглэгээ баримжаа муу, элстэй хэсэгт авто хөсгийн туулах чадвар буурах зэрэг нь цэргийн хөдөлгөөн, цэргийн эмнэлгийн хангалтад сөрөг нөлөөтэй.

Хүний биеийн дасан зохицох урвалд температурын нөлөө, ус-эрдсийн солилцооны хямрал, цусны эргэлтийн өөрчлөлт, шээс ялгах тогтолцоо голлон өртөнө. Говь-талын газар зүйн орчинд биеийн жингийн алдагдал ихэнхи цэргийн албан хаагчдад ажиглагдах бөгөөд хоногт 12л хүртэл усаар шингэний дутагдлыг нөхөх шаардлага тулгардаг. Наранд



цохиулах, наршилтын үед зүрх судасны тогтолцооны хямрал нь даралт ихсэн, цус өтгөрөх, тархины ба зүрхний цусан хангамжийн хямралтай холбоотой тархины хаван, цус харвах, цус хомсрох, зүрхний шигдээс зэрэг хүндрэлд хүргэх аюултай. Мөн хоол боловсруулах ба дотоод шүүрлийн тогтолцооны хямрал үүсэх нь элбэг тохиолдоно.

Халуун ба нарын туяа, хүйтний нөлөөнд арьс хуурайших, түлэгдэх, хөлдөх, фотохаршил, салстын гэмтэл нүдний өвчин, хамраас цус алдах уруул амны салт хагарах шинжүүд илрэнэ. Шороон ба элсэн шуурганы үер нүдний салст гэмтэх, блефарит, амьсгалын дээд замын өрөвсөл, ринит, фарингит, бронхит үүсэх ба энэ нь олныг хамарсан ослын хэмжээнд хүрч бие бүрэлдэхүүний 75% нь жагсаалаас гарч байсан гашуун туршлага байдаг бөгөөд өвлийн улиралд хөдлөх, осгох, даарах зэрэг шалтгаанас үүсэх өвчлөл ч дээрх хэмжээний хохирол үүсгэх аюултай.

Говь талын бүсийн ургамлын төрөл зүйл дотор харшил үүсгэгч ургамлууд элбэг учир полиноз, конъюнктивит, дерматит үүсгэх нөлөөтэй.

Эдгээр районд элбэг тархсан мэрэгчид тарвага, зурам, оготон бусад мэрэгчид, арьсны цус шимэгчид, бүүрэг бөөс нь тарваган тахал, хулгана яр, лейшманиоз зэрэг өвчний байгалийн зөөгчид юм. Үүнд халварт өвнүүдээс нэн тэргүүнд холер, балнад, иж балнад, дизентри, гепатит, амёбын ба хачигны реккетсиоз, москитын халуурал, лейшманиоз, гэдэсны шимэгч хорхойн халдварууд хамаарна.

Бие бүрэлдэхүүний эмнэлгийн хангалт нь эмнэлэг-газар зүйн судалгаанд үндэслэн зохион байгуулагдах бөгөөд үүнд цэргийн албан хаагчдын бие махбодийг халууны нөхцөлд дасгах дадлагаас эхлэн, говь талын нөхцөлд үүсч болох эмгэгүүдийн онцлогыг эмнэл зүйн тусламжинд тусгах, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дадлага сургууль, эм хэрэгслийн хангалт, төхөөрөмжийг тооцон зохицуулах, эм хэрэгслийн чанар байдлыг халуун хүйтнээс хамгаалах зэрэг олон талын арга хэмжээ багтана. Цэргийн хүнсэнд монголын уламжлалт хүнс ааруул, хатаасан бяслал, борц зэргийг хэрэглэх, тэдгээрийн нөөцийг цэргийн аранз-

агсамжинд оруулах, витаминжуулах арга хэмжээг ар тал хангалтын бусад албуудтай хамтран хэрэгжүүлнэ. Усыг цэвэршүүлэх агергатуудыг хүнсний технологид оруулж, инженерийн цэргийн ажиллагааг худаг гаргах, усны нөөц нэмэгдүүлэхэд чиглүүлнэ.

Байлдааны ажиллагааны үед галын шугаманд байгаа өвчтөн шархтныг эрж олох, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, халуунаас хамгаалах, цангаа тайлах ажлыг маш хурдан хийх шаардлага үүсдэг. Ялган дугаарлалтын ба өвчтөн шархтан цуглуулах байрыг сүүдрэвчээр халхлах, эмнэлгийн бие бүрэлдэхүүнийг халуунаас хамгаалах, цангаа тайлах, ялангуяа мээ засал, эрчимт сэхээны өрөөг сэрүүцүүлэх арга хэмжээг авах, эмчилгээнд хэрэглэж байгаа дуслын шингэний хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээнүүд багтана.

Говь-талын нөхцөлд эмнэлгийн байрыг өнгөлөн далдлах боломж муу учир энэ талын бэлтгэлийг урьдчилан хангасан байх шаардлагатай.

Галын шугамнаас тэгш тал газар шархтан татан гаргах ажилбар нэн хүндрэлтэй бөгөөд эмнэлгийн бие бүрэлдэхүүний хохирол их гарах магадлалтай учир өнгөлөн далдлалын хувцас хэрэглэл, шархтан татан гаргах хэвтрийн чиргүүл, оосор зэргийг урьдчилан базаахын зэрэгцээ байлдааны театрыг урьдчилан бэлтгэлийг инженерийн төхөөрөмжтэй хийх тохиолдолд галын шугаманд хүрсэн шуудуу сувгийг бэлтгэх шаардлага ч үүснэ. Говь-талын районд хийж байсан байлдааны ажиллагааны туршлагаас харахад утаан хөшгийг ашиглах, ердийн тээврийн хөсөг ашиглах нь үр дүнтэй байдаг. Монгол орны нөхцөл морин ба тэмээн чиргүүлийг галын шугамнаас шархтан татан гаргах боломжтой мэт санагддаг.

Өвлийн улирлын цаг уурын онцлог. Монгол орны өвлийн уур амьсгал нь экстремаль нөхцөлд хамаарах бөгөөд нийгэм, эдийн засгийн онцлогт уялдуулан эмнэлэгийн хангалтыг зохион байгуулах шаардлага үүснэ. Өвлийн хүйтэний хэмжээ манай орны ялангуяа хойт ба баруун бүсэд хасах 40-50°C хүрэх ба температурын дундаж нь -17,5°C



байна. Агаарын атмосферийн даралт 30-38 мм.куб-д хэлбэлзэх ба салхины дундаж хурд 5-8мсек, дээд тал нь 30мсек хүрнэ. Хөрсний хөлдөлт мөнх цэвдэгийн бүсүүдэд зундаа ч хэвээр хадгалагдана. Хүйтний температур ба салхи цас, чийглэг нь хүний биед хавсарсан нөлөө үзүүлэх бөгөөд цаг агаарын шууд нөлөөнд үүсэх эмгэгээс гадна хүйтний нөлөөнд ихэнхи архаг өвчин сэдрэх эрсдлийг дагуулна.

Өвлийн цаг ууртай холбоотой өвчлөлийг хүйтний эмгэгийн 60-70%-ийг (хөрөх, хөлдөх, окопы өсгий өвчин, даарсанаас үүсэх эмгэгүүд: тонзиллит, синусит, трахейт, бронхит, пневмони) 15-20%-ийг ходоод гэдэсний замын хямрал (гастрит, гүйлгэлт, суулгалт), 15-20%-ийг арьс халимын өвчин (арьсны үрэвсэл, себоррей, эфидермофити) эзэлдэг. Голчлон мөчдийн үзүүр хуруу, чихний хөлдөлт элбэг тохиолдоно. Мөн 5-аас дээш хоног окопонд гутал тайлахгүй байх нөхцөлд "окопын өсгий" өвчин үүсэх бөгөөд энэ нь тэжээллэг, цусан хангамжийн архаг дутмагшлаас үүдэлтэй.

Хүйтний нөлөөнд мэдрэл-булчингийн, яс булчингийн тогтолцооны өвчнүүд, Чих хамар хоолойн эрхтэний эмгэгүүд, конъюнктивит, креатит үүсч нүд цийх тохиолдол ч байна. Хүйтний нөлөөгөөр шээсны ялгарал эрс ихэсч хоногт 15 хүртэл удаа болох тул шингэн дутагдалын дегидратацийн хам шинж, ус эрдсийн солилцооны хямрал үүсэх магадлалтай.

Цастай орчинд удаан байхад "цасны сохор" буюу гэрлийн офтальмофати үүсэх ба үүнийг эмчлэхгүй тохиолдолд 3-5 хоног үргэлжилж бие бүрэлдхүүний байлдах чадварт муугаар нөлөөлдөг.

Өвлийн улиралд цэргийн албан хаагчдын дунд авитаминоз, иод ба фторын, Д-Аминдэмийн дутмагшил үүсэх тул хүнс хоол болон урьдчилан сэргийлэх арга хэмжээнд, эдгээр асуудалд анхаарах хандуулах шаардлагатай.

Цэргийн эмнэлгийн албад өвлийн хүйтэн нөхцөлд бие бүрэлдхүүний эрүүл мэндийг хамгаалах олон талт ажиллагааг бусад албад салбаруудтай хамтран хэрэгжүүлнэ. Ялангуяа цэргийн албан хаагчдын чийрэгжилт, цанын дадлага олгох асуудлыг биеийн тамирын албатай, каллорлог, витаминт хоол хүнсээр хангах

талаар хүнсний алба, дулаан хувцас хэрэгсэл болон байрны талаар орон сууцны гэх мэт бусад албадын оролцоо маш чухал. Даарах, осгох хөлдөхөөс өөрийгөө хамгаалах болон хүйтний улирлын гэмтлийн үед авах арга хэмжээний талаар урьдчилсан сургалт явуулах шаардлагатай. Хүйтэн цастай үед эмнэлгийн байрыг дулаалах, татан гаргалтын авто техникийг бэлтгэх, замд дулаацуулах арга хэмжээг зам комендантын ба бусад албуудтай хамтран төлөвлөх, замын турш радио холбоотой байх, удирдлагыг бүрдүүлэх зэрэг ажлуудыг эмнэлгийн алба хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүйтнээс эмнэлгийн эм тариа бусад хэрэгслийг хамгаалах, шархтныг эмнэлгийн тусламж үзүүлэх үед дааруулахгүй байх, шархдагсдын хөл гарыг дулаан байлгах, эмнэлгийн бие бүрэлдхүүнийг хүйтэний нөлөөнөөс хамгаалах асуудалд анхаарах шаардлагатай.

Хот суурингийн гео-экологийн онцлог. MOUT (англ. Military Operations on Urban Terrain буюу MOBA, Military Operations in Built-Up Areas); хотын байгууламж доторх байлдааны ажиллагааг нэрлэдэг. Хотын географын онцлог нь үзэгдэх орчин хязгаарлагдмал, замын эвдрэл, барилга нурах, гурван хэмжээст орон зайн өгөгдөхүүн зэрэг өвөрмөц онцлогтой. Хотын байлдааны ажиллагааны оператив, тактикийн нөхцөл байдал байнга өөрчлөгдөж байдаг, маневрын олон хувилбартай, цагийн байдал гэнэт өөрчлөгдөх, анги салбар, бүлгүүдийн байлдааны ажиллагаа салангид бүлгүүдийн бие даасан хэлбэрээр явагддаг, нэгдсэн холбоо удирдлагаар хангах боломж хязгаарлагдмал зэрэг онцлогтой. Байлдааны ажиллагааны театрт түймэр, барилга нурах, зам талбай бөглөрөх, ариун цэвэр халдварын зэрэг эрсдэл байхын зэрэгцээ хотын хүн амын зүгээс үзүүлэх эсэргүүцэл, дэмжлэг болон тэднийг хамгаалах, нүүлгэн шилжүүлэх бодлого зэргийг цэргийн ажиллагааны үед тооцох асуудал үүсдэг. Цэргийн ажиллагаанд оролцож байгаа бэхлэлт саад байгуулах, партизаны ба сайн дурын бүлэг багуудын ажиллагааг цэргийн оператив тактикийн бодлоготой нэгтгэн удирдах хэрэгцээ ч үүснэ. Хотын байлдааны түүхэн туршлагын жишээнүүдээс Мадрида

(1936-1939), Сталинград (1942-1943), Кёнигсберг (1945), Берлин (1945), Грозный(1994-1995) Фаллуджу(2004), Иловайск (2014) зэргийг дурьдаж болно.

Хот суурингийн байлдааны ажиллагааны эмнэлгийн хангалт нь байлдааны тактик, байлдаж буй районы эрүүл ахуй-халдвар хамгааллын нөхцөлөөр тодорхойлогдоно. Хотын байлдааны ажиллагаа ихэвчлэн өндөр маневртай жижиг бүлгийн тулалдааны хэлбэртэй байх бөгөөд байлдааны хохирол нь галт зэвсгийн эмгэгээс гадна, барилгын нуралт, дарагдалт, түймрийн улмаас гарах эмгэгүүдээр тодорхойлогдоно. Том хэмжээний хот сууринд болох байлдааны ажиллагааны үед ил болон далд гэмтлийн хувийн жин эрс өсөх ба толгой хүзүү, цээжний гэмтэл давамгайлах хандлага үүснэ. Анаэроб халдварын тоо харьцангуй өндөр байдаг нь хот суурингийн бохирдлын түвшинтэй холбоотой.

Цэрэг нэг бүрт эмнэлгийн анхны тусламжийн нэмэгдэл хэрэгсэл олгож, дээрх хавсарсан ба нийлмэл эмгэгүүдийн үед үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламжийн мэдлэг дадлагыг урьдчилан зааварчлах шаардлагатай. Татан гаргалтын маршрутыг зөв сонгон авч, нөөц татан гаргалтын замыг, эмнэлгийн татан гаргалтыг зохион байгуулж байгаа бүрэлдэхүүнд мэдээллэн зам ба барилгын хананд чиглэл заасан сумаар тэмдэглэнэ. Эмнэлгийн пункт салбаруудыг байлдааны журмуудад аль болох ойр байрлуулах, майхан дэлгэхгүйгээр барилгын зоорийн давхар туннель зэргийг сонгон дэлгэх нь илүүтэй бөгөөд эмнэлгийн байрыг яаралтай нүүлгэх гарц, зам маршрутыг урьдчилан төлөвлөх, эмнэлгийг хамгаалах харуул хамгаалалтын үүргийг эмнэлгийн бие бүрэлдэхүүн, хөнгөн шархтанаас бүрдүүлэх шаардлага үүснэ. Татан гаргах боломж хязгаарлагдмал нөхцөлд эмнэлгийн тусламжийг бүрэн хэмжээгээр буюу шат ахиулан үзүүлэх бэлтгэлийг хангах хэрэгтэй.

Үүний зэрэгцээ ариун цэвэр-халдвар эсэргүүцэх эмнэлгийн тагнуулын ажиллагааг идэвхижүүлэх, цэргийн бие бүрэлдэхүүний хүнс, ахуйн эрүүл ахуйн арга хэмжээг эмнэлгийн албад дагнан хэрэгжүүлнэ. Захирагч даргын тушаалаар

олзолсон хүнсний нөөц, баталгаагүй ундны эх үүсвэрийг ашиглахыг хориглоно.

Шөнийн байлдааны эмнэлгийн хангалт. Орчин үеийн зэвсэгт тэмцлийн практикт шөнийн байлдааны эзлэх хувь улам өссөөр байна. Ялангуяа давшилт маневр, өндөр хурдаар гүний довтолгоо хийх замаар ялалт байгуулах зорилгод шөнийн байлдааны ажиллагааг ашиглана. Мөн тагнуул, десант, диверсийн жижиг бүлгүүдийн байлдааны ажиллагааг шөнийн цагаар эхлүүлэх нь ашигтай гэж үздэг. Шөнийн байлдаанд бие бүрэлдэхүүний хохирол харьцангуй бага байна. Гэвч шөнийн байлдаан нь газар орны баримжаа алдагдах, бие бүрэлдэхүүний бие махбод, сэтгэл зүйн ачаалал ихсэх сөрөг талтай.

Эмнэлгийн байгууллагууд деверсийн халдлагад өртөх магадлал өндөр тул хамгаалалтын бүлгийг томилж харуулын үүргийн чангатгах хэрэгтэй. Эмнэлгийн тагнуулыг зохион байгуулах ажил хүндрэлтэй болж ялангуяа халдварлагдсан ба химийн хороор хордсон газар орныг тогтоох асуудал төвөгтэй болно. Шөнийн үйл ажиллагаанд эмнэлгийн бие бүрэлдэхүүнд гэрэл, шөнийн харааны хэрэгслээр хангах явдал чухал байдаг.

Өвчтөн шархтныг эрж олох ажилд цэргийн бие бүрэлдэхүүнээс самнах ажиллагааг зохион байгуулах нь зүйтэй. Самналтаар илэрсэн шархтныг цуглуулах үүрийг байгуулж гэрлээр тэмдэглэн байрлалын солбилцлыг эмнэлгийн салбар ангид мэдээлнэ.

Эмнэлгийн татан гаргалтын замыг тэмдэг тэмдэглээгээр тодруулах, газрын зурагт тэмдэглэх, авто тээврийн таних гэрэлтдэг тэмдэг, тээврийн хэрэгсэлийг өвчтөн цуглуулах байранд аль болох ойртуулах зэрэг онцлогыг тусгах хэрэгтэй.

Цэргийн ариун цэврийн зааварлагч нарт шөнийн ажиллагааны зааварчлага өгч дадлага сургууль хийлгэсэн байх шаардлагатай.

Эмнэлгийн байруудыг байлдааны журамд аль болох ойрхон байрлуулах, тэдгээрийн болон эмнэлгийн тээврийн хэрэгслийн гэрлийн өнгөлөн далдлалтыг зааврын дагуу хийх шаардлагатай.

Дүгнэлт

Цэргийн эмнэлгийн газар зүйн



судалгааны ойлголтуудыг цэргийн эмнэлгийн практик ажиллагаанд ур дүнтэй ашиглах нь өвчтөн, шархтанг татан гаргах анхны болон яаралтай тусламжийг үзүүлэх, шархтныг асрах сувилах, эмнэлгийн шат дамжлагуудад тэвэрлэн гаргах зэрэг анги салбаруудын хэмжээнд явагдах байлдааны ажиллагаанд илүү хамааралтай нь манайд мөрдөгдөж байгаа орон нутгийн хамгаалалтын үзэл баримтальн үед маш өндөр ач холбогдолтой ба энэ талаар хийсэн судалгаанаас дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Монгол орны газар зүйн онцлог цаг агаарын нөхцөлийг цэргийн оператив, тактикийн төлөвлөлт, байлдааны хангалт, ялангуяа ар тал тээвэр эмнэлгийн хангалт, цэргийн сургалт, биеийн тамирын албаны тайван цагийн төлөвлөгөөнд тусгах;
2. Монгол орны газар зүйн онцлогт зайлшгүй хамааралтай дэд бүтэц хүн амын байршил, эдийн засаг, нийгмийн байдал зэрэг хүчин зүйлүүдийг тайван ба байлдааны цагийн эмнэлгийн хангалтыг зохион байгуулахад тооцон төлөвлөх, орон нутгийн эмнэлгийн байгууллагын харилцан ажиллагааны журмыг боловсруулах, орон нутгийн дэмжлэг боломжийг (хүн хүч, тээвэр холбооны хэрэгсэл, ердийн хөсөг, хүнс, эд материал, ахуйн нөөц) ашиглах бодлогыг боловсруулах;
3. Монголын батлан хамгаалах хүчний

зэвсэгт тэмцлийн өнөөгийн үзэл баримтлалд нийцүүлэн эмнэлгийн хангалтын үндсэн зарчим, тактик зохион байгуулалтын асуудал, табель хангалтын норм, нормативийг шинэчлэх замаар ерөнхий цэргийн ба бусад байлдааны хангалтын салбаруудын үйл ажиллагаанд нийцүүлэх;

4. Газар зүйн онцлогт бие бүрэлдэхүүний бэлтгэлийг тохируулан хангах, чийрэгжүүлэх, вакцинжилт, хүнс хоол, эмчилгээнд монголын уламжлалт анагаах ухаан, биологийн ухааны боломжуудыг ашиглах, амь гарах эрдэм ухаанд суралцуулах;
5. Эмнэлгийн өөртөө ба нөхөртөө үзүүлэх анхны тусламж, анхан шатны ба яаралтай тусамжийн чанар хүртээмж, үр дүнг дээшлүүлэх талаар онцгой анхаарч эмнэлгийн тусламжийн 50-60%-ийг галын шугам, өвөр эгнээ, батальон, хорооны эмнэлгийн албадын шатанд төвлөрүүлэх;
6. Цэргийн байлдааны театрыг урьдчилан бэлтгэх боломжтой нөхцөлд газар зүйн онцлогыг тусгасан цэргийн эмнэлгийн хангалт, зохион байгуулалттай холбоотой саналуудыг боловсруулан, захирагчийн шийдвэрээр, инженер сапериин ангиудтай хамтран хэрэгжүүлэх зэрэг болно.



ГАМШГИЙН ҮЕД ОХУ-ЫН ОНЦГОЙ БАЙДЛЫН /РСЧС/ УДИРДАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ ТУРШЛАГААС

П.ЦЭДЭВ /Доктор, профессор/
С.БЯМБАСҮРЭН /Докторант/

Түлхүүр үг: Харилцан ажиллагаа, удирдамж, зохион байгуулалт, төлөвлөгөө, туршлага

Key words: Cooperation, guidance, arrangement, plan, experience

Хураангуй: РСЧС гэдэг товчилсон үгийн тайлбар, Тайван ба байлдааны үед гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах талаар ОХУ-ын Онцгой байдлын яам, Батлан хамгаалах яамны удирдах болон бусад байгууллагуудын харилцан ажиллагааны удирдамж, төлөвлөгөөний бүтэц, үйл ажиллагааны талаар авч үзнэ. Энэ нь өнөө үед "Covid-19" цар тахалтай тэмцэх үед манай орны хүчний байгууллагуудын харилцан ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад аргачлал болж болох юм.

РСЧС гэдэг нь "Единая государственная система предупреждения и ликвидации чрезвычайных ситуаций" буюу "Гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах Оросын төрийн нэгдсэн тогтолцоо" гэсэн утга бүхий товчилсон үг. РСЧС гэдэг энэ үгийг хэвээр нь ашиглав.

РСЧС-ын хүч, хэрэгслийн харилцан ажиллагаа гэдэг нь зорилгодоо хүрэхийн тулд гамшгийг аль болох богино хугацаанд, хүн ам, эд хөрөнгөд хамгийн бага хохиролтойгоор даван туулахад РСЧС төрийн захиргааны удирдах байгууллагууд болон аврах хүч, хэрэгслэлийг ашиглах зорилго, үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээ, газар орон, цаг хугацаанд шуурхай бүлэг ба аврах анги, бригад, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний харилцан уялдаатайгаар аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагааг явуулахыг хэлнэ.

Тайван ба байлдааны үед гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах талаар ОХУ-ын Онцгой байдлын яам-(Иргэний хамгаалалт), Батлан хамгаалах яамны удирдах байгууллагууд ба хүчний үйл ажиллагааны тохиролцсон зорилт, гүйцэтгэх үүрэг, газар орон, цаг хугацаа ба арга замууд, түүнчлэн иргэний

хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд норматив ба төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулж байна. (ОХУ-ын Онцгой байдлын яам, ОХУ-ын Батлан хамгаалах яам хоорондын харилцан ажиллагааны удирдамж, хамтын ажиллагааны төлөвлөгөө) зохицуулалтын бүхий л түвшинд зохион байгуулагдана.

Байгалийн болон техногенийн шинж чанартай гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах талаар ОХУ-ын Онцгой байдлын яам, ОХУ-ын Батлан хамгаалах яам хоорондын харилцан ажиллагааны удирдамж байдаг байна.

Энэ харилцан ажиллагааны удирдамж нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

Бүлэг 1. Ерөнхий зүйл

1.1. Үндсэн тодорхойлолтууд

1.2. Харилцан ажиллагааны үндсүүд

Бүлэг 2. Удирдах байгууллага, тэдгээрийн эрх, үүрэг

2.1 Удирдах байгууллагууд

2.2. Удирдах байгууллагын эрх, үүрэг

2.3. Харилцан ажиллагааны төлөвлөлт, боловсруулж буй баримт бичиг

Бүлэг 3. Харилцан ажиллагааны зохион байгуулалт

3.1. Өдөр тутмын үйл ажиллагааны үеийн харилцан ажиллагааны зохион байгуулалт

3.2. Гамшгийн аюул үүссэн үед харилцан ажиллагааны зохион байгуулалт

3.3. Гамшгийн үед харилцан ажиллагааг зохион байгуулах нь

3.4. Эмнэлэг, ар талын болон техникийн хангалтын болон бусад чиглэлээр харилцан ажиллагааг зохион байгуулах нь

3.5. Дайны байдлын үеийн харилцан ажиллагааны зохион байгуулалтын онцлог



Иргэний хамгаалалт ба Онцгой байдлын удирдлагын байгууллагын харилцан ажиллагааны төлөвлөгөөний бүтэц

Гамшиг ба иргэний хамгаалалт.

Гамшиг ба Иргэний хамгаалалтын удирдлагын байгууллагууд /Болзошгүй аюултай объект, Химийн аюултай объект, Цацрагийн аюултай объект, Гал - дэлбэрэлтийн аюултай объект, Ус усан хангамжийн аюултай объект/-ын үйл ажиллагаа нь харилцан ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдана:

- гамшгийн байдал үүсч болох тусгай дэглэмтэй, мөн байгалийн гамшиг тохиолдож болох газар орон нутаг дэвсгэр (сүйрлийн аюултай үерийн гамшигт үзэгдэл гэх мэт), бусад эдийн засгийн хувьд нэлээд чухал болзошгүй аюултай объектуудын байршил, тэдгээрийн шинж чанар;
- аюултай ачааг автомашин, төмөр зам, агаарын болон усан замаар тээвэрлэх чиглэлүүд;
- гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээ авахад зориулан гаргасан цэргийн хүч, бүлэглэл ба түүний бүрэлдэхүүн, бүтэц тэдгээрийг объект, нутаг дэвсгэрт хуваарилах;
- гамшгийн хор уршгийг арилгахад цэргийн хүчний гүйцэтгэх үүрэг даалгавар;
- Иргэний хамгаалалтын хүч, хэрэгслийн үүрэг даалгавар;
- Цэргийн анги нэгтгэлүүдийг татан оруулах, цугларалтын талбай, болзошгүй аюултай объектод хүрэх зам чиглэл, тээврийн төрөл, очих хугацаа, авто зам-замын хөдөлгөөний хяналтын алба ба объектын хамгаалалтыг зохион байгуулах;
- удирдлага, харилцаа холбоо, сэрэмжлүүлэг, тэдгээрт дохио өгөх ажлыг зохион байгуулах;
- орон нутгийн эдийн засаг, засварын баазыг харгалзан гамшгийн хор уршгийг арилгах бүх талын цогц арга хэмжээгээр хангах ажлыг зохион байгуулах;
- нөөц хүчнийг оролцуулах журам ба түүний бүтэц, байршил, үүрэг даалгавар;

- хөрш зэргэлдээ бүсүүдийн (флотууд) удирдлагын байгууллагууд, бүс нутгийн иргэний хамгаалалт ба онцгой байдлын төвүүд, иргэний хамгаалалт ба онцгой байдлын цэргийн анги, гарнизоны удирдах байгууллагууд, түүнчлэн осол, гамшиг, байгалийн гамшигт өртөхөд тэдгээрийн бодит чадвар;
- тухайн бүс нутгийн онцлог байдлаас шалтгаалсан бусад асуудлууд.

Өдөр тутмын үйл ажиллагаанд шийдвэрлэх шаардлагатай асуудлууд

Гамшгийн аюул үүсэх заналхийлэл байхгүй тохиолдолд ОХУ-ын Онцгой байдлын яамны цэргийн командлал ба удирдлагын байгууллагууд дараах тохиолдолд харилцан ажиллагааны асуудлуудыг шийдвэрлэнэ. Үүнд:

- гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах талаарх зохицуулалтын шаардлагуудыг багтаасан эрх зүйн актууд болон бусад баримт бичгийг боловсруулах;
- харилцан ажиллагааны төлөвлөгөөний бодит байдлыг шалгах, хамтарсан дасгал (сургуулилтууд) хийх;
- гамшгийн нөхцөл байдал (аврах хойшлуулшгүй бусад ажиллагааг явуулах) удирдах байгууллагууд болон цэргийн анги нэгтгэлүүд (хүчнүүд) –ийн сургалт;
- гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах тулгамдаж буй асуудлын талаар туршлага солилцох, хурал, семинар, уулзалтад оролцох;
- харилцан анхааруулга мэдээлэл зохион байгуулах;
- харилцан ажиллагааны төлөвлөгөөг тодотгох;
- хүч хэрэгслийг ашиглах боломжтой объект, газар нутгийг судлах;
- нутаг дэвсгэрийн макет төсөл дээр (объектуудад) хамтарсан үйл ажиллагааг явуулах боломжуудыг судлах;
- бусад асуудлыг шийдвэрлэх;

Аюул заналхийлэл үүссэн үед харилцан тохиролцсон асуудлууд

Гамшгийн аюул заналхийлэл



үүссэн тохиолдолд ОХУ-ын Онцгой байдлын яамны цэргийн командлал ба удирдлагын байгууллагууд нь дараах арга хэмжээнүүдийг тодруулна. Үүнд:

- гаргасан шийдвэрүүд;
- харилцан ажиллагаа ба холболтын төлөвлөгөөнүүд;
- цагийн байдлын тухай харилцан мэдээлэл зохион байгуулах;
- хуваарилагдсан хүч хэрэгслийн бүрэлдэхүүн;
- бүх талын хангалтын асуудлууд.

Энэ үеүүдэд удирдах байгууллагуудын төлөвлөгөөний дагуу болзошгүй гамшгийн үед авах арга хэмжээнүүдийн дадлага /сургалт/, мөн хүн ам, нутаг дэвсгэрийг урьдчилсан болон тэргүүлэх чиглэлийн эхний ээлжийн /хүн ам газар нутгийг хамгаалах/ арга хэмжээг боловсруулж болох штабын дасгал (сургуулилтууд) хийж болно.

Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед гүйцэтгэх арга хэмжээ

Гамшгийн нөхцөл байдал бий болсон үед ОХУ-ын Онцгой байдлын яамны цэргийн командлал ба удирдлагын байгууллагууд нь дараах арга хэмжээнүүдийг гүйцэтгэнэ. Үүнд:

- гамшгийн цагийн байдал тухай болон харилцан зарлан мэдээлэл хүргэх;
- гаргасан шийдвэр, харилцан ажиллагааны төлөвлөгөө (асуудлууд), хүч хэрэгслийн бүтэц, тэдгээрийг гамшгийн бүс рүү хөдлөх ба бүхий л талын хангалтуудын асуудлуудыг тодруулах;
- яаралтай тусламжийн бүсэд үзүүлэх урьдчилсан нөхцөл, цогц дэмжлэг;
- Хуваарилсан цэргийн анги нэгтгэлүүд (хүчнүүд) нэн даруй гамшгийн байдлын бүс рүү (уулзах газар) хөдлөх ба аврах хойшлуулшгүй сэргээн босгох бусад ажиллагааг хэрэгжүүлэх бэлэн байдалд орно.

Гаргасан шийдвэр болон харилцан ажиллагааны төлөвлөгөө хэрэгжиж эхэлсэн талаар харилцан мэдээлэл өгч, тайланг талуудын удирдлагад хүргүүлж байна.

Гамшгийн бүс дэх шуурхай үйл ажиллагаа, цагийн байдлын тухай

илтгэлүүдийг яаралтай мэдээний хүснэгтэд заасны дагуу зохих удирдлагын байгууллагад хүргүүлнэ.

ОХУ-ын Онцгой байдлын яам ба Цэргийн удирдлагын байгууллагын харилцан ажиллагааны үндсэн асуудлууд нь дараах байдалтай байна. Үүнд:

- Удирдлага зохион байгуулалт
- Зарлан мэдээлэл
- Тандалт ажиглалт /тагнуул/
- Хүн амын болон газар орон нутгийн хамгаалалт
- Гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, аврах хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа
- Хүч, хэрэгслийн хуваарилалт, тэдгээрийн бэлтгэл ба бүх талын хангамж
- Гамшгийн бүс рүү хүч хэрэгслийг илгээх ажлын зохион байгуулалт
- Нутаг дэвсгэрийн хамгаалалт
- Дайны байдалд иргэний хамгаалалтыг шилжүүлэх ба дайчилгаатай тараан байрлуулалт
- Сөргөлдөгч талын хэрэглэсэн хөнөөх хэрэгслийн үр дагаврыг арилгах ажиллагаа

Удирдлагын асуудлаарх харилцан ажиллагаа

Иргэний хамгаалалтын байгууллага, цэргийн удирдлага, цэрэг ба иргэний хамгаалалтын анги нэгтгэлүүдэд мэдээлэл-дохио, тушаал, байлдааны шийдвэрийг цаг алдалгүй хүргэх, түүнчлэн мэдээлэл солилцох зорилгоор харилцан ажиллагаа зохион байгуулагдана.

Үүний зэрэгцээгээр ОХУ-ын Зэвсэгт хүчний орон нутгийн батлан хамгаалах байгууллагууд, түүнчлэн нутаг дэвсгэрийн батлан хамгаалах байгууллагуудын харилцан ажиллагаа (уялдаа холбоо, харилцааг)-г зохион байгуулахад онцгой анхаарал хандуулна.

Зарлан мэдээллийн асуудлаарх харилцан ажиллагаа

- Энэ нь дараах замаар шийдвэрлэнэ:
- цэргийн командлал ба иргэний хамгаалалтын (РСЧС) зарлан мэдээллийн систем болон харилцаа холбооны системүүдийг хослуулах;
 - зарлан мэдээллийн дохиоллын нэгдсэн систем байгуулах;
 - дохио дамжуулах тодорхой



- дараалал, аргыг тодорхойлох;
- үүссэн нөхцөл байдал, гаргасан шийдвэрийн талаар харилцан мэдээлэл солилцох.

Тандалт /тагнуул/-ын асуудлаарх харилцан ажиллагаа

Тодорхойлогдох зүйл:

- тандалт /тагнуул/-ын зорилго ба зорилт;
- үйл ажиллагааны чиглэл (зам маршрутууд);
- тандалт /тагнуул/-ын объект;
- хуваарилагдсан хүч хэрэгсэл;
- тандалт /тагнуул/ хийх цаг хугацаа ба дараалал;
- тандалт /тагнуул/-ын мэдээллийг дамжуулах дараалал.

Аврах хойшлуулшгүй бусад арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаарх харилцан ажиллагаа

Тодорхойлогдох зүйл:

- үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын зорилго ба зорилт;
- хуваарилагдсан хүч хэрэгсэл;
- хүч хэрэгслийг оруулах чиглэл (зам маршрутууд);
- үйл ажиллагааг явуулах объект ба нутаг дэвсгэр;
- хүч хэрэгслийг ашиглах цаг хугацаа ба дараалал.

Хүн ам, материаллаг болон соёлын үнэт зүйлс бүхий нутаг дэвсгэрийг хамгаалах асуудлаарх харилцан ажиллагаа

Дараах замаар шийдвэрлэнэ:

- нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ;
- инженерийн хамгаалалт;
- цацраг, химийн хамгаалалт;
- эмнэлгийн хамгаалалт;
- хүн амын аюулгүй амьдрах үйл ажиллагааг хангах зэрэг болно.

ОХУ-ын Онцгой байдлын яамны хүч хэрэгслэл, Иргэний агаарын тээврийн байгууллагын харилцан ажиллагаа

Гамшгийн үед Иргэний агаарын тээврийн шийдвэрлэх ажлууд:

1. Өмчийн төрөл бүрийн хэлбэрийн агаарын тээврийн компаниуд шаардлагатай тооны зорчигч тээврийн болон ачаа тээврийн агаарын хөлөг хуваарилах замаар гамшгийн хор уршгийг арилгах

ажилд бүх төрлийн тээврийн дэмжлэг үзүүлэх.

2. Тухайн гамшгийн бүсэд агаарын тээврийн тусгай анги (өмчлөлөөс үл хамааран) тусгай нисэхийн үйл ажиллагаа явуулах.
3. Иргэний агаарын тээврийн байгууламж дахь байгалийн гамшгийн үр дагаврыг өөрсдийн хүчээр арилгах зэрэг болно.

Гамшгийн хор уршгийг арилгахаар хэрэгжүүлж буй төрөл бүрийн тээврийн дэмжлэгтэйгээр дараах тээврийн ажиллагааг гүйцэтгэнэ:

- Онцгой байдлын яам болон тухайн орон нутгийн онцгой комиссын мэргэжилтнүүдийн үйл ажиллагааны шуурхай баг;
- гал түймрийн болон эрэн хайх аврах ангийн шаардлагатай багаж, хэрэгсэлтэй бүхий бүлгүүд;
- эмнэлгийн яаралтай тусламжийн бүлэг, эм, эмнэлгийн хэрэгсэл ба холбогдох тоног төхөөрөмж;
- цацраг, химийн бүлгүүд, холбогдох багаж, хэрэгсэл;
- тусгай зориулалтын техникийн хэрэгсэл, үүнд хүнд даацын тусгай хэрэгсэл, төрөл бүрийн материал-техникийн хэрэгслэлүүд, хоол хүнс ба хувцас гэх мэт;
- шархадагсад, нэрвэгдэгсэд ба өвчтөнгүүд;
- орон гэргүй болсон энгийн иргэд;
- Засгийн газрын болон Улсын нэгдсэн комисс;
- яаралтай засвар хийх машин механизм ба тоног төхөөрөмж;
- Оросын Онцгой байдлын яамны хүсэлтээр хүмүүнлэгийн ачааг хүргэнэ.

Нисэхийн тусгай ажиллагаанд дараах зүйлс багтана. Үүнд:

- Гамшгийн ерөнхий нөхцөл байдал, олон нийтийн аж ахуйн объектын төлөв байдал, дэд бүтэц, харилцаа холбоо, хийн хоолой, цахилгаан шугам болон бусад объектуудын агаарын тандалт судалгаа;
- Дэд бүтэц болон харилцаа холбоо, бусад объектуудын гамшгийн бүсийн агаарын зураг;
- Агаар мандал, газар нутгийн



- цацрагийн тандалт судалгаа;
- Зарим объект болон авто замын хэсгийг хийгүйжүүлэх ба ариутгах;
- Гал түймэрийг унтраах;
- Далайд хаягдсан байгаа зорчигчид болон усан онгоцны багийн гишүүдийг аврах;
- Тусгаарлагдсан объект болон талбайгаас хохирогчдыг аврах;
- Гамшигт буй далайн болон гол мөрний усан онгоцнуудыг удирдлагаар хангах;
- Барилга байгууламжийг буулгах ба задлан салгах, нурангийг зайлуулах;
- Гамшгийн хор уршгийг арилгахад туслахаар ирэх гадаадын агаарын хөлгийг өөрийн онгоцны зогсоолд хүлээн авах ажиллагааг зохицуулах;
- Царцаа болон бусад хорт мэрэгч тэмцэх зэрэг болно.

Салбарын байгууламж (агаарын тээврийн компаниуд, нисэх онгоцны буудал, иргэний нисэхийн үйлдвэр гэх мэт) дээрх гамшгийн хор хөнөөлийг арилгахдаа дээрх тусгай ажиллагаанаас гадна, иргэний нисэхийн байгууллага нь дараах ажлыг шийдвэрлэнэ. Үүнд:

- аврах, хойшлуулшгүй сэргээн босгох болон бусад яаралтай арга хэмжээг гүйцэтгэдэг;
- хохирогчдод эмнэлгийн анхны болон мэргэжлийн эмчийн өмнөх тусламж үзүүлэх;
- үйлдвэрлэлийн ажилчид ба хүн амын хэвийн амьжиргааг хангаж, иргэний агаарын тээврийн аж ахуйн үйл ажиллагааг сэргээнэ.

Нисэх хүчний нисэх бэлэн байдлыг хангах хугацаа нь хүсэлт (шийдвэр) гаргасанаас хойш дараах хугацаанаас хэтэрч болохгүй. Үүнд:

- нисдэг тэрэгний хувьд - 3 цаг;
- нисэх онгоцны зорчигчдын хувьд - 8 цаг;
- тээврийн онгоцны хувьд - 12 цаг.

Гамшгийн бүсэд цагийн байдлыг үнэлэх шуурхай ажлын хэсэг, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх багийн яаралтай хүргэх ба аврах болон хойшлуулшгүй арга хэмжээний санал боловсруулах ажиллагааг агаарын нисэх хүчний эрэн хайх, аврах багийнханыг жижүүрүүд хийж гүйцэтгэнэ. (Нисэхэд бэлэн байх хугацаа:

зуны улиралд-30 минут, өвлийн улиралд - 45 мин).

Гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах чиглэлээр талуудын харилцан ажиллагаа нь дараах зүйлийг агуулна. Үүнд:

- зохицуулалтын эрх зүйн актууд болон холбооны хэмжээний бусад удирдамжийг боловсруулахад хамтран оролцох;
- талуудын чадамжтай холбоотой мэдээлэлүүдийг харилцан солилцох;
- харилцан ажиллагааны төлөвлөгөөг хамтран боловсруулах;
- гамшгийн хор уршгийг арилгах үед шаардлагатай хүч, хэрэгслийг тодорхойлох, боловсруулсан харилцан ажиллагааны төлөвлөгөөний дагуу хуваарилах;
- гамшгийн үед үзүүлэх хариу арга хэмжээ, түүний дотор иж бүрэн дэмжлэг үзүүлэх асуудлаар хамтарсан үйл ажиллагааг зохицуулах;
- төлөвлөгөөний бодит байдал, удирдлага ба хүч хэрэгслийг сургах талаар хамтарсан дадлага сургуулилт (дасгал) хийх;
- туршлага солилцох, гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах асуудал ба бусад арга хэмжээний талаарх хурал, семинарт оролцох;
- талуудын хүч, хэрэгслийг тус тусад нь бэлтгэх явцад явуулсан сургалт, дасгалын явцад ажиглагч харилцан солилцох;
- томоохон осол ба сүйрлүүдийн шалтгааныг тодорхойлох албаны тандалт судалгаануудын ажиллагаанд хамтран оролцох зэрэг болно.

Харилцан ажиллагааны төлөвлөгөөнд дараах зүйлс тусгагдана. Үүнд:

- байгалийн гамшиг тохиолдож болзошгүй газрууд болон төмөр замын ойролцоо байрласан байгалийн гамшиг тохиолдож болох нутаг дэвсгэрүүдээс бусад эдийн засгийн болзошгүй аюултай объектуудын байрлал;
- болзошгүй аюултай объектуудын шинж чанар;
- гүүр, туннель, аюултай ачаа ачих



- газар, бусад болзошгүй гамшгийн аюултай нөхцөл байдал үүсч болох төмөр замын хэсгийг оруулсан төмөр замын сүлжээний схем;
- сэргээх засварлах болон гал түймрийг унтраах галт тэрэгнүүдийн байршиж буй газар;
 - болзошгүй гамшгийн хор уршгийг арилгахад талуудын гаргаж буй бүтэц ба хүчний бүрэлдэхүүн, тэдгээрийг объект, нутаг дэвсгэрт хувиарлах;
 - гамшгийн хор уршгийг арилгах талуудын хүчний үүрэг даалгавар;
 - РСЧС -ны эрэн хайх- аврах ангиудын үүрэг даалгавар;
 - эрэн хайх- аврах албаны үүрэг даалгавар;
 - төмөр замын эмнэлгүүдийн дэргэдэх эмнэлэг-аврах ангиудын үүрэг даалгавар;
 - гамшгийн байдал үүссэн газар руу талуудын сэргээн босгох хүч ба хэрэгслэлийг гаргах журам, цугларах болон төвлөрүүлэх бүс, хөдөлгөөний маршрут ба зохион байгуулалт, ирэх цаг хугацаа, объектын хамгаалалт;
 - удирдлагын зохион байгуулалт, анхааруулга, тэдгээрт дохио өгөх;
 - орон нутгийн эдийн засаг болон аж үйлдвэрийн баазын харгалзан гамшгийн хор уршгийг арилгах тал бүрийн арга хэмжээг зохион байгуулах;
 - талуудын нөөцийн бүтэц, байршиж буй газар, үүрэг даалгавар ба оролцох журам дараалал;
 - хөрш зэргэлдээ төмөр замын удирдлага ба хэлтэс, албад болон орон нутгийн засаг захиргааны байнгын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, мөн хүн ам, нутаг дэвсгэрийг гамшгаас хамгаалах чиглэлээр тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тусгай эрх бүхий байгууллагуудын харилцан ажиллагааны журам, үүнээс гадна тэдгээрийн осол, байгалийн гамшигт өртсөн тохиолдлын үеийн бодит боломж;
 - тухайн бүс нутгийн онцлог байдлаас шалтгаалсан бусад асуудлууд орно.

ОХУ-ын Онцгой байдлын яамны болон ОХУ-ын Зам тээврийн яамны хүч хэрэгслийн харилцан ажиллагаа

Харилцан ажиллагааны зохион байгуулалт.

Өдөр тутмын үйл ажиллагааны харилцан ажиллагааны зохион байгуулалт. Өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд талууд дараах чиглэлээр харилцан үйл ажиллагааг зохион байгуулна. Үүнд:

- зохицуулалтын эрх зүйн акт, гамшгийн байдлаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах талаарх тогтоосон зохицуулалтын шаардлага бусад баримт бичгийг боловсруулахад хамтран оролцох;
- харилцан ажиллагааны төлөвлөгөөний бодит байдлыг шалгахын тулд хамтарсан сургуулилт (дадлага) хийх;
- удирдах байгууллага болон үйл ажиллагааг хэрэгжүүлэгч хүчнийг гамшгийн нөхцөлд үйл ажиллагаа явуулах сургалт;
- гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах арга хэмжээний асуудлаар туршлага солилцох, тулгамдсан асуудлаар хурал, семинар, уулзалтад оролцох;
- бусад асуудлаар хамтын ажиллагааны төлөвлөгөөг тодруулах зэрэг болно.

Гамшгаас урьдчилан сэргийлэх ба арилгах чиглэлээр талуудын харилцан ажиллагааны дараах зүйлийг агуулна. Үүнд:

Гамшгийн үед харилцан ажиллагааг зохион байгуулах

Гамшиг үүсэх аюул нүүрэлсэн үед гамшгийн хор уршгийг арилгахад татан оролцуулсан талуудын удирдах байгууллагууд ба удирдлага дараах байдлыг тодордуулна. Үүнд:

- урьд нь гаргасан шийдвэр;
- харилцан ажиллагааны төлөвлөгөө;
- цагийн байдлын талаарх бүх талын мэдээллийг зохион байгуулах;
- хуваарилагдсан хүч хэрэгслүүдийн бүрэлдэхүүн;
- бүлэглэлийн бүтцэд хуваарилсан хүч хэрэгслүүд нь холбогдох дээд албан тушаалтнуудын шийдвэр

болон талуудын дээд шатны удирдах байгууллагуудын илтгэлүүдэд үндэслэн гамшгийн бэлэн байдалд шилжинэ.

Харилцан ажиллагааны төлөвлөгөөнд дараах зүйлс орно. Үүнд:

Гамшгийн үед харилцан ажиллагааг зохион байгуулах нь

Гамшгийн байдал үүссэн үед:

1. Талуудын шуурхай албадын шугамаар гамшгийн тухай зарлан мэдээлэл болон мэдээллийг түүнд хавсаргасан байх ёстой схемийн дагуу (Хавсралт 2) илгээнэ;
2. Гамшгийн төрөл; гамшиг болсон он, сар өдөр ба цаг (Москвигийн цагаар); газар (төмөр замын туслах зам, хэсэг, өртөө, салбар, зам); үүсэх шалтгаан; боломжит аюул үүсэх талбай; нөхөн сэргээлт хийхэд, хүн ам ба хүрээлэн буй орчинд үзүүлэх аюулын түвшин; хүч ба хэрэгслийн оролцоо.
3. Хүлээн авсан мэдээлэлд үндэслэн талуудын удирдлагын байгууллагууд гаргасан шийдвэр, харилцан ажиллагааны төлөвлөгөөнд (асуудлууд) тодруулга хийнэ.
4. Сэргээн босгоход зориулагдан хуваарилагдсан хүчнүүд нэн даруй гаргасан шийдвэрийн дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлэх бэлэн байдалд орох ба гамшгийн хор уршгийг арилгах харилцан ажиллагааны төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаанд орж, харилцан мэдээлэл солилцож, тайланг талуудын удирдлагад хүргүүлнэ.

Харилцан ажиллагааны зохион байгуулалт

Өдөр тутмын харилцан ажиллагааг зохион байгуулах нь. Аюултай ачаа бараа бүхий гамшгийн хор уршгийг арилгах үед ОХУ-ын Зам тээврийн яам өөрсдийн хүч ба хэрэгслүүдээр дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- ОХУ-ын Онцгой байдлын яамны хүчин, техник хэрэгслийг гамшгийн бүсэд хүргэх ажлыг гүйцэтгэнэ;
- галт тэрэгний хөдөлгөөнийг сэргээнэ;
- ОХУ-ын Зам тээврийн яамны ачаа барааг вагоноор тээвэрлэх журамд

заасны дагуу тээвэрлэсэн барааг ачих (шилжүүлэх) зориулалттай хөдөлгөөнт тээврийн хэрэгслээр хангах;

- Ачаа тээвэрлэгчийн (ачаа хүлээн авагчийн) вагоноор тээвэрлэн авчирсан ачааг ачих (шилжүүлэх) зориулалттай тусгай зориулалтын хөдөлгөөнт бүрэлдэхүүнийг гамшгийн бүсэд хүргэх;
- Гамшгийн бүсийн хордсон газар дэвсгэрийг цэвэрлэх, хор уршгийг арилгах, аюултай ачаа тээврийг зайлуулах, эвдэрсэн болон гэмтсэн хөдөлгөөнт бүрэлдэхүүнээс цэвэрлэнэ.

Гамшиг үүссэн /аюул заналхийлэл/ үед харилцан ажиллагааг зохион байгуулах нь

Аюултай ачаа бүхий гамшгийн байдал үүссэн тохиолдолд ОХУ-ын Онцгой байдлын яамны удирдах байгууллага, хүчин ба техник хэрэгслээр шийдвэрлэх ажлууд:

- гамшгийн бүсийг тусгаарлан хааж, удирдлагын төвүүдийг дэлгэх ба харилцаа холбоог зохион байгуулах;
- хүн амыг аврах ба тэднийг гамшгийн бүсээс нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ, нэрвэгдэгсдэд эмнэлгийн тусламж үзүүлэх ба тэдгээрийг эмнэлгийн байгууллагад байршуулах ажиллагааг зохицуулах ба хэрэгжүүлэх;
- орон нутгийн гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах улсын нэгдсэн системийн дэд системд багтсан бусад яам болон тамгын газрын аврах нэгжид зарлан мэдээлэх ба дуудлага өгөх;
- ачаа тээвэрлэгчийн (ачаа хүлээн авагчийн) вагоноор тээвэрлэн авчирсан ачааг ачих (шилжүүлэх) зориулалттай тусгай зориулалтын вагоноор хангах;
- Талбайн бохирдлыг арилгах, аюултай барааны үлдэгдлийг зайлуулах арга хэмжээг зохион байгуулах ба хэрэгжүүлэх зэрэг болно.

Гамшгийн үед харилцан харилцан ажиллагааг зохион байгуулах нь



Цацраг идэвхт бохирдлын голомтыг (химийн халдвар) хор уршгийг арилгахад дараах асуудлуудыг тохиролцон шийдвэрлэнэ. Үүнд:

- хуваарилагдсан хүч ба хэрэгслийн талаар;
- тэдгээрийг шилжүүлэх ба ажлын гүйцэтгэлийн дараалал ба аргачлал;
- голомтод ажиллаж буй хүн ам, хүч хэрэгслийг хамгаалах горимууд;
- эмнэлгийн тусламжийн зохион байгуулалт, нийтийн дэг журмыг сахиулах, удирдлага, үйл ажиллагааны хангалт болон бусад

асуудлууд орно.

Нэн сүйрэл ихтэй газар хөдлөлт, үер, хөрс гулсалтын хөнөөлийг арилгахад ажлын хэмжээ ба үргэлжлэх хугацаа их байдгаас шалтгаалан РСЧС-ийн удирдах байгууллагууд болон хүч, хэрэгслийн харилцан уялдаатай үйл ажиллагааг үе шаттай ба үйл ажиллагааг үечлэн зохион байгуулдаг байна.

Дээрх байдлаас дүгнэлт хийж үзэхэд гамшгийн үед ОХУ-ын Онцгой байдлын / РСЧС/ удирдах байгууллагуудын харилцан ажиллагаа нь манай оронд авч хэрэглэх туршлага мөн болох харагдаж байна.



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХҮНИЙ НӨӨЦИЙН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ, ХЭРЭГЛЭХ АРГА ЗҮЙ

Б.НЭРГҮЙ /ҮБХИС-ийн БХЭШХ-ийн БХДШТ-ийн ЭША, доктор, дэд хурандаа/
Т.УРАНЧИМЭГ /ҮБХИС-ийн БХЭШХ-ийн ЦТСТ-ийн ЭША, магистр/

Түлхүүр үг: Цахим, мэдээлэл, хүний нөөц, Зэвсэгт хүчин, бодлого, алба, сан, систем, програм, модуль, төлөвлөлт

Товч агуулга: Батлан хамгаалахын хүний нөөцийн бодлого, удирдлага, төлөвлөлтийг хийхэд дэмжлэг үзүүлэх нэгдсэн цахим мэдээллийн сан бүрдүүлэх, шаардлагатай боловсруулалт, тайлан мэдээгээр хангах үндсэн үүрэгтэй програм хангамж, түүний хэрэглээний онцлогийн талаар энэхүү өгүүлэлд авч үзэв.

Монгол Улсын Төрийн Батлан хамгаалах бодлого, Батлан хамгаалахын багц хуулиуд батлагдан шинэ зорилт чиг үүргүүд бий болсонтой холбогдуулан Батлан хамгаалах салбарын хүний нөөцийн бодлого, тогтолцоонд дүн шинжилгээ хийж, шинэчлэн боловсруулан батлаад байна.

Батлан хамгаалах салбарын хүний нөөцийн бодлого нь Аюулгүй байдлын орчны өөрчлөлт, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, батлан хамгаалах тогтолцооны шинэчлэл, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг хөгжүүлж бэхжүүлэх зорилтоос үүдэн салбарын бодлого, зорилт, чиг үүргийг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх чадавхтай хүний нөөцийг төлөвлөх, бэлтгэх, байршуулах, хөгжүүлэх, удирдах, хянах тогтолцоог бүрдүүлэх зорилготой боловсруулагдсан байна.

Тухайн бодлого нь батлан хамгаалах бодлого, зорилт, чиг үүргийг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх чадавхтай хүний нөөцийг төлөвлөх, бэлтгэх, байршуулах, хөгжүүлэх, удирдах, хянах тогтолцоог бүрдүүлэх зорилготой бөгөөд ингэхдээ нэгдсэн сүлжээнд холбогдсон хүний нөөцийн мэдээллийн санд тулгуурлахаар тодорхойлж өгчээ.

Энэ үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд батлан хамгаалахын хүний нөөцийн мэдээллийн судалгаанд тулгуурласан цаасан болон цахим

мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэгцээнд суурилсан Зэвсэгт хүчний хүний нөөцийн бүртгэл мэдээллийн системийг боловсруулах хэрэгцээ шаардлага зайлшгүй урган гарсан юм.

Зэвсэгт хүчний хэмжээнд алба хаагчийн мэдээ, мэдээлэл материалыг хөтлөх, бүртгэх, удирдах зорилгоор хүний нөөцийн бүртгэл, мэдээллийн чиглэлийн цахим програмыг боловсруулан ашиглах оролдлого хийж байсан боловч амжилтгүй болжээ. Мөн Төрийн албаны зөвлөлөөс боловсруулсан Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн систем HRMIS (2013)-г үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн боловч тус програм нь салбарын болон цэргийн байгууллагад тохиромж муутай, цаг хугацаа, техник ажиллагаа их шаарддаг, хязгаарлагдмал мэдээллийн сан, тайлагналт боловсруулалт муутай Зэвсэгт хүчний үйл ажиллагаатай авцалдахгүй байсан тул ашиглахаа больж мэдээ судалгаагаа хагас бүтэн жилээр гарган Төрийн албаны зөвлөлд цаасаар хүргүүлдэг байна.

Иймээс салбарын онцлог хүчин зүйлийг харгалзсан дайчилгааны бодлого, төлөвлөгөөтэй хүний нөөцийн удирдлагын цахим системийг боловсруулан ашиглах нь батлан хамгаалах, төрийн цэргийн байгууллагын хүний нөөцийн төлөвлөлт, бодлого, удирдлагыг зөв, үр ашигтай, баталгаатай хэрэгжүүлэхэд чухал болсон байна.

Одоогийн байдлаар хүний нөөцийн бүртгэл мэдээллийн чиглэлээр жилдээ 10 000 гаруй иргэд, цэргийн алба хаагчдад үйлчилдэг. Уг үйл ажиллагаа нь хувь хүний мэдээлэл хайх, архивт хадгалагдсан мэдээлэл шүүх, тооцоо судалгаа гаргах зэргээр цаг хугацаа, хөрөнгө хүч, хүний нөөц ихээхэн шаардсан ажил байдаг. Үүнд өдөр тутамдаа MS Excel програмыг



ашиглан алба хаагчдынхаа бүртгэлийг нэг бүрчлэн гараар шивж, бүртгэлжүүлэн түүнээсээ хасалт, нэмэлт хийх маягаар бүртгэл, мэдээлэл хөтөлж байна. Судалгаа тайлан мэдээг гаргахдаа хүн нэг бүрийн хувийн хэрэг, алба хаагчийн картыг шүүж нэг бүрчлэн шивэх маягаар судалгааг хийдэг бөгөөд байнгын шаардлагатай судалгаа, тайлан мэдээг MS Excel програм дээр томьёо ашиглан шүүлт хийх маягаар судалгаануудыг гаргадаг нь хүндрэлтэй байдаг байна.

Иймд батлан хамгаалах бодлого, зорилт, чиг үүргийг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх чадавхтай хүний нөөцийг төлөвлөх, бэлтгэх, байршуулах, хөгжүүлэх, удирдах, хянах тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Зэвсэгт хүчний хүний нөөцийн систем" (MAFHRS-2019) буюу хүний нөөцийн бүртгэл мэдээллийн системийг Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн дээр боловсруулав.

Зэвсэгт хүчний хүний нөөцийн систем нь батлан хамгаалахын хүний нөөцийн бодлого, удирдлага, төлөвлөлтийг хийхэд дэмжлэг үзүүлэх нэгдсэн цахим мэдээллийн сан бүрдүүлэх, шаардлагатай боловсруулалт, тайлан мэдээгээр хангах үндсэн үүрэгтэй юм.

Энэхүү бүртгэл мэдээллийн систем нь техник хангамж, програм хангамжийн тусламжтайгаар хэрэглэгчийн тодорхойлсон өгөгдөл, мэдээллийг цуглуулан тодорхой аргачлал, дүрэм журам, технологиор боловсруулахаас гадна их хэмжээний өгөгдөл мэдээллийг найдвартай хадгалах, шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь түргэн шуурхай, төрөл бүрийн байдлаар гаргах замаар Зэвсэгт хүчний хүний нөөцийн удирдлагын бүхий л үйл ажиллагааг дэмжинэ.

Зэвсэгт хүчний нөөцийн систем нь БХЯ, ЗХЖШ, ХЗЦК, АЦК, анги, байгууллагуудыг хамарсан цогц систем бөгөөд системийн бүтцийг зураг 1-д үзүүлэв.

Систем нь үндсэн сервер



Зураг 1. "Зэвсэгт хүчний нөөцийн систем"-ийн зураг

(БХЯ), төв сервер (ЗХЖШ, ХЗЦК, АЦК), анги, байгууллагын хэрэглэгч гэсэн бүтэцтэй байна.

Тус системийг үүсгэх болон хэрэглээ, ашиглалтын талаарх журмыг тусгай журмаар зохицуулж ашиглах нь ажиллагаанд гарах алдаа дутагдал, аюулгүй байдлын зохицуулалт, мэдээллийн сан бүрдүүлэлтийн нарийн үйл ажиллагааг зохицуулж өгөх ач холбогдолтой тул "Зэвсэгт хүчний хүний нөөцийн систем, цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам"-ын төслийг мөн боловсруулсан байна.



Зураг 2. Зэвсэгт хүчний хүний нөөцийн системийн бүтэц



Тус систем нь хоорондоо нягт уялдаа холбоотой ажилладаг дараах үндсэн 5 модулиудаас бүрдэнэ.

1. Байгууллагын дотоод бүтэц үүсгэх, удирдах модуль
2. Ажлын байр, орон тоо үүсгэх удирдах модуль;
3. Хүний нөөцийн бүртгэлийн модуль;
4. Хүний нөөцийн дайчилгааны бүртгэлийн модуль;
5. Хүний нөөцийн мэдээлэл тайлагналын модуль;

Түүнчлэн Зэвсэгт хүчний хүний нөөцийн системд ажиллахдаа дараах үндсэн дарааллыг баримтална.



Зураг 3. Зэвсэгт хүчний хүний нөөцийн системд ажиллах дараалал


"Зэвсэгт хүчний хүний нөөцийн систем"-ийн техник, хэрэглээний програм хангамжийн шаардлага дараах байдалтай байна. Үүнд:

1. Сервер компьютер:
 - a. Техник хангамж:
 - CPU - 2 Quad Core Intel® Xeon® 2x2MB Cache, 3.0 GHz, 1333MHz, түүнээс дээш;
 - RAM - 12Gb, түүнээс дээш;
 - Hard disk - 1Tb, түүнээс дээш /RAID 1, түүнээс дээш/;
 - LAN card - 100/1000Mbps;
 - Бусад техникийн үзүүлэлт - стандарт;
 - b. Нөөц тэжээл - 3000VA, түүнээс дээш
 - c. Програм хангамж:
 - Windows Server 2008 R2 Standard Edition, түүнээс дээш;
 - MS SQL 2008, түүнээс дээш;
 - Microsoft framework 4.0, түүнээс дээш;
2. Хүний нөөцийн ажилтан буюу хэрэглэгчийн компьютер:
 - a. Техник хангамж:
 - I5 Intel® 2x2MB Cache, 3.0 GHz, 1333MHz, түүнээс дээш;

- RAM - 4Gb, түүнээс дээш;
 - Hard disk - 1Tb, түүнээс дээш;
 - LAN card - 100/1000Mbps;
 - Бусад техникийн үзүүлэлт - стандарт;
- b. Нөөц тэжээл - 1000VA, түүнээс дээш;
 - c. Програм хангамж:
 - Windows 7, түүнээс дээш;
 - Microsoft framework 4.0, түүнээс дээш;
 - MS SQL 2008, түүнээс дээш;
 - Microsoft Office 2007, түүнээс дээш;
 - Adobe Reader 7.0, түүнээс дээш;
3. Мэдээлэл зөөвөрлөх техник:
 - a. Зөөврийн хатуу диск;
 - 100Gb, түүнээс дээш;
 - Fingerprint biometric нууцлалын шаардлага хангасан байх;
 - b. Зөөврийн диск:
 - 4Gb, түүнээс дээш;
 - Fingerprint biometric нууцлалын шаардлага хангасан байх;

Тус програм нь сүлжээний орчинд зөвхөн сервер компьютерт байгаа өгөгдлийн санд хандаж хэрэглэгчийн програмаар нэвтрэх нэр болон нууц үгийн тусламжтай ажилладаг. Харин сүлжээгүй компьютер дээр тухайн байгууллагын өгөгдлийн сантай нэвтрэх нэр болон нууц үгийн тусламжтай ажиллах ба сервер компьютерт зөөврийн хадгалах төхөөрөмжөөр шинэчлэл хийх, өгөгдөл солилцох хэлбэрээр ажилладаг байна. Програмтай ажиллахад дараах байдалтай байна. Үүнд:

1. Нэвтрэх нэр, нууц үг оруулснаар програмд нэвтрэх орно. 2 төрлийн хэрэглэгчтэй байна. Үүнд:
 - a. Бүрэн эрхтэй хэрэглэгч буюу Администратор;
 - b. Хязгаарлагдмал эрхтэй хэрэглэгч буюу хүний нөөцийн ажилтан;



Зураг 4. Системийн нэвтрэх хэсэг



Drag a column header here to group by that column

Хэрэглэгч нэр	Хэрэглэгч эрх	Идэвхтэй эсэх
Administrator	Админ	<input checked="" type="checkbox"/>
user1	Хүний нөөц ажилтан	<input checked="" type="checkbox"/>


Програмд нэвтэрч орсны дараа "Лавлах" цэснээс "Хэрэглэгчид" цэсийг сонгосноор системд нэвтрэх хэрэглэгчийн жагсаалт гарч ирнэ.

Үйлдэл хийх цэснээс "Нэмэх" товчийг дарж шинээр гарч ирсэн цонхыг бөглөж хэрэглэгч нэмж болдог. Мөн бусад товчнуудын зааварчилгааг гарын авлагад тодорхой зурагтайгаар дүрсэлж оруулсан.


2. Орсны дараах програмын үндсэн цонх:

3. Байгууллагын бүтцийг мод хэлбэрээр нэмж оруулж өгдгөөр уян хатан хийж өгсөн төдийгүй, түүнтэй холбогдох өгсгдлийн талбар шинээр үүсдэгээр зохион байгуулж өгсөн нь хэрэглэгчдэд давуу тал болж байна. Мөн жагсаалтын цонхон дотор нь нэрийг засах боломжтой хийгджээ.

4. Тухайн байгууллагын бүтэц, ажлын байр, орон тоог өөрчлөх, нэмж оруулах, засах боломж бүрдсэн



Зураг 5. Системийн үндсэн цонхны харагдах байдал



Зураг 6. Үндсэн бүртгэлийн мэдээллийг тайлагнах хэвлэх хөрвүүлэх хэлбэрийн зурагнууд



- байна;
5. Төрийн албан хаагчийн анкет болон бусад шаардлагатай маягтуудыг давхардалгүйгээр оруулах боломжийг гаргаж өгсөн байна;
 6. Шаардлагатай маягтуудыг нэмэх, хэвлэх, лавлагаа авах, талбарын сонголттойгоор статистик үзүүлэлт гаргах, хайлтыг талбар талбараар нь хийх, түүнийгээ хэрэглээний програм руу хөрвүүлэх, шууд принтерээр хэвлэх боломжтойг доорх зурагт харуулав.
 7. Удирдлага, аюулгүй байдлын чиглэлээр:
 - Үндсэн удирдлага буюу администратор нь програмтай ажиллахдаа өгөгдлийг оруулах, засах, устгах, хайх, тайлан гаргах эрхтэй;
 - Хязгаарлагдмал хандалтын эрхтэй хэрэглэгчдийн түвшинг үүсгэх боломжийг бүрдүүлсэн нь програмтай ажиллах тодорхой түвшний эрхтэй;
 - Програмд хандсан хэрэглэгчдийн хийсэн үйлдлийн бичлэг хадгалдаж, архив файл үүсдэг;
 - Програмд хандах нэр, нууц үгийн удирдлагын функцтэй;
 - Өгөгдлийн сангийн нөөц архив үүсгэж өгдгөөр хийгджээ.
 8. "Зэвсэгт хүчний хүний нөөцийн систем" нь програм хангамжийн хувьд түүнд тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт, захиалагч хамтран ажиллагчийн бодлогын даалгаврыг бүрэн хангасан ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, агуулгатай болсон.

Энэхүү програм хангамж нь байгууллагын хүний нөөцийн үндсэн бүртгэл мэдээллээс гадна Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд шаардлагатай дараах онцлох олон боломжит үйлдлүүдийг гүйцэтгэх боломжтой. Үүнд:

1. Хүний нөөцийн бүх чиг үүргүүдийг системчилсэн. Зэвсэгт хүчний хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагаанд шаардлагатай гэж үзсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлэхэд энэхүү систем нь дэмжлэг болох ба хүний нөөцийн менежментийн бүх үйл ажиллагаануудыг систем ашиглан удирдах боломжийг

олгосон.

2. Хүссэн бүтэц, орон тоо үүсгэх. Зэвсэгт хүчний бүтэц зохион байгуулалт, орон тооны загваруудыг тухай бүр хүссэн байдлаар системд оруулан загварчилж мод хэлбэрээр харах, алба хаагчийн мэдээллийн бүртгэлтэй холбох боломжтой.

3. Цэргийн албаны онцлог бүртгэл. Байгууллагын хүний нөөцийн үндсэн бүртгэлүүдээс гадна цэргийн байгууллагын онцлог, цэргийн албаны үйл ажиллагааг илэрхийлэгч олон онцлог утгуудаар бүртгэх, түүний дотор анги, байгууллагууд дээр дайчилгааны бүртгэлийг хөтлөх боломжийг олгосон;

4. Ухаалаг тайлан. Зэвсэгт хүчин хүний нөөцөө төлөвлөх, зохион байгуулах, шийдвэр гаргалтын үндэслэлийг сайжруулахад шаардлагатай бүх төрлийн ухаалаг тайланг батлан хамгаалах салбарын хүний нөөцийн судалгаа гаргах жагсаалтаар, мөн хайлт шүүлтийн хэлбэрээр бүртгэлийн бүх утгуудыг ашиглан гаргаж авах боломжтой.

5. Алба хаагчийн анкет гаргах. Төрийн алба, цэргийн албаны хүний нөөцийн үйл ажиллагаанд нийтлэг шаардлагатай Төрийн албан хаагчийн анкетын "А ХЭСЭГ" (Маягт 1) болон "Б ХЭСЭГ" (Маягт 2), Цэргийн алба хаагчийн анкетын батлагдсан загварын дагуу алба хаагч тус бүрийн бүртгэгдсэн мэдээллийн дагуу бөглөж бичсэн хэлбэрээр програмаас хэвлэж гаргах боломжтой.

6. Эх сурвалжийн архив үүсгэх. Хүний нөөцийн бүртгэл, мэдээ, мэдээллийг үнэн зөв болохыг тодорхойлох эрх зүйн чадамж бүхий бичиг баримт болох зарлиг, захирамж, тушаал, шийдвэр, диплом, гэрчилгээ, үнэмлэх гэх мэт баримтуудыг харгалзуулан хадгалж архив үүсгэх боломжтой.

7. Автомат мэдэгдэл. Цэргийн цол, цалингийн шатлал, удаан жилийн хугацааны талаарх автомат мэдэгдэл ирүүлэх тоолууртай (мэдэгдлийн төрөл, тоог нэмэгдүүлэх, зохиомжлох боломжтой);

8. Үр дүнгийн гэрээ, ашиг сонирхлын мэдүүлэг. Төрийн жинхэнэ албан хаагчдын үр дүнгийн гэрээ, гэрээний биелэлт, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын



мэдүүлэг зэргийн эх файлыг он дараалан архив үүсгэн мэдээллийн сандаа хавсарган хадгалах боломжтой. Үүнээс албан дахь садан төрлийн холбооны талаарх бүртгэл хөтлөх, лавлагаа гаргах боломжтой;

9. Системийн Log үүсгэх. Тус програмын администратор, хэрэглэгчдийн нэвтрэлт, ажиллагааны талаарх Log үүсгэж хадгалж аюулгүй байдлыг хангах боломжтой (Log үүсгэх хугацааг тохируулах боломжтой);

Цаашид уг системийг дараах байдлаар хөгжүүлэх боломжтой:

1. "Хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох аргачлал"-ыг боловсруулж ашиглахад холбож баяжуулах боломжтой.
2. Зэвсэгт хүчний нэгдсэн сүлжээг зохион байгуулахад түүнд холбож энэхүү програм хангамжид түшиглэсэн хүний нөөцийн онлайн сүлжээг бий болгох боломжтой.
3. Төрийн цэргийн байгууллын нэгдсэн мэдээллийн санг энэхүү програм хангамжид түшиглэн нэмэлт хөгжүүлэлт хийн байгуулж үүсгэх боломжтой.

Програмыг хэрэглээнд нэвтрүүлэх, батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд ашиглахад дараах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Эрх зүйн орчинг тодорхой болгож шаардлагатай дүрэм, журам, техник технологийн боломжийг бүрдүүлсэн зохион байгуулалтын ажлыг хийх;
2. "Зэвсэгт хүчний хүний нөөцийн систем, цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам"-ыг боловсруулан Батлан хамгаалахын сайдаар батлуулах;
3. "Батлан хамгаалах салбарын хүний нөөцийн судалгаа, мэдээлэл хөтлөх нийтлэг журам"-ыг Батлан хамгаалахын сайдаар шинэчлэн батлуулах;
4. Системийг сүлжээний болон сүлжээгүй орчинд ажиллуулах тохиолдолд мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаарх мэргэжлийн

болон зохион байгуулалтын арга хэмжээг авах;

Энэхүү системийг нэвтрүүлснээр дараах ач холбогдолтой:

1. Батлан хамгаалахын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, салбарын хүний нөөцийн нэгдсэн цахим сан байгуулагдах, түүнийг бүрдүүлэх үндсэн програм хангамжтай болох;
2. Батлан хамгаалах салбарын хүний нөөцийн менежмент сайжирч, удирдлага, төлөвлөлтийн үйл ажиллагааны шуурхай, бодитой, үр ашигт байдал дээшилнэ;
3. Батлан хамгаалах салбарт иргэний байгууллагад ашиглаж буй хүний нөөцийн удирдлагын системийг шууд ашиглах боломж хязгаарлагдмал байдаг тул салбарын онцлогт тохирсон хүний нөөцийн бүртгэлийн системтэй болох;
4. Батлан хамгаалах хүний нөөцийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх, хэрэгцээт тайлан мэдээллээ хүссэн үзүүлэлтээр тайлагнах, бүлэглэх, ажилтнуудын талаарх хайлт хийх, судалгаа гаргах, мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх зэрэг хүний нөөцийн үйл ажиллагааг автоматжуулах;
5. Хүний нөөцийн систем нь арифметик алдаа гаргадаггүй, тооцоололтуудыг хүнээс хэд дахин хурдан хийх боломжтой учраас Зэвсэгт хүчний удирдлагад хүний нөөцийн талаар богино хугацаанд уян хатан, алдаагүй, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх;
6. Батлан хамгаалах эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд хяналт тавих, нийт захиргааны зардлыг багасгах;
7. Батлан хамгаалах салбарын санхүүгийн шинжилгээ, төлөвлөлт хийх, хүний нөөцийн урсгалыг хянах зэрэг үйл ажиллагаан дахь хүний хүчин зүйлээс шалтгаалах алдааг багасгах зэрэг ач холбогдолтой юм.



ЦЭРГИЙН ЦАХИМ СУРГАЛТЫН ОРЧИНГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ



Г.ЭНХЖАРГАЛ /УБХИС-ийн Ахлагчийн сургуулийн мэргэжил олгох сургалтын тэнхимийн сургагч багш, сургагч ахлагч/

2005 онд СУИС-ийн харьяа Соёлын коллежийг "Архив, бичиг хэргийн ажилтан" мэргэжлээр төгссөн. Төрийн удирдлагын магистр.

Түлхүүр үг: Сургалт, цахим орчин, хичээл, сошиал медиа

Key words: Training, cyberspace, lessons, social media

Товч утга. Сургалтын нэг шинэлэг хэлбэр бол цахим сургалт юм. Цахим сургалт нь өөрөө хүн хүч цаг хугацаа хөрөнгө мөнгө ихээхэн хэмнэсэн сургалтын нэг хэлбэр юм. Батлан хамгаалах салбарт сургалтын энэ хэлбэр нь ихээхэн боломж бололцоо олгох боломжтой.

Цэргийн мэргэжил олох сургалтын онцлог нь өөрөө зардал хөрөнгө мөнгө цаг хугацаа шаардсан үйл ажиллагаа байдаг. Ихэнх сургалт танхимаас гадуур практик дээр явагддаг гэдгээрээ онцлог. Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн хувьд танхимаас гадуурх сургалтыг хээрийн сургалтын талбайд төлөвлөгөөний дагуу явуулдаг бөгөөд энэ нь хөрөнгө мөнгө, цаг хугацаа ихээр шаардсан ажил болдог.

Харин өнөөдөр дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага нь танхимаас гадуурх хээрийн дадлага сургуулийг цахим орчинд танхимд хийдэг болоод удаж байна. Тухайлбал: төрөл бүрийн буудлага, жолоодлого, дадлагыг цахим орчинд хийх болсон. Үндэсний батлан хамгаалахын их сургууль энэ жишгийн дагуу зарим хичээлийг цахим сургалтаар явуулж байна. Цахим сургалтын нэг онцлог нь хөрөнгө мөнгө цаг хугацаа хүн хүчний нөөцийг хэмнэдгээрээ давуу талтай юм. Улс орны эдийн засаг хүнд, дэлхий нийтийг хамарсан "Covid-19" халдварт өвчин гарсан энэ үед цахим сургалтыг хөгжүүлэх нь ихээхэн ач холбогдолтой юм.

Цаашид ч энэ өвчний халдвар буурахгүй харин ч дэгдэх магадлал өндөр байгаа нь цахим хэрэглээ цахим сургалтыг хөгжүүлэх түүгээр дамжуулан хичээл сургалтын үйл ажиллагааны тасралтгүй

хэвийн байдлыг хангахад чухал нөлөөтэй юм.

Цэргийн цахим сургалтын орчинг сайжруулснаар:

Нэгдүгээрт: Хээр гадаа хийх байлдааны сум хэрэгсэлтэй сургалт дадлагыг хийх шаардлагагүй болох бөгөөд эдийн засгийн хямралтай, өвчний дэгдэлт өндөр байгаа энэ үед ихээхэн төсөв мөнгө хэмнэх юм. Мөн аюулгүй байдлын талаасаа ч ач холбогдолтой юм.

Хоёрдугаарт: Цахим сургалтаар оюутны бие даан суралцах чадвар ихээхэн дээшлэх боломжтой байдаг. Суралцагчид заавал багшийн заавраар бус харин өөрсдөө бие дааж хөгжих боломжийг нээж өгсөн явдал юм. Багш төвтэй бус харин шавь төвтэй сургалтын тогтолцоо ихээр ярьж буй энэ цаг үед ихээхэн тохирсон арга гэж үзэж болно.

Гуравдугаарт: Цэргийн мэргэжлийн зэрэг олгох сургалт өөрөө их цаг хугацаа шаардсан мөн ихээхэн хөрөнгө мөнгө шаардсан ажил байдаг гэдгийг дээр дурдсан. Цэргийн мэргэжлийн сургалтын нэг онцлог нь онол практик хосолмол явж байдаг. Онолоор авсан мэдлэгээ практик дадлагаар бататгах нь энэ чиглэлийн сургалтын онцлог байдаг.

Социалист нийгмийн үед буюу өөрөөр хэлбэл 1960-1990-ээд оны үед Монголын Зэвсэгт хүчний хөгжил өндөрт хүрч хуучны ЗХУ-ын дэмжлэгтэйгээр цэргийн мэргэжил олгох сургалт эрчимтэй явагдсан. Энэ хэрээр сургалтад ашиглах техник хэрэгсэл хангалттай байж онол практик хосолсон сургалт үр дүнгээ өгч байсан.

1990 он гараад Монгол Улсын боловсролын систем тэр дундаа цэргийн



сургалт бэлтгэлийн тогтолцоо үндсэндээ өөрчлөгдсөн. Улс орны эдийн засгийн байдал болоод батлан хамгаалах салбарт хуваарилсан төсөв тэр дундаа сургалтын зардал ихээхэн хорогдсон. Жил ирэх бүр батлан хамгаалах салбарын төсөв багаар батлагдаж байсантай холбоотой юм.

Нөгөө талаар төсвийн хүндрэлээс гадна төсөөлөгдөөгүй хүчин зүйлс гарч ирэх болсны нэг нь дэлхий нийтийг хамарсан "Covid-19" вирус юм. Энэ өвчин нь нийгмийн бүхий л үйл ажиллагаанд хүндрэл учруулсны нэг нь боловсролын салбар юм.

Боловсролын салбар энэ өвчний хамгийн эрсдэлт бүлэгт багтаж байгаа учраас Монгол Улсын Засгийн газраас бүх шатны сургалтыг цахим хэлбэрт шилжүүлсэн.

Энэ бүхнээс үндэслэн уламжлалт цэргийн сургалтын тогтолцоог өөрчлөн цахим сургалтад цаашид ч шилжүүлэх зүй ёсны шаардлага урган гарч ирж байна. Нөхцөл байдал хүндрэлтэй цаг үе ч үүнийг шаардаж байна.

Цахим сургалт гэж тэгвэл юу вэ? Ерөнхийдөө цахим сургалт гэдэг нь технологид суурилсан сургалт гэж тодорхойлж болно. Цэргийн мэргэжлийн цахим сургалт нь энгийн сургалтаас огт өөр ойлголт гэж үздэг.

Сургалтын цахим хэрэглэгдэхүүн бэлтгэх нь ихээхэн цаг, хөдөлмөр шаардсан ажил юм. Өөрөөр хэлбэл цахим хичээл бэлтгэх ажлын 80% нь тухайн мэргэжлийн багшид ноогддог гэсэн судалгаа байдаг.

Иймд цахим хичээл болон хэрэглэгдэхүүн бэлтгэхийн тулд ямар арга хэмжээ авбал зохих дүгнэлтийг доорх байдлаар хийж байна.

Цахим хичээл боловсруулахад:

1. Хичээлийнхээ материалд шинжилгээ хийж, цахим хичээлийн төлөвлөгөө боловсруулах
2. Төлөвлөгөөнийхөө дагуу материалаа боловсруулах
3. Боловсруулсан хичээлээ туршин, цаашид сайжруулах

Багш нарын МХТ-ийг ашиглах чадварыг дээшлүүлэхийн тулд:

1. Цахим сургалт явуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх

2. Гадны болон дотоодын сургалтад хамруулан суралцуулах

3. Цахим сургалт явуулах орчинг нь бүрдүүлэх

4. МХТ-ийг сургалтандаа ашиглаж байгаа багшийг дэмжин ажиллах, урамшуулах г.м

Багш ямар аргаар е-хичээл бэлтгэж болох вэ?

1. Та өөрийн хамгийн сайн ашигладаг хэрэглээний програмыг ашиглах

2. Та шинээр нэмэлт хэрэглээний програм сурах

3. Та зориулалтын е-хичээл бэлтгэдэг програм хангамж ашиглах

4. Та мэргэшсэн хүнээр хийлгэх

5. "Multimedia studio"-ийн тусламжтай Е-хичээл хийх гэх мэт.

Цахим сургалтын томъёолол нь компьютерт суурилсан сургалт, Вебд суурилсан сургалт, виртуал сургалт, сошиал медиа, телевиз, радиогийн сургалт зэргийг агуулах сургалтын нэг шинэ хэлбэр бөгөөд үйлчилгээний өргөн цар хүрээг агуулсан байдаг.

Цахим сургалт нь суралцагчдад агуулгаа хүргэхдээ бүх төрлийн цахим дамжуулах төхөөрөмж, түүний дотор интернет, интранэт, экстранэт, хиймэл дагуулын систем, аудио, видео систем, сошиал медиа, интерактив телевиз ба CD – ROM зэргийг ашиглаж болдог.

Гэхдээ цэргийн мэргэжлийн сургалтад ихэвчлэн виртуал сургалтыг ашиглах нь оновчтой бөгөөд үр дүнтэй байдаг. Хамгийн энгийн жишээгээр ухаж ойлговол байлдаантай "action" төрлийн компьютерийн тоглоомоор тоглож байгаатай агаар нэгэн юм.

Мөн сошиал медиад суурилсан сургалт хамгийн үр дүнтэй болох нь сүүлийн хэдэн сарын судалгаанаас харагдаж байна. Тухайлбал фейсбүүкт тусгай бүлгэм, групп үүсгэн мэдээ мэдээлэл солилцох, онлайн тест авах, видео хурал хийх гэх мэтийн олон давуу талтай. Мөн Google classroom ашиглан цахим анги үүсгэн хичээл заах гэх мэтийн олон давуу талтай.

Тактикийн хээрийн сургууль, байлдааны буудлагыг цахим орчинд явуулах нь хөрөнгө, мөнгө хүн хүч хэмнэсэн үр дүнтэй ажил юм. Тухайлбал: тактикийн хээрийн сургууль, байлдааны



буудлага явуулах үед байгаль орчинд ихээхэн сөрөг үр дагавартай бөгөөд бууны сум, байлдааны техник хэрэгсэлд онги татагдсан газрын хөрс эргэж сэргэх нь удаан, зарим тохиолдолд тэсэрч дэлбэрээгүй сум галт хэрэгсэл үлдэх үүнээс болж мал болон хүн өртөж гэмтэх, шатахуун тослох материал ихээр үрэх, хүн хүчийг байрлуулах байр сав агуулах, хоол хүнс гээд маш олон зардал гарч ирдэг. Харин цахим полигонд буудлага хийхэд энэ бүх үргүй зардал хэмнэгдэх давуу талтай.

Мөн дараах давуу талуудыг дурдах нь зүйтэй. Үүнд:

1. Багш сурагчдын хувийн харьцааны ойлголт байхгүй
2. Суралцагч цагт баригдахгүй мэдлэг олж авах боломж
3. Байршлаас үл хамааран суралцах
4. Сургалтын агуулга хязгааргүй
5. Сургалтын материалуудын шинэчлэл, хүргэлт шуурхай
6. Мэдээллийн технологийн хэрэгслүүд ашиглах боломж

7. Үнэлгээний харьцангуй байдал үгүй болох

Цахим сургалт хэдийгээр давуу талтай ч дутагдалтай хэд хэдэн зүйлс бий. Тухайлбал:

1. Бодит харилцааны дутмаг байдал
2. Асуух, тодруулах боломж байхгүй /сүүлийн үед форум хэлбэрээр шийдэж байгаа/
3. Мэдээллийн технологийн дэд бүтэц шаардлагатай
4. Суралцагчдын хоорондын холбоо сул
5. Үнэлгээний арга хэрэгсэл явцуу

Эцэст нь дүгнэхэд. Өнөөдөр Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн хэмжээнд цахим сургалт тэр дундаа цахим сургалтын нэг хэлбэр болох виртуал сургалт хангалтгүй байгаа нь нэгдүгээрт: хөрөнгө мөнгөтэй холбоотой, хоёрдугаарт: энэ сургалтын талаар огт мэдлэггүй, гуравдугаарт: багш нарын мэдлэг чадвар өөрийгөө дайчлах чадвар, шинийг эрэлхийлэх чанар дутагдсантай холбоотой гэж үзэж байна.

Ашигласан материал:

1. Байгалтөгс.С. Монголын е – Сургалтын чанарын баталгаажуулалтын бодлогын асуудалд. ШУТИС. ЭШБ эмхэтгэл. 2012. №4/127.
2. Батчимэг.О. МХХТ-ийг сургалттай хэрхэн уялдуулах вэ? ШУТИС. 2010
3. Оюунгэрэл.Д. Сургалт удирдлагын системийг цахим хэрэгслүүдтэй холбож ажиллах хэрэглээний судалгаа. ЭШ өгүүлэл. 2012
4. Цэдэвсүрэн.Д. МХХТ-ийг нэвтрүүлж буй өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага. УБ. 2010
5. Чойжоованчиг.Л. нар. Багш нарын мэдээлэл харилцааны технологийн боловсролд. Багш нарт зориулсан гарын авлага. БСШУЯ. УБ. 2008
6. <http://www.youtube.com/watch?v=cK3RJj1I5JQ> - Сэдэв: "Э-сургалтын програм хангамж боловсруулах арга зүйн асуудалд". Илтгэгч: докторант Б.Мөнхчимэг, ШУТИС, Е-нээлттэй сургуулийн багш



ЦЭРГИЙГ АГААРЫН ДОВТОЛГООНООС ХАМГААЛАХ ЗЭВСЭГЛЭЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ



Ц.БАТБАЯР /УБХИС, БХУА-ийн Цэргийн стратегийн төвийн ахлах багш, дэд хурандаа/

2004 онд БХИС-ийг Зенитийн пуужин-артиллерийн командын офицер мэргэжлээр, ОХУ-ын агаарын довтолгооноос хамгаалах цэргийн академи, Словак улсын Батлан хамгаалахын академийн олон улсын штабын офицерын дамжаа, Непал улсын НҮБ-ын штабын офицерын дамжаа, БНЭУ-ын БХ-ын менежментийн дамжааг тус тус дүүргэсэн.

Түлхүүр үг: Агаарын довтолгооноос хамгаалах цэрэг, удирдлагын автоматжуулсан цогцолбор систем, Бага оврын гурван хэмжээст радиолокацын станц 1Л122Е, Радиолокацын станц, сансрын хиймэл дагуулын систем ГЛОНАСС

Key words: Air defense, small-scale three-dimensional radar station, satellite system GLONASS

Үндэслэл: Монгол Улсын Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн ЦАДХ-ын зэвсэглэл, удирдлагын систем нь байлдааны ажиллагаа явуулахад өнөө үед тавигдаж буй шаардлагыг тэр бүр хангаж чадахгүй байна. ЦАДХ-ын зэвсэглэл, удирдлагын техник хэрэгсэлд гарч буй шинэчлэл, байлдааны ажиллагааг удирдах боломжийг хэрхэн дээшлүүлж байгаад дүн шинжилгээ хийж, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох шаардлага тулгарч байна.


Зорилго. ОХУ-ын Зэвсэгт хүчний ЦАДХ-ын зэвсэглэл, удирдлагын автоматжуулсан систем, бүтэц зохион

байгуулалтыг судлах, МУ-ын Зэвсэгт хүчний хуурай замын цэргийн ЦАДХ-ын удирдлагын системд судалгаа хийж харьцуулах, сүүлийн үеийн байлдааны ажиллагааны туршлагаас ашиглаж болох зарим арга замыг тодорхойлоход оршино.

1. ОХУ-д Зэвсэгт хүчний ХЗЦ-ийн ЦАДХ-ын бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл, удирдлагын автоматжуулсан системд хийсэн судалгаа

ОХУ-ын хуурай замын цэргийн мотобуудлагын бригадын бүтэцэд, АДХ-ын 2 дивизионтой байна.

Мотобуудлагын бригадын бүтэц, зохион байгуулалт



Хүч хэрэгсэл

Бие бүрэлдэхүүн	4500	152мм-ийн МСТА-С	36	ТЭсПЦог "Корнет-Э"	24
Т-80	42	125мм-ийн танк эсэргүүцэгч пушка	6	ЗПЦ БМ "Тор"	12
БМП-3	170			ЗПАЦ "Тунгуска"	6
БРДМ-2	4	120мм миномёт "Сани"	24	ЗПЦ "Стрела-10"	6
АГС-17	18	БМ 21-1 "Град"	18	ЗПЗЦ "Игла"	36



БРИГАДИЙН ЦОГЦОЛБОР (мббр, тбр)

АДХ-ын даргын
Удирдах салаа



мббр зптдн «Оса-АКМ»



тбр зптдн «Тор»

ЗДН захирагчийн
удирдах тасаг



зпадн



ЗПАЦ «Тунгуска»



ЗПЦ «Стрела-10»



ЗПЗЦ «Игла»

"Оса-АКМ"-ийн, танкийн бригадад "Тор"-ийн зенитийн пуужингийн дивизион (зптдн)-оор, нам өндөрт 3 төрлийн холимог зэвсэглэлтэй зенитийн пуужин артиллерийн дивизионоор (зпадн) халхалж байна. Холимог зэвсэглэлтэй дивизион нь зенитийн пуужин-артиллерийн цогцолбор (ЗПАЦ)-ийн "Тунгуска"-аар зэвсэглэсэн батарей, зенитийн пуужингийн цогцолбор (ЗПЦ)-ийн "Стрела-10"-аар зэвсэглэсэн батарей, зенитийн пуужингийн зөөврийн цогцолбор (ЗПЗЦ) "Игла-

1М"-аар зэвсэглэсэн батарейнуудаас бүрдэнэ. Эндээс харахад мотобуудлагын батальонууд (мбб) нь орон тооны АДХ-ын зэвсэглэлгүй бөгөөд холимог зэвсэглэлтэй зенитийн пуужин-артиллерийн дивизион (зпадн)-оос халхлах хүч хэрэгслийг байлдааны ажиллагаанд гүйцэтгэх үүргийнх нь дагуу хуваарилах бөгөөд АДХ-ын удирдлагыг зпадн-ны удирдах байрнаас хэрэгжүүлнэ. Энэ нь АДХ хүч, хэрэгслүүд нэгдсэн удирдлагатай байна гэсэн үг юм.

Тэгвэл АДХ-ын нэгдсэн удирдлагыг хэрхэн зохион байгуулж байгаа дээр



судалгаа хийлээ.


Агаарын довтолгооноос хамгаалах зэвсэглэлийн удирдлагын автоматжуулсан цогцолбор систем "Барнаул-Т"

2008 оноос хойш Барнаул-Т автоматжуулсан хэрэгслийн цогцолбор (КСА) ыг АДХ-ын удирдлагын системийг мотобуудлагын бригадуудын зэвсэглэлд оруулж, зенитийн пуужин-артиллерийн

байлдааны буудлага, харвалтуудын үед агаарын довтолгооны хэрэгслүүдийн цохилтыг няцаах болон пуужингийн эсрэг хэрэглэх зэрэг байлдааны дасгалуудыг боловсруулсан сургамж туршлагуудад дүн шинжилгээ хийж сайжруулсаар байна.

Бригадын АДХ-ын автоматжуулсан хэрэгслийн цогцолбор (КСА)-ын бүрдэлд:

Удирдлагын түвшин	Нэршил	Явах анги	Гаднах байдал
Нэгтгэл (бригад)-ийн удирдлагын байр	Төлөвлөлтийн дэд хэсэг 9С931-1	Чиргүүлтэй Камаз	
Нэгтгэл (бригад) дивизионы удирдлагын байр	Төлөвлөлтийн дэд хэсэг 9С931	МТ-Лбу	
Батарейны захирагчийн командын байр	Тагнуул удирдлагын дэд хэсэг 9С932-1	МТ-Лбу	
Зенитийн харвах салааны захирагчийн галын удирдлагын хэрэгсэл	Зөөврийн хэрэгсэлийн цогцолбор (ПМУО) 9С933		
Зенитийн харвагч	Хүн нэг бүрийн цель заалтын багаж (КСАС) 9С935		
Салаа (тасаг)-ны захирагчид	Зөөврийн тагнуулын РЛС		



Мотобуудлагын бригадын АДХ-ын удирдлагын бүтэц, зохион байгуулалт "Барнаул-Т"

2. РЛС-ын харьцуулсан судалгаа

Бага оврын гурван хэмжээт радиолокацын станц "Гармонь" 1Л122Е. Бага оврын гурван хэмжээт радиолокацын станц 1Л122Е нь Агаарын довтолгооноос хамгаалах цэрэгт хээрийн нөхцөлд радиолокацийн найдвартай мэдээгээр хангах үүрэгтэй. РЛС 1Л122-1Е болон 1Л122-2Е нь ойрын зайн зенитийн артиллерийн болон пуужингийн салбаруудын командын байрыг илрүүлэхэд төвөгтэй газар орны нөхцөл, уулархаг районд агаарын целийн мэдээгээр хангахад нэн тохиромжтой. Түүнийг зөөвөрлөх тоот нь хоёроос гурван хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд РЛС-ын хөгжлийн шинэ чиг хандлагыг бий болгосон.



Бага оврын гурван хэмжээт радиолокацын станц 1Л122Е-ийн ерөнхий байдал.

Системийг хэдийн ашиглаж эхэлсэн бөгөөд анх түүнийг Сочигийн өвлийн олимпын үеэр нислэгийн хөдөлгөөний нөхцөл байдал, агаарын цагийн байдлыг хянахаар ашиглаж байсан. Тухайн үед агаарын аюулгүй байдлыг хангаж байсан зенитийн пуужингийн цогцолбор "Тор"-той ажиллууж байжээ.

Уг станц нь зөөврийн (МРЛС1Л122-1Е) болон техник дээр суурилуулсан (МРЛС1Л122-2Е) гэсэн 2 хувилбартай.

Үзэсгэлэнд дэлгэн үзүүлснээр өөрөө явагч "Гармонь"-1Л122-2Е, хувилбар нь МТ-ЛБу загварын гинжит явах анги дээр суурилагдсан. Энэ хувилбар нь антен өргөх төхөөрөмж, удирдлагын болон цахилгаан хангамжийн нэмэлт төхөөрөмжүүдээр тоноглогджээ. Ингэснээр түүний хүчин чадал, илрүүлэх алслалт 2 дахин нэмэгдсэн байна.

Бага оврын гурван хэмжээт радиолокацын станц 1Л122Е-ийг радиолокацын станц П-19, П-18-тай харьцуулсан судалгаа /хүснэгтээр/

Харьцуулсан дүгнэлт

- Тактик техникийн өгөгдөхүүнийг харьцуулан үзэхэд саатуулгаас хамгаалагсан байдал, маневрын боломж, эрчим хүчний зарцуулалт, илрүүлэх өндөр нь илүү байгаа нь харагдаж байна.
- Зах зээлийн үнэ өртөг, эдийн засгийн хэмнэлттэй байдал, хүний эрүүл мэндийн хамгаалалт зэрэг



Тактик техникийн өгөгдөхүүн

	МРЛС1Л122-1Е	МРЛС1Л122-2Е	П-19	П-18
Ажлын				
Ажлын цар	дециметр	дециметр	дециметр	метр
Илрүүлэх алс км	1-40	1-80	160	260
Азимуаар, градус	360	360	360	360
Байрын өнцгөөр, градус	-5 –аас 40	0-60		
Өндрөөр, км	10-аас багагүй	20	6 хүртэл	20 хүртэл
Агаарын целийн хурд м/с	700 хүртэл	700 хүртэл		
Координатыг тодорхойлох нарийвчлал				
Алслалт, м	100	100	90 м	1400м
Азимуаар, градус	0,5	0,3	0,3	47 мин
Байрын өнцөг, градус	1,5	1	1,5	
Саатуулгаас хамгаалагдсан байдал				
Байрын саатуулга, дБ	55	55	40	20
Идэвхтэй саатуулга, дБ	40	40	32	20
Эрчим хүчний хэрэглээ, Вт /ихгүй/	800 Вт	5000 Вт	10 кВт	10 кВт
Тогтмол гүйдлийн цахилгаан тэжээлээс	22-30	22-30	220	
Хүндийн жин	150 кг	900 кг		
Антен цацруулагчийн оврын хэмжээ	1200x800	1900x1800		
Нэвтрүүлэх байгууламж			Ламп	Ламп
Мэдээллийг гарах төрөл	тоон	тоон	аналог	аналог

давуу талуудыг харж болно.

- Энэ радиолокацын станцыг ашигласнаар станц дээр ажиллах инженер техникийн ажилтнуудын ажил, орон тоог хөнгөвчлөж, олон цагаар найдвартай ажиллах нөхцөл боломж нэмэгдэнэ.
- Сансрын хиймэл дагуулын системийг ашиглан мэдээлэл авах боломжтой болсон.

Иймээс орчин үеийн байлдааны ажиллагааны шинж чанарт нийцүүлэн

ашиглах боломжтой гэж үзэж байна.

3. Сайжруулах зарим арга зам

3.1 Зенитийн өөрөө явагч суурь ЗСУ-23-4М. Зенитийн өөрөө явагч суурь "Шилка" нь Варшавын гэрээний орнуудад, Ази, Африк, Ойрхи дорнотын орнуудын армийн зэвсэглэлд байдаг бөгөөд 1960-аад оны Араб-Израйлийн орон нутгийн дайнаас авахуулаад халуун цаг агаартай хойт Африк, Афганистаны байлдааны ажиллагаа, Косово, Чечень, Ирак зэрэг орон нутгийн болон бүс нутгийн



Станц байлдааны байдалд



Өөрөө явагч суурь МТ-ЛБу дээр суурилсан МРЛС1Л122-2Е загвар



байлдаануудад өргөнөөр ашиглаж ирсэн. 1973 оны 10 дугаар сард Сирийн АДХ-ын хэрэгсэл ЗПЦ "Квадрат", ЗПЗЦ "Стрела-2М" ЗӨЯС "Шилка"-ээр 98 онгоц сөнөөсний 11-ийг зенитийн өөрөө явагч суурь "Шилка" устгасан байна. Түүнээс гадна "Шилка" нь говь цөл болон уулархаг газар оронд туулах чадвар сайтай, өндөр маневрлах боломжтой гэдгээ харуулсан байдаг. Хамгийн сүүлийн жишээ бол Сирийн армийн зүгээс босогчдын эсрэг ашиглаж байна.



Бидэнд тулгамдаж байгаа асуудал.

Зенитийн өөрөө явагч суурь ЗСУ-23-4М манай улсын зэвсэгт хүчний зэвсэглэлд 1979 онд орсон бөгөөд 40 шахуу жил ашигласан ашиглалт гүйлт норм нь гүйцсэн байна. Нэгэнт бид шинэ зэвсэглэл ойрын хугацаанд авах боломж хязгаарлагдмал байгаа тул байгаа зэвсэглэлийнхээ бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх боломжийг дээшлүүлэх арга замыг эрэлхийлсээр байх шаардлага тулгарч байна.

Иймд шийдвэрлэх дараах арга замуудыг санал болгож байна

1. Дотоод нөөц бололцоондоо тулгуурлан инновац шингээн сайжруулах
2. ОХУ-д их засварт явуулж, зарим эд ангиудыг сольж шинэчлэх
3. Украйнд хийгдэж байгаа тоон системээр шинэчлэн сайжруулах

1 дэх арга зам нь сэргээн сайжруулагдсан ЗСУ-23-4М-ийн дараагийн загваруудаас үлгэр авбал дараах зүйлсийг бид хийж болох юм.

- Ухрах камер болон телевизийн оптик систем суурилуулах;
- Зөөврийн зенитийн пуужингийн цогцолбор Игла 1Э эсвэл зенитийн пуужин Стрела-г суурилуулах;
- Үндсэн хөдөлгүүр болон бусад эд

ангиудад их засвар хийх;

- Дээрхийг зөвхөн зенитийн өөрөө явагч сууриудад ч бус бусад хуягт техникүүдэд ашиглаж болох юм.

2 дахь арга зам нь хэрэгжих бүрэн боломжтой бөгөөд урьд нь бид 2 суурийг их засварт оруулж байсан туршлага байна. ОХУ-тай хамтарсан хээрийн сургуулиудийн үед зарим нэг бага хэмжээний засвар үйлчилгээ хийгдсэн боловч доривтой ахиц гарахгүй байна. ЗСУ-23-4М-ийн дараагийн загваруудын хоёрдогч цахилгаан үүсгүүрийн хийн тийрэлтэд хөдөлгүүр ГТД-г солиулж тавиулбал бидэнд эдийн засгийн багагүй хэмжээний хэмнэлт бий болно. Одоо байгаа хийн тийрэлтэд хөдөлгүүр ГТД нь 1 цагт 96 л дизелийн түлш зарцуулдаг бол түүнийг дараагийн загвар нь цагт 36 литр түлш зарцуулдаг.



Үзүүлэлт	ГТД1	ГТД5М
1 мото/цагт зарцуулах түлш	96 л	36 л
50 мото/цагт зарцуулах түлш	4,800 л	1,800 л
1 л түлшний үнэ 1650 төг	7,920,000	2,970,000
Батарей орон тоогоор 6 ЗӨЯС-тай гэвэл	47,520,000	17,820,000
1 жилд гарах зөрүү	29,700,000	

Ингэснээс зөвхөн нэг суурийн хувьд ангийн сургалт бэлтгэлийн үндсэн төлөвлөгөөнд заагдсан төлөвлөгөөт хичээл сургалт, буудлага мөн байлдааны жижүүрлэлт гээд багаар бодоход 50 мото/цаг ажиллах шаардлага гардаг. Энэ нь жилд 4,800 литр түлш хэрэглэдэг гэсэн үг. Үүнийг одоогийн дизелийн түлшний зах зээлийн хамгийн бага ханшаар 1650 төгрөгөөр бодвол зөвхөн нэг суурь дээр 7,920,000 төгрөгийн зардал гарч байна. Бид дараагийн загварын ГТД-г сууриулбал 2,970,000 төгрөгийн түлш зарцуулах буюу бодит хэмнэлт нь 4,950,000 төгрөгийг зөвхөн нэг сууриас хэмнэж болно. Батарей орон тоогоор 6 зенитийн өөрөө явагч суурьтай гэвэл бид жилд багадаа 29,700,000 төгрөг хэмнэж болох нээ. Их засварт явсан суурийг багадаа 10 жил ашиглана гэвэл хэмнэлт нь засварын



зардлыг нөхөх хэмжээний хөрөнгө мөнгө болно.

З дахь арга зам: Украин, Беларусь, Энэтхэг зэрэг улсуудад ЗӨЯС ЗСУ-23-4М ийг сэргээн сайжруулсаар байгаа бөгөөд тэдэнтэй хамтран ажиллах. Тэд РЛС-ийг нь бүрэн шинэчлэж тоон технологид шилжүүлж байна. Үүнд мөн адил түлшний зарцуулалт багатай хийн тийрэлтэд хөдөлгүүрийн асуудлыг шийдсэн байна.



3.2 Хос гол төмөрт зенитийн автомат суурь ЗУ-23-2. Энэ зэвсэглэл дээр инновац нэвтрүүлэх өргөн боломжтой бөгөөд ОХУ-д ч шинэчлэн сайжруулсаар байна. Заримаас нь дурдвал.



Үүний нэг жишээ нь "Самум" юм. Араб хэлээр "Самум" гэдэг нь "цөлийн хуй салхи, замдаа таарсан бүхнийг хуу хамна" гэсэн утгатай юм. Албан бус бас нэг нэр нь "Дроны алуурчин" гэгдэх болжээ.

Туулах чадвар өндөртэй 4x4 машин нь Ярославскийн моторын завод (ЯМЗ)-д үйлдвэрлэгдсэн 200 морины хүчтэй дизель хөдөлгүүр, тэжээлийн үүсгүүртэй юм. Байлдааны машин мэргэн буудагчийн винтовын сум нэвтрэхгүй



байхаар хуяглагдсан. Үндсэн зэвсэглэл нь минутад 2000 буудлага хийх боломжтой хос гол төмөрт зенитийн суурь (ЗУ-23-2)-ийн сайжруулагдсан загвар бөгөөд гал удирдах ухаалаг систем, олон сувгийн хараалах систем, лазер хол хэмжигч, сум цель 2-ийн уулзах цэгийг тооцоолон бодох систем, мөн нэмэлтээр 2 ширхэг зенитийн пуужингын зөөврийн цогцолбор "Игла"-аар хүчжүүлж болох юм.

Гол давуу тал нь хуягласан жолоочийн бүхээг дотроос буг удирдаж, 160 км/цаг хүртэл хурдлах чадвартай байлдааны машины хурдыг сааруулахгүйгээр агаарын целийг хараалж, буудлага явуулах боломжтой юм. Энэ нь түүнд Мадейрын өндөр боломжийг олгох төдийгүй түүний галын бүсээс дрон усгагдахгүйгээр гарах боломжгүй юм.

Галын удирдлагын ухаалаг систем нь сүүлийн үеийн дулааны дүрслэл бүхий монитор, лазер хол хэмжигч, цахилгаан хөтлөгчтэй удирдлагын пулт зэргээс бүрдэнэ. Зохион бүтээгчдийн хэлж байгаагаар дулаан мэдрэгч нь нисэж яваа шувууны дулааныг мэдэрч илрүүлжээ.

Удахгүй бүтээхээр төлөвлөж буй Арктикийн хувилбар нь экипажгүйгээр бүрэн автомат робот болгох боломжтой гэж үзжээ. Одоо түүний 3 дахь нэр нь "ирээдүйн хуягласан машин" гэж нэрлэгдэх болсон.



3.3 57 мм-ийн зенитийн автомат буу. 57 мм-ийн зенитийн автомат буу нь байрын өнцгөөр болон азимутаар эргүүлэх редукторуудтой бөгөөд инновац бүтээхэд шаардлагатай бүх электрон төхөөрөмжүүдээр тоноглогдсон. Жишээ дурдахад Индонезод түүнийг ухаалаг хавтан, утас, зөөврийн компьютерээс удирдах боломжтой болгосон байна.



Өөрөө явагч зенитийн артиллерийн цогцолбор 2С38 ЗАК-57 "Деривация-ПВО"

"Деривация-ПВО" Агаарын целийг оптик-дулаанаар илрүүлэх тагнуулын болон хараалах систем бүхий хөдөлгөөнт зенитийн артиллерийн цогцолбор бөгөөд ННХ, далавчит пуужин, тактикийн авиац, галын дэмжлэгийн нисдэг тэрэг, түүнчлэн тийрэлтэд галын системийн пуужин, газар болон усан дээрхи целиүдтэй тэмцэл явуулах үүрэгтэй.

Явган цэргийн байлдааны машин БМП-3 дээр суурилсан 57 мм-ийн зенитийн артиллерийн автомат буугаар зэвсэглэсэн агаарын довтолгооноос хамгаалахын шинэ зэвсэглэлийн 2017 онд "Арми-2017" үзэсгэлэнд дэлгэн үзүүлсэн.





Дүгнэлт. ОХУ-ын ЗХ ЦАДХ-ын цэрэгт ихээхэн анхаарал хандуулж байгаа нь зэвсэглэл техникийн шинэчлэлийн эрчимжүүлж байгаагаас тодорхой харагдаж байна. МУ-ын ЗХ-ний ЦАДХ-ын зэвсэглэлүүд тавигдаж буй шаардлагыг тэр бүр хангахгүй байна. Тиймээс удирдлагын автоматжуулсан системийн боломжит хувилбаруудыг зэвсэглэлд нэвтрүүлэх шаардлагатай байгааг судалж дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- МУ-ын ЗХ-ний ХЗЦ-ийн АДХ цэрэг нь сургууль дадлага, байлдааны жижүүрлэл, жил бүр буудлага, харвалтаа хийж, дайчилгааны нөөц бэлдэж чадаж байгаа төрлийн цэрэг юм. Энэ төрлийн цэрэг нь болзошгүй аюулын үед маневрлах чадвар өндөртэй, түүгээрээ дамжуулан эсрэг талд олон гэнэтийн бэлэг барьж чадах учир үүнийг анхаарах шаардлагатай байна.
- ОХУ бидэнд алсын тусгалтай пуужин, нэн шинэ зэвсгээ өгөхгүй нь тодорхой боловч болсон үйл

явдлаас харахад 30-40 жилийн өмнө үйлдвэрлэсэн АДХ-ын зэвсэглэлүүд Сирид барууны нэн өндөр цэцтэй зэвсгийн эсрэг үр дүнтэй тулалдсан гэж экспертүүд дүгнэж байна. Иймд үүнийг ч бас тооцоолох нь зүйтэй.

- ННХ-тэй тэмцэх, түүнд бие бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах, шаардлагатай зэвсэглэл техникээр хангах явдал юм. МБХ-уудад байгаа зенитийн салбараас ННХ-тэй тэмцэх хайгуул устгалын бүлэг байгуулах нь хамгийн оновчтой хувилбар гэж үзэж байна.
- ОХУ-аас зохион байгуулдаг Цэргийн наадмын "Цэлмэг тэнгэр" тэмцээнд оролцох, АНУ-ын Аляска мужид явагддаг олон улсын АДХ-ын цэргийн хамтарсан хээрийн сургууль дадлагад оролцдог байсан уламжлалаа сэргээснээр бие бүрэлдэхүүний бэлэн байдал, сургалтад бодитой дэмжлэг болно.

Ашигласан материал:

1. Агаараас эсэргүүцэн хамгаалалт.УБ.,1974.
2. Далхаасүрэн.Т.Зенитийн өөрөө явагч суурь ЗСУ4-23-М. УБ.,2009.
3. Зенитийн артиллерийн дивизион, батарейны тагнуул ба холбоо.УБ.,1973.

Интернет сайтууд

- <https://ru.wikipedia.org/wiki/>.
- <https://topwar.ru/-68472radiolokacionnaya-stanciya1-l-122garmon.html>.
- <http://bastion-opk.ru/111-122e>.



ХАС БЭЛГЭДЭЛ ТЭМДГИЙН ХЭРЭГЛЭЭ ЗЭВСЭГТ ХҮЧИНД



Н.ХҮДЭРБАТ /БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан докторант, хошууч/

Түлхүүр үг: Хас бэлгэдэл тэмдэг, Монгол ардын журамт цэрэг, Цолны мөрдэс

Key words: Swastika symbol, Mongolian People's revolutionary Army, Military rank insignia

Бидний өвөг дээдэс байгалийн сүр хүч, түүний зүй тогтол, хэм хэмжээсийн утга учир, шалтгааныг танин мэдэж, хайн олж улмаар түүнийг захиран эзэмших гэсэн хүсэл эрмэлзлээ анхлан дүрс хэлбэрийн бэлгэдэл тэмдгээр илэрхийлэх болсон. Энэхүү дүрс хэлбэрийн бэлгэдэл тэмдгийн нэг бол хас хэмээх бэлгэдэл тэмдэг юм¹.

Зөвхөн энэхүү бэлгэдэл тэмдгийг дэлхийн улс орны Зэвсэгт хүчинд хэрхэн бэлгэдэн хэрэглэж байсныг гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын бүтээл, вэб сайтууд дээр дурдагдсан материалуудыг харьцуулан судлахын зэрэгцээ мөн Батлан Хамгаалахын Төв архивт хадгалагдаж байгаа архивын эх сурвалж болон бусад холбогдох баримтуудыг иш үндэс болгон нэгтгэн та бүхэнд толилуулж байна.

Түүх өгүүлбэл: 1911 он буюу Богд хаант Монгол улсын үед төрийн албаны ноёд түшмэдийн зэрэг дэвийг ялгах тэмдгүүдийн нэг нь хас бэлгэдэл тэмдэг болж байв.



Алтан хас бүхий энгэрийн ялгах тэмдэг (фүз)

Зэрэг дэвийн ялгах тэмдгийг тухайн үед **фүз*** (пүүз) хэмээн нэрлэж байсан ба Монголын хаан, хан, ван, бэйл, бэйс, гүн, тайж, түшмэд нар зэрэг дэвээсээ хамаарч тус тусийн фүз тэмдэг зүүдэг байжээ. Тухайн үед фүз тэмдгэнд хэрэглэж байсан лууны дүрсийг халж соёмбо, бум үсэг, алтан нар, сар, таван нүдэн, хас, өлзий, чандмань, лавай зэрэг монгол тэмдэгтэй байхаар "Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг" -т заажээ.

Энэ хуулинд Богд хаанаас эхлэн төрийн бүх хэргэм зэрэгтэн нар, тухайлбал; хаан, хан, ван, бэйл, бэйс, гүн, тайж, түшмэд бичиг хэргийн болон цэргийн цол хэргэмтнүүдийн зэрэг дэвийн ялгааг заасан хувцас хэрэглэлийг тогтоож, зэрэг дэвийн фүз² тэмдгийн ялгааг мөн тодорхой зааж өгсөн байна. Уг хуулийн тайж түшмэдийн зэрэг дэвийн тухай бүлэгт тайж нарыг дөрвөн зэрэг, түшмэдийг есөн зэрэгтэй байхаар тогтоож үүнээс түшмэдийн зэрэг дэвийн фүз тэмдэг ямар байхыг нарийвчлан заасныг эшлэж дурдвал: ... гутгаар зэрэг түшмэд "**Алтан хас**" хатгасан дөрвөлжин фүз хэрэглэдэг байсан³ бол 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгалын ялалтын нөлөөгөөр Ардын журамт цэргийн хувцас, хэрэглэлийг дэлхий нийтийн жишигт нийцүүлэх үүднээс цэргийн шинэ цол, зэрэг дэвийг шинэчлэх шаардлага тулгарсан. Үүнд: Бүх цэргийн жанжин, цэргийн яамны сайд Д.Сүхбаатар "Цэргийн сахилга батыг сайжруулах, цэргийн таних тэмдэг зэргийг зөв хэрэглүүлэх тухай" 1921 оны

¹ Хүдэрбат.Н. "Дэлхийг хасаар тамгалсаар" УБ., 2012. т.7

* Фүз ба пүүз гэдэг хоёр үг нь нэг утгыг илэрхийлнэ. Хэргэм зэрэгтний хүрэмний ар өвөр болон хоёр мөрөн дээрх ямбаны тэмдэг (ялгах тэмдэг)-ийг хэлнэ.

² "Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь" УБ., 2008. IY. (Т-Хө) т.2349

³ Нямаа.Б, Ганболд.Г "Монголын хоёр төрийн мөнгөн тэмдэгт 1921" УБ., 2007. х.191-197



Гутгаар зэргийн түшмэл. Мишиг гүн.

7 дугаар сарын 16-ны өдрийн 2 дугаар тушаалын 6 дугаар зүйлд заасны дагуу цэргийн дарга болон хувьсгалт цэргүүдэд монголын үндэсний хас тэмдэг бүхий улаан даавуугаар хийсэн цэргийн цолны ялгах тэмдэг хэрэглэхийг заасан байдаг.



МАЖЦ-ийн ханцуйн ялгах тэмдэг
1921.07.16

Тус ялгах тэмдэг нь "шар өнгөтэй гурвалжин, тал бүрийн урт нь 5 дюйм буюу 1 см 27 мм (1 дюйм=25,4 мм)⁴ хэмжээтэй даавуун дээр монгол үндэстний уламжлалт бэлгэдэл хээний нэг болох хас тэмдгийг улаан даавуугаар хадах ба доод хагаст нь хааж буй албаны улаан дөрвөлжин ба ромбыг хадна" гэж заажээ⁵.

Мөн Бүх цэргийн зөвлөлийн 1923 оны 3 дугаар сарын шинийн 9 буюу аргын тооллын 4 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрээр тусгай комиссын түшмэдээс цэргийн алба хаагчдын хувцсанд хадах тэмдэг, зургийг үйлдэн баталж хэрхэн хэрэглэхийг зааснаар дээрх ялгах тэмдэг өөрчлөгдөж, ханцуйн тэмдэг нь таван хошуу дотор хас тэмдэг

дүрсэлсэн, төрөл мэргэжлийн цэргийг заасан их буу буюу пулемётын зурагтай болж шинэчлэгдсэн байна.

Энэхүү цолны ялгах тэмдгийг Европ хувцсанд ханцуйн үзүүрт, харин Монгол дээлэнд ханцуйны угт хадахаар зааж, тухайн оны 4 дүгээр сарын шинийн 1-ээс эхлэн хэрэглэхээр зааж, Ардын намын төв хороо, дотоодын зэрэг 4 яамд Монгол ардын хувьсгалт цэргийн сурган боловсруулах хэлтэс, Ховд, Улиастай, Алтанбулаг хотын сайдууд, төлөөний хамаарсан жанжин, сайд, зүүн ба Тамсагбулаг, зүүн өмнө хязгаарын сайдууд ба өмнө хязгаарыг сэргийлэх цэргийг захирах түшмэл нар дотоодыг хамгаалах газруудад тэмдгийн загварыг илгээж⁶ ... хэрэглэхийг даалгаж байв.

Удалгүй 1925 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн МАХН-ын төв хорооны тогтоолоор хас тэмдгийг хэрэглэхийг хориглох шийдвэр гарсантай холбогдуулан Монгол ардын хувьсгалт цэргийн алба хаагчдын зэрэг дэвийг илэрхийлсэн ялгах тэмдгийг дахин шинэчилж, өөрчлөн баталснаар хас бэлгэдэл тэмдэг Монголын Зэвсэгт хүчний салбарт бүр мөсөн хэрэглэгдэхээ больсон түүхтэй.

Хуучнаар Зөвлөлт Холбоот Улс буюу Оросын Холбооны Улсын Батлан хамгаалахын цэргийн түүхийн институтыг удирдаж байсан түүх судлаач, хурандаа В.О.Дайниса Зөвлөлтийн армийн төв архивт хадгалагдаж байсан баримтуудыг судлан үзэх явцдаа Улаан армийн цэргүүд хас бэлгэдэл тэмдэг хэрэглэж байсан талаарх мэдээллийг олж судалгааны эргэлтэд оруулсан юм.

1919 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр хас бэлгэдэл тэмдэг нь Улаан армийн цэргийн алба хаагчдын ханцуйн бэлгэ тэмдгийн загвар болжээ. Энэхүү ханцуйн бэлгэ тэмдэг нь 15x11см улаан



Аравны дарга (пулемёт) МАЖЦ-ийн ханцуйн ялгах тэмдэг
1923.03.09

⁴ <https://ru.wikipedia.org/wiki/Дюйм>

⁵ АЕГ.УТН, ОНБА. Сх.4. д.1 хн.361. т.3

⁶ АБХТА. Сх.1 д.1 хн.9 нэг нугалбар бичиг

материалаар хийсэн ромбо, дээд буланд 5 хошуу, (15мм) голдоо цэцэгт титэм, (6 см) түүн дотор хас тэмдэг байх бөгөөд ЛЮНГТН (27мм) РСФСР үсэг (6мм) лентийг нь алтан утас (шар өнгийн)-аар цэцэг титэм ба гар бичмэлийг мөнгө (цагаан) утсаар тус тус оёсон байна.



Улаан армийн
цэргийн ханцуйн
бэлгэ тэмдэг
1919.11.03

Энэхүү тэмдгийг хурандаа В.И.Шорин (1871.1.7-1938.6.29)⁷ зохиосон хэмээн үздэг бөгөөд дээрх цолны ялгах тэмдгийг Зөвлөлтийн улаан армийн цэргийн алба хаагчид мөн хэрэглээгүй юм.

Харин Оросын иргэний дайны үед орос болон ази гаралтай үндэстнүүдээс бүрдсэн "Азийн морин дивиз" хэмээх нэгтгэл, ангийг Барон Унгерн фон Штернберг (1886.01.10-1921.09.1)⁸ захирч байсан бөгөөд тус дивизийн бүрэлдэхүүнд багтаж байсан ази үндэстнүүдээс бүрдсэн морьт хороодын цэргийн алба хаагчид хас бэлгэдэл тэмдэгтэй цолны ялгах тэмдгийг хэрэглэж байсан⁹ хэмээх ам дамжсан яриа байдгийг үндэслэн доорх цолны ялгах



Азийн морин дивизийн хошууч генерал Левицки "Шударга Баатар Цог Жавхлант"-ийн командласан ангид харьяалагдаж байсан ази үндэстнүүдээс бүрдсэн цэргийн алба хаагчдын цолны мөрдэсний загвар.

1. Төвөд цэргийн морьт хорооны цэргийн алба хаагчдын цолны мөрдэс
2. Монгол цэргийн морьт хорооны цэргийн алба хаагчдын цолны мөрдэс
3. Хятад цэргийн морьт хорооны цэргийн алба хаагчдын цолны мөрдэс

тэмдгийг вэб сайтуудаас иш үндэс болгон авч энэхүү нийтлэлд оруулсан болно.

1920 оны сүүлээр АНУ-ын Оклахома мужийн армийн үндэсний гвардын 45 дугаар явган цэргийн дивиз Аризона, Колорадо, Шинэ Мексик, Оклахома зэрэг мужийг хамгаалж байсан бөгөөд тус дивизийн ялгах тэмдэг болох хас бэлгэдэл тэмдгийг 1924 оны 8 дугаар сард баталсан бөгөөд цэргийн алба хаагчдын мөрдэс, ханцуйн ялгах тэмдэг дээр ромбо хэлбэртэй улаан даавуун дээр улбар шар өнгөтэй хас тэмдэг хэрэглэгдэх болжээ.

Гэвч энэхүү дивизийн ялгах тэмдэг нь улс төрийн үзэл баримтлалын нөлөөнөөс шалтгаалан уугуул америкуудын бэлгэ тэмдгийн нэг болох тундрын шувууны дүрстэй болж 1939 онд өөрчлөгдсөн түүхтэй.

Хас бэлгэдэл тэмдэг нь мөн дэлхийн II дайнаас өмнө Их Британи, Финланд, Латвийн Зэвсэгт хүчинд хэрэглэгдэж байсан бол 1920 оны 8 дугаар сарын 7-ны өдөр Сальцбургийн Конгрессийн шийдвэрээр тус бэлгэдэл тэмдгийг Германы Үндэсний Социалист Ажилчны Нам буюу Нацист намын албан ёсны бэлгэ тэмдэг болгосон¹⁰ бөгөөд энэхүү бэлгэ тэмдэг удалгүй 1935 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Германы төрийн бэлгэ тэмдэгний журам зохицуулах хуулийн дагуу төрийн далбаанд дүрслэн хэрэглэгдэхээр хуульчлан баталгаажсан юм¹¹.



Энэ үеэс эхлэн хас тэмдгийг Германы Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүдийн эмблем, зэвсэг техник, одон медаль, марк, ил захидлуудад аугаа их ялалт, сүр хүч, гэрэл гэгээний илэрхийлэл хэмээн үзэж өргөн дэлгэр дүрслэн хэрэглэх болжээ.

Мөн 1935 оны 9 дүгээр сараас 1945 оны 5 дугаар сарын эхэн хүртэл хас тэмдэг Европт Герман улсыг илэрхийлэх бэлгэдэл тэмдэг болсон юм.

⁷ https://ru.wikipedia.org/wiki/Шорин,_Василий_Григорьевич

⁸ https://mn.wikipedia.org/wiki/Барон_Унгерн_фон_Штернберг

⁹ <https://archive.is/KnDh#selection-461.0-483.1134>

¹⁰ <https://www.learning-mind.com> > Food for thought

¹¹ https://en.wikipedia.org/wiki/Nazi_symbolism



Дэлхийн II дайнд Германы өөрийгөө хамгаалах Зэвсэгт хүчний (SS) 40 дивизийн 38 нь оролцсон бөгөөд тус дивизүүдэд сайн дурын үндсэн дээр олон үндэстний цэргүүд алба хааж байсан ба нийт 3 дивизэд хас тэмдгийг эмблем болгон хэрэглэж байжээ.



СС-ийн 11 дүгээр дивизийн эмблем. Энэхүү дивизийн цэргийн алба хаагчдын ихэнх бүрэлдэхүүн нь Югослав, Хорватчууд байв.



СС-ийн 27 дугаар дивизийн эмблем. Энэхүү дивизийн бие бүрэлдэхүүн нь Фламанд (Бельги, Румин, Нидерланд, Франц, Голланд)-ын сайн дурынхнаас бүрдэж байсан.



СС-ийн 5 дугаар Панзер (Panzer) танкийн дивизийн эмблем. Тус дивиз нь Скандиновын хойг дээр орших Дани, Норвеги, Швед, Финланд, Оросууд мөн нутгийн уугуул Герман үндэстнүүдээс бүрдсэн холимог бүрэлдэхүүнтэй байжээ.

Тухайн үед Германы өөрийгөө хамгаалах Зэвсэгт хүчний (СС) 13 дугаар уулын дивизийн Хендерс (Handschar) хэвлэл мэдээллийн ажил хариуцсан хэлтэс (алба) суртал ухуулгын ажлыг Босни, Херцеговина, Хорват улсын нутаг дэвсгэрт зохион байгуулан явуулж байв. Энэхүү хэлтсийн цэргийн алба хаагчдын петлиц дээр хас тэмдэг мөн дүрслэгдсэн байдаг¹².



Хендерс хэлтсийн цэргийн алба хаагчдын дүрэмт хувцас (петлиц). 1943-1945.

Дэлхийн II дайны дараа буюу 1945 оны сүүл үеэс энэхүү тэмдгийг нацист (хүчирхийлэл)-ын үзэл суртлын бэлгэ тэмдэг хэмээн үзэж, Герман улсын эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлд заасны дагуу Герман улсад хэрэглэхийг хориглосон түүхтэй¹³. Харин 1991 оноос Латви улсын Үндэсний гвардын 22 дугаар явган цэргийн мотобуудлагын батальоны

лого буюу ялгах тэмдгэнд хас бэлгэдэл тэмдэг дүрслэгдэн хэрэглэгдэж байсан.



Дэлхийн I дайны үе.
Америкийн нисэх хүчний онгоц



Дэлхийн I дайны үе.
Английн нисэх хүчний онгоц



1919-1940 оны хооронд хас тэмдэг Латвийн агаарын нисэх хүчний бэлгэ тэмдэг болж байв. Их Британ улсад үйлдвэрлэгдсэн "Gloster Gladiator" загварын онгоц.



Германы нисэх хүчний онгоц
Дэлхийн анхны тийрэлтэт хөдөлгүүрт онгоц
Мессершмитт Me-262 "Хараацай" 1943 он.

¹² https://en.wikipedia.org/wiki/13th_Waffen_Mountain_Division_of_the_SS_Handschar_%28st_Croatian%29

¹³ <http://www.zukunft-braucht-erinnerung.de/das-hakenkreuz-geschichte-eines-ns-symbols/>



Америкийн хоёрдагч эмэгтэй нисгэгч Матильдэ Мойсант (1878.9.13–1964.02.05)

Америкийн анхдагч нисгэгчдийн нэг Мойсант Нью-Йоркын Лонг Айланд дахь Алфредын "Мойсант нисгэгчийн сургууль"-д суралцсан.

1911 онд Матильдэ Мойсант Америкийн нисэх клубээс нисгэгчийн үнэмлэх гардан авсан бөгөөд АНУ-ын түүхэнд хоёр дахь эмэгтэй нисгэгч болсон түүхтэй. Тухайн оныхоо 9 дүгээр сард эмэгтэйчүүдийн нислэгийн өндрийн дээд амжилтыг эвдэж 370 метрийн өндөрт нисчээ.

Түүнийг 1912 онд "Амжилт" хэмээх хас тэмдэг бүхий медалиар шагнан урамшуулж байв.




Хурандаа генерал Эрнст Удэт (1896.4.26-1941.11.17)

Хурандаа генерал Эрнст Удэт дэлхийн I дайнд хамгийн олон онгоц устгасан Германы чадварлаг нисгэгчээр тооцогдож байсан.

Дайны өмнө тэрээр нисэхийн цирк, онгоц угсрах үйлдвэрт ажиллаж байгаад А.Гитлерийн үед түүний удирдлагад ажиллаж байсан. Тэрээр 1936 оны Берлин хотод зохион байгуулагдсан олимпын нээлтэд нисэх онгоцоор үзүүлбэр үзүүлэх ажиллагааг удирдсан.



Латвийн Үндэсний гвардын 2 бригадын 22 дугаар мотобуудлагын батальоны (1991 онд байгуулагдсан) цэргийн алба хаагчдын ханцуйн ялгаж тэмдэг. Тус батальон Латви улсын Волмар хотод байрладаг.



Берлин хотод зохион байгуулагдсан зуны XI олимпын нээлт. Нисэх онгоцны үзүүлбэр (1936.08.01-08.16)



Дэлхийн II дайны үед Финландын армид хэрэглэгдэж байсан танк Hoshever T-26 загвар



Финланд улсын агаарын нисэх хүчний туг



1991 оноос эхлэн Монгол Улсын Зэвсэгт хүчин уламжлалт хас бэлгэдэл тэмдгийн оронд (дан болон давхар өлзий хээ) тэмдгээ дахин хэрэглэж эхэлсэн түүхтэй. Дэлхийн улс орнуудын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдын мөрдэс, ялгах тэмдгийн жишигт нийцсэн таван хошуу, сумны зэв (ахлах даргын ялгах тэмдэг, оны ялгаа, удаан жилийг илэрхийлсэн тэмдэг) буюу суурьгүй гурвалжин мөн хөндлөн зураас (хашилтан) тэмдгүүдийг 2017 оноос Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид хэрэглэж эхэлсэн.

Гэвч дээрх бэлгэдэл тэмдгүүд нь дэлхийн жишигт нийцсэн цолны ялгах тэмдэг мөн эсэх нь эргэлзээтэй байна. Учир нь зөвхөн энэхүү нийтлэлийг бичих явцад өрөөсгөл ойлголт болох нь дараах дүгнэлтүүдээр нотлогдож байна. Үүнд:

1. Учир юу хэмээвээс хөгжингүй, буурай хөгжилтэй, социалист үзэл баримтлалтай улс орны цэргийн алба хаагчдын хэрэглэж байгаа мөрдэс, ялгах тэмдэгт ихэвчлэн

таван хошуу тэмдэг хэрэглэгдэж байна.

2. Мөн зарим өндөр хөгжилтэй улс орны Зэвсэгт хүчинд зөвхөн цэргийн дээд цолтон (генерал)-ны мөрдэс, ялгах тэмдгэнд таван хошуу тэмдгийг хэрэглэх явдал түгээмэл ажиглагдаж байна.
3. Харин ахлагч нарын мөрдэс, ялгах тэмдэг нь дэлхийн улс орны Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдын хувьд ерөнхийдөө нэгэн ижил боловч мөн өөрсдийн уламжлалт онцлог, бэлгэдэл загварыг шингээсэн байна.

Ийм учраас өнөөгийн нийгэмд өөрийн гэсэн уламжлалт соёлоо хадгалж үлдэх үзэл санаа улс орон болгонд хүчтэй өрнөж байгаа билээ. Үүнтэй холбогдуулан цаашид бид үндэсний соёлын бэлгэдэл тэмдгүүдээ маш сайн нягталж, судлан үзэж өөрийн улсын түүхэн уламжлалт бэлгэдэл тэмдгүүдээ цэргийн мөрдэс, цолны ялгах тэмдгэнд хэрэглэх шаардлагатай хэмээн үзэж байна.

Ашигласан материал:

1. АЕГ.УТН, ОНБА. Сх.4. д.1 хн.361. т.3
2. АБХТА. Сх.1 д.1 хн.9 нэг нугалбар бичиг
3. Хүдэрбат.Н. "Дэлхийг хасаар тамгалсаар" УБ., 2012. т.7
4. Нямаа.Б, Ганболд.Г "Монголын хоёр төрийн мөнгөн тэмдэгт 1921" УБ., 2007. х.197-191
5. "Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь" УБ., 2008. ҮҮ. (Т-Хө) т.2349
6. <https://archive.is/KnDh#selection483.1134-461.0->
7. https://mn.wikipedia.org/wiki/Барон_Унгерн_фон_Штернберг
8. <https://ru.wikipedia.org/wiki/Дюйм>
9. https://ru.wikipedia.org/wiki/Шорин,_Василий_Григорьевич
10. <https://www.learning-mind.com> › Food for thought
11. https://en.wikipedia.org/wiki/Nazi_symbolism
12. https://en.wikipedia.org/wiki/13th_Waffen_Mountain_Division_of_the_SS_Handschar_281%st_Croatian29%
13. <http://www.zukunft-braucht-erinnerung.de/das-hakenkreuz-geschichte-eines-ns-symbols/>



“ЦАГИЙН БАЙДЛЫГ ТОГТООХ” ХЭМЭЭХ НЭР ТОМЬЁНЫ ТУХАЙ ШҮҮМЖ

Ш.ПАЛАМДОРЖ /БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор/

Түлхүүр үг: Цагийн байдал, тогтоох, цагийн байдлыг тогтоох, байлдааны цагийн байдлыг тогтоох, үнэлэх, цагийн байдлыг үнэлэх, байлдаан цагийн байдлыг үнэлэх;

Key words: Situation, install (stabilize), to stabilize, to stabilize of the situation, assessment, assessment of the situation, battle assessment, assessment of the situation of the battle.

Өгүүллийн агуулга: “цагийн байдлыг тогтоох” гэсэн нэр томьёог байлдааны дүрэм, тактикийн бэлтгэлийн хөтөч ном, сурах бичиг, гарын авлагад хэрэглэх нь хэр оновчтой болохыг шүүн тунгааж, энэхүү нэр томьёог цаашид хэрэглэх нь оновчтой бус гэдгийг тайлбарлаж, няцаалт өгөхөд чиглэсэн, урьд өмнө хэрэглэж хэвшсэн “цагийн байдлыг үнэлэх”, “байлдааны цагийн байдлыг үнэлэх” гэсэн нэр томьёог хэвээр ашиглах нь зохимжтой болохыг нотолсон, шинжилгээ, судалгаанд үндэслээгүй аливаа нэр томьёог цаашид дүрэм, заавар, сурах бичиг, гарын авлагад хэрэглэхгүй байх шинжлэх ухааны үндэслэлийг илэрхийлсэн өгүүлэл болно.

Нэр томьёо бол аливаа судлагдахууны онол, арга зүйн үндэс юм. Цэргийн хэлний тогтолцоог бүрдүүлэхэд жигдэрсэн нэр томьёо чухал үүрэг гүйцэтгэдэг. “Үг, нэр томьёо болохдоо хэрэглэгдэх хүрээ нь багасаж, тухайлсан сэдэвт тусгай нэгэн утгаар орох болдог”¹ гэснээс үзэхэд цэргийн нэр томьёо цэрэг, батлан хамгаалахын мэргэжлийн хүмүүсийн хувьд мэргэжлийн ухагдахууны тогтолцоо дахь аль нэг ухагдахуунтай холбоотой тийм үг, хэлний тэмдэг болох нь ойлгогдоно. **Нэр томьёо бол яг таг, нэгэн утгаар нэрлэсэн үг буюу нийлмэл үгээр илэрхийлэгддэг. Цэрэг, батлан хамгаалахын хүрээ хязгаар дотор түүний бусад ойлголтуудтай харилцах харьцааг цэргийн мэргэжлийн хэллэгийг нэр томьёо илэрхийлдэг.** Цэргийн мэргэжлийн үг хэллэг нь энэ мэргэжлийн ажил эрхэлдэг хэсэг бүлэг хүмүүсийн ажил төрөлтэй холбоотой, зөвхөн тэдэнд л нэр

томьёоны чанартай хэрэглэгдэх үгсийн агуулгыг ойлгож байдаг. Цэргийн тухайн нэр томьёо нь цэргийн мэргэжлийн хүмүүстээ тодорхой ойлголтыг өгдөг.

Гадаад үгийг орчуулан ашиглах үед, үг, нэр томьёоны хамаарлыг оновчтой гаргах шаардлага гарч ирдэг. Ямар үг, хэллэгээр нь нэр томьёо болгох нь мэргэжлээс хамаардаг. Нэг үг хэд хэдэн мэргэжлийн хүмүүсд нэр томьёо болон ашиглагдахдаа өөр өөр ойлголтыг агуулсан байдаг. Энэ мэтээр орчуулгын үгэнд энэ нь тухайн ухагдахууны жинхэнэ мөн чанарыг нь илэрхийлж чадаж байна уу гэдэг асуудал байнга тулгардаг.

Нэр томьёог боловсруулах, орчуулан ашиглахад онцгойлон анхаарах, ач холбогдолтой зүйлийн нэг бол үг-ухагдахуун хоёрын харилцан хамаарлын асуудал юм. Жишээ нь “операц” хэмээх үг нь цэргийнхэнд цэргийн урлаг (стратегийн, операц, тактик)-ийн бүрэлдэхүүн хэсэг, цэргийн нэгдлийн хүч, хэрэгслээр байлдааны ажиллагаа явуулах урлаг гэсэн агуулгыг илэрхийлдэг. Харин эмнэлгийн мэргэжилтнүүдэд ажилбар, хагалгаа, эдийн засагч нарт ажиллагаа гэсэн утга агуулгатай байна.

Шинжлэх ухааны болон практикийн өдөр тутмын нэр томьёоны агуулга өөр өөр ч байнга холилддог учраас зовлонтой асуудлыг үүсгэдэг. Практикт стандартын болон хууль эрх зүйн баримт бичгээр тогтоосон нэр томьёог дагаж мөрддөг бол шинжлэх ухаанд тухайн салбар ухаанд тогтсон, үндэслэл тайлбараар баталгаажсан нэр томьёог ашигладаг. Энэ нь шинжлэх ухаанч чанараараа бас няцаагдаж эсвэл үнэмшилд хүрч дагаж мөрдөх үндэс болдог. Нэр томьёо нь

¹ Д.Дашдаваа, Э.Равдан. Нэр томьёоны тухай. УБ., 1980. т.4;



хувьсаж өөрчлөгдөж байдаг, тэр даруйдаа нийтэд хүрч, дагаж мөрдөх хэрэгсэл болдог. Тэгэхээр нэр томьёо нь **үг буюу нийлмэл үгээр илэрхийлэгддэг, тодорхой ойлголтыг агуулдаг.**

Ойлголт - үзэгдэл юмсын үндсэн гол шинж чанар, холбоо харилцааг илэрхийлэн гаргаж буй сэтгэлгээний хэлбэр. **Онцлог буюу нийтлэг шинжээр нь нийт зүйлсээс ялган гаргаж, нэгтгэн базсан ой ухаан дахь дүрслэл, тогтооц юм.** Өөрөөр хэлбэл бусдаас нь ялгах буюу адилтгаж буй бидний сэтгэлгээний нэг хэсэг юм. Тиймээс ойлголт нь субъектив шинжтэй байдаг. Ойлголтоос нэр томьёо төрдөг. Харин нэр томьёо нь объектив болон субъектив бодит ертөнцтэй холбоотой, ойлголтын цэгцэрсэн мэдлэг юм. Субъектив байтугай объектив зүйлсийн тухай ойлголт зөрүүтэй байх нь олонтаа. Ж.нь. Дорж гэж хэн бэ? Доржийн тухай ойлголт хүн хүнд янз бүр. Олон жил хамтран ажилласан хүн нэг янзын ойлголттой, танилцаад удаагүй байгаа нөгөө хүнд өөр нэг ойлголт төрдөг. Тэгэхээр ойлголт бүрэлдэн тогтнох үйл явцаас хамаарч үндсэн гол шинж чанар, холбоо харилцааг үнэн бодитой илэрхийлэхэд нэгд, ул суурьтай судалгаа хэрэгтэй. Хоёрт, ойлголтод тохирсон шинжлэх ухаанч нэр томьёо хэрэгтэй. Ойлголтыг цэгцлэхэд эрдэм шинжилгээний хурал, семинар, хэлэлцүүлэг их чухал. Жишээ нь: 100 000 төгрөг гэсэн "мөнгөний тоо"-ны тухай ойлголтыг авч үзье. Ядуу хүнд энэ "мөнгөний тоо" маш "их", баян хүнд "бага" мэт санагдана. Ойлголтын зөрүү эндээс эхэлдэг. Нийгмийн бүлэг тус бүрийн ойлголт өөр өөр байдгийг би энэ жишээгээр хэлэх гээд байгаа юм. Ойлголт муутай асуудлаар улс төрчид, багш сурган хүмүүжүүлэгчид олон нийтэд мэдээлэл хийж нэр төрөө алдах нь бий. Өөрөөр хэлбэл, мэддэг, ярих эрхтэй асуудлаараа яриагүйн гайг хэлэх гэсэн юм. Нэр томьёо

бол хураангуйлсан мэдлэгийн цогц юм.

Тиймээс **байлдааны дүрэм², тактикийн бэлтгэлийн хөтөч ном, сурах бичиг³, гарын авлага⁴** хэрэглэдэг болоод байгаа "цагийн байдлыг тогтоох" гэсэн нэр томьёоны учир холбогдлыг энэ өгүүлээр илэрхийлэх гэсэн юм. Энэ нэр томьёог хэрэглэдэг болоод багагүй хугацаа өнгөрч байна. Урьд өмнө хэрэглэж байсан "цагийн байдлыг үнэлэх" гэсэн нэр томьёоны оронд түүнийг ашиглаж байна. Яагаад энэ томьёог өөрчлөх болсон талаар бичиж тайлбарласан, учир холбогдлыг илэрхийлсэн эрдэм шинжилгээний чанартай нэг ч өгүүлэл нийтлэгдээгүй, нэг ч илтгэлд дурдагдаагүй байх юм. Энэ "шинэ нэр томьёо"-г цаашид ашигласаар байх төлөв байдал ажиглагдаж байна.

"Цагийн байдлыг тогтоох" гэсэн нэр томьёог цаашид хэрэглэх, хэрэглэхгүй байхыг тайлбарлах шаардлага, хэрэгцээ бий болоод удаж байгааг харгалзан энэ өгүүлийг бичихэд хүрлээ. "Цагийн байдлыг тогтоох" гэсэн энэ нэр томьёог тайлж, агуулгын тайлбар хийхийн өмнө уг нэр томьёог бүрдүүлж буй үгийн утга санааг тайлж ойлгох нь логикийн хувьд зөв байх. "Цаг", "байдал", "тогтоох" гэсэн гурван үг тус бүрийг "юмс, үзэгдэл, тэдгээрийн шинж чанар, тоо хэмжээ, орон цаг, үйл хөдлөл зэргийг заан илтгэдэг"⁵ нэрлэлт болох талаас нь авч үзье.

"Цаг"⁶-1. үргэлжид хөгжих материйн орших ахуйн бодит хэлбэр; 2. Хугацаа, үе; 3. Зурхай (нарны зурхайн ёсны нэг өдөр, шөнийг хорин дөрөв хуваасны нэг хувь); 4. Хугацааны хэмжүүр; 5. Цаг хэмжигч багаж; 6. Үйлийн хэзээ болсон, болж байгаа, болохыг илтгэх хэл зүйн ай (цаг заах үйл үг); Эдгээрээс: хугацаа, үе, сүүлчийн буюу үйлийн болсон, болж байгаа, болох гэж буй гэсэн хоёр утга агуулга нь бидний авч үзэж буй нэр томьёоны утга, агуулгад нийцэж байна.

"Байдал"⁷-1. Байгаль, нийгэм,

² Байлдааны дүрэм. БД-1/100. УБ., 2016 он. 7.1, 7.1.3 заалт; Байлдааны дүрэм. БД-2/100. УБ., 2016 он. 5.2, 5.2.3 заалт;

³ Б.Шагдар. Тактик-1. УБ., 2011.-160х; т.13,14, ...; Б.Шагдар. Тактик-2. УБ., 2013.-214х; т.71,72, ... ; Г.Бүлтэн. Ерөнхий тактик. УБ., 2011 он. Т.33,106, ...;

⁴ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. А-Г; т. XXI;

⁵ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Т-Х; т. XXI;

⁶ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Х-Я; т.2871;

⁷ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. А-Г; т.211;



сэтгэхүйн юмс үзэгдлийн дүр төлөв, гадаад, дотоод төлөв, төрх, шинж төлөв, хэрэг явдлын ерөнхий төлөв; Үүнээс юмс үзэгдлийн ерөнхий төлөв, гадаад, дотоод шинж төлөв гэсэн утга агуулга нь бидний авч үзэж буй нэр томьёоны утга, агуулгад нийцэж байна.

"Тогтоох"⁸-1. юмны урсах, давших зэрэг хөдөлгөөнийг зогсоох, саатуулах; 2. Юмыг бэхэлж хөдөлгөөнгүй болгох; 3. Хууль, дэг журам тогтоох; 4. Шинэ зүйлийг үүсгэн байгуулах, бий болгох (засаг төрийг тогтоох, харилцаа тогтоох, үүсгэх; хэлхээ холбоо тогтоох); 6. Учир зүйг судлан тодорхойлох (хад чулууг судалж, эрт галавын нас сүүдрийг тогтоох, цээжилж тогтоох, язгуурыг тогтоох, нүдлэн тогтоох); 7. Идсэн ууснаа шингээх, тогтоох; 8. Мал амьтны хүч тарга, хүчийг тогтоох; эдгээрээс зогсоох, саатуулах, хөдөлгөөнгүй тогтвортой, цээжилж тогтоох, нүдлэн тогтоох, хууль, дэг журам тогтоохын аль ч "цагийн байдал" нэр томьёонд нийцүүлэн ашиглах боломжгүй байна. Тодруулж хэлбэл, байлдааны цагийн байдлыг - зогсоох, саатуулах, байлдааны цагийн байдлыг хөдөлгөөнгүй тогтвортой болгох, байлдааны цагийн байдлыг цээжилж тогтоох, нүдлэн тогтоох, байлдааны цагийн байдлыг хууль, дэг журмаар тогтоох болчихож байгаа юм. Энэ "тогтоох" гэсэн үгийн утга агуулга нь бидний авч үзэж буй нэр томьёоны утга, агуулгад нийцэхгүй байна. Тэгэхээр "байлдааны цагийн байдлыг тогтоох" гэсэн нэр томьёо байх нь утгагүй, хэрэглэж болохгүй болж байгаа юм.

"Цагийн байдлыг үнэлэх" гэсэн нэр томьёоны "цаг", "байдал" гэсэн үгс өмнө эш татаж утга санааг заасан учир зөвхөн "үнэлэх" гэсэн үгийн утга агуулгыг харья. "Үнэлэх"⁹ – 1. Юмны үнэ ханшийг тогтоох; 2. Үйл ажиллагааны амжилт, чанар, нөхцөлийг тогтоож үнэлэх гэсэн утга агуулгатай байна. Энэ "үнэлэх" гэсэн үгийг "цагийн байдал" гэсэн ойлголттой хамтад нь нэр томьёо болгон ашиглах боломжтой байна. Тодруулж хэлбэл "цагийн байдлыг үнэлж" болно. Ойлголтоос нэр томьёо төрдөг юм бол

"цагийн байдлыг тогтоох" ойлголтоос энэ нэр томьёо үүсэх боломжгүй байхад, "цагийн байдлыг үнэлэх" ойлголтоос нэр томьёо үүсэх боломжтой байна.

"Цагийн байдлыг тогтоох" гэсэн хэрэглэж, ашиглаж болохгүй нэр томьёогоор "цагийн байдлыг үнэлэх" гэсэн болж буй нэр томьёог солих болсны учир шалтгаан ойлгомжгүй байна.

Бид гадаад хэлнээс энэ нэр томьёог буруу орчуулж ашигласан байж болох талтай гэж бодоод орос, англи хэл дээр цэргийн нэр томьёоны утга агуулгаар хэрэглэж буйг нягталж үзье.

"Цагийн байдлыг үнэлэх" гэсэн нэр томьёог орос, англи хэл дээр хэрхэн орчуулж буйг харья. Оросоор: оценка обстановки; оценка боевой обстановки; англиар: Assessment of the situation, battle assessment, assessment of the situation of the operation and the battle гэжээ. Мөн "тогтоох" гэсэн үгийг – оросоор: установить; стабилизировать; англиар: to stabilize; to establish; to set up; to decide, resolve; to learn by heart, memorize гэсэн байна.

Одоо тэгвэл "байлдааны цагийн байдлыг үнэлэх" (оценить боевой обстановки - assessment of the situation of the battle) асуудлыг авч үзье.

Байлдааны цагийн байдал: байлдаан болсон, байлдаан болж байгаа, байлдаан болох нөхцөл байдал нь чанар, сорил, эрсдэл, амжилтад үзүүлэх байдлыг үнэлнэ гэсэн агуулгатай байна. Дээрх нэр томьёог ОХУ болон АНУ-ын цэргийн дүрэм, зааварт болон онолд хэрхэн хэрэглэж буйг харьцуулж харья.

ОХУ-ын "ХЗЦ-ийн байлдааны дүрэм-III"¹⁰-д: "тактикийн ажиллагааг зохион байгуулах гэдэгт: ахлах даргын бодлогыг тайлбарлах, салаанд гүйцэтгэх үүргийнх талаар бэлтгэлийг хангах байлдааны үүрэг өгөх; **цагийн байдлыг үнэлэх**; шийдвэр гаргах, түүнийгээ газрын зураг дээр зурах; харилцан ажиллагаа, удирдлага, хангалтыг зохион байгуулах" (организация тактических действий включает: уяснение задачи и отдачу указаний подготовки взвода

⁸ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Т-Х; т.1978;

⁹ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Т-Х; т.2319;

¹⁰ Боевой устав Сухопутных войск. Часть III. 002 заалт;



к ее выполнению; оценка обстановки; принятие решения и оформление его на карте; проведение рекогносцировки; отдачу боевого приказа; организацию взаимодействия, управления и обеспечение действий) гээд "цагийн байдлыг үнэлэх нь: дайснаа үнэлэх, өөрийн салбарыг болон зэргэлдээх салбарыг үнэлэх, газар орны байдлыг үнэлэх, жилийн улирал, хоногийн болон цаг агаарын байдлыг үнэлэх, тэдгээр нь салбарын байлдаанд бэлтгэх, түүнийг явуулах тактикийн ажиллагаанд хэрхэн нөлөөлөхийг үнэлэхээс бүрдэнэ" (Оценка обстановки включает: оценки противника, своего подразделения и соседей, местности, состояния погоды, время года, суток и их влияние на подготовку и ведение тактических действий) гэсэн байна.

Тэгвэл Америкийн цэргийн операцын хээрийн гарын авлага FM 3-0-д болон нэгдсэн операцын гарын авлага JP 3-0 зэрэг баримт бичигт: Judgment of the motives, qualifications, and characteristics of present or prospective employees or "agents"¹¹ (JP 3-0); "The operations process consists of the major command and control activities performed during operations: planning, preparing, executing, and continuously assessing the operation"¹². (операцын ажиллагаа удирдлага, хяналт дор явагдах ба энэ нь: операцын ажиллагааны төлөвлөлтийн, бэлтгэлийн, операцын ажиллагааны гүйцэтгэлийн, түүнд хийх байнгын үнэлгээний гэсэн үндсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ), "Assessment is the continuous monitoring and evaluation of the current situation, particularly the enemy, and progress of an operation"¹³. (үнэлгээ нь: байлдааны үйл явц нэг бүрд хяналт үнэлгээ өгөх, ялангуяа дайсны тухай, операцын явцын талаар байнгын үнэлгээ өгөх үйл явц юм), "Assessment precedes and guides every operations process activity and concludes each operation or phase of

an operation"¹⁴. (үнэлгээ нь операцын ажиллагаа нэг бүрийн урьтач болох бөгөөд операцын ажиллагаа нэг бүрийг чиглүүлэгч, операц болон операцын шат нэг бүрийн төгсгөлд хийгддэг үйл явц), "commander's estimate — In the context of the Joint Operation Planning and Execution System level 1 planning detail for contingency planning, a developed course of action"¹⁵. (командлагчийн үнэлгээ – операцын нэгдсэн төлөвлөлтийн агуулга болон нэгдүгээр эрэмбийн ажиллагааны төлөвлөлтийн гүйцэтгэл ба онцгой нөхцөлийн дэлгэрэнгүй төлөвлөгөө нэг бүрт чиглэдэг) гэсэн байна.

Тэгвэл "цагийн байдал" гэсэн нэр томъёог цэргийн шинжлэх ухааны үүднээс тайлбарлавал: "цагийн байдал – цэргийн байлдааны ба өдөр тутмын үйл ажиллагаа явагдах нөхцөл, хүчин зүйлийн нэгдэл. Операц, байлдааны явцад бий болсон нөхцөлийг байлдааны цагийн байдал гэнэ. Тэр нь цар хүрээний хувьд стратегийн, операцын, тактикийн гэж байна. ... Цэргийг үр ашигтай удирдахын тулд захирагч, штаб нь цагийн байдлыг тасралтгүй судалж, задлан шинжилнэ. Түүний үр дүнд хийсэн дүгнэлт нь командлагч (захирагч)-ийн операц (байлдаан) явуулах шийдвэрийн үндэс байна"¹⁶. /Б.Ш./

Дүгнэлт: "цагийн байдлыг тогтоох" гэсэн нэр томъёог "цагийн байдлыг үнэлэх" гэсэн нэр томъёоны оронд ашиглах нь зохимжгүй байна. Байлдааны дүрэм, заавар, сурах бичиг, гарын авлага дахь энэхүү буруу нэр томъёог даруй засаж залруулах шаардлагатай бөгөөд буруу ойлголт төрүүлэх "цагийн байдлыг тогтоох" гэсэн нэр томъёог сургалт судалгаанд ашиглахыг хориглох хэрэгтэй болжээ. Энэ мэт буруу нэр томъёо байлдааны шинэ дүрмүүдэд цөөнгүй байгааг засаж залруулах ажлын хэсэг гаргаж зөв хэрэглээг нэвтрүүлэхийг судлаачийн хувьд зөвлөж байна.

¹¹ JP 3-0. Joint Operations. 22 October 2018;

¹² OPERATIONS. FM 3-0. 27 February 2008, т. 5-15;

¹³ OPERATIONS. FM 3-0. 5-84 заалт;

¹⁴ OPERATIONS. FM 3-0.5-85 заалт;

¹⁵ JOINT PLANNING JP 5-0; 16 June 2017;

¹⁶ Цэргийн нэр томъёоны тайлбар толь. т.335;

**Ашигласан материал:**

1. Байлдааны дүрэм. БД100/1-. УБ., 2016 он. – 126х;
2. Байлдааны дүрэм. БД100/2-. УБ., 2016 он. – 120х;
3. Бүлтэн Г. Ерөнхий тактик. УБ., 2011 он. 278-х; ISBN 4-9-804-99929-978;
4. Дашдаваа Д., Равдан Э.. Нэр томъёоны тухай. УБ., 1980.
5. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Т-Х;
6. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Х-Я;
7. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. А-Г;
8. Шагдар Б. Тактик1-. УБ., 160-.2011х;
9. Шагдар Б. Тактик2-. УБ., 214-.2013х;
10. Цэргийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2014он. 702-х;
11. Боевой устав сухопутных войск, часть III. 022 заалт;
12. JP 0-3. Joint Operations. 22 October 2018;
13. OPERATIONS. FM 27 .0-3 February 2008,т. 15-5;
14. JOINT PLANNING JP 16 ;0-5 June 2017;



ТУЛГАРАХ БАЙЛДААН, ТҮҮНИЙ ОНЦЛОГТ ХИЙСЭН СУДАЛГАА

Ц.ГАНДОРЖ /БХЭШХ-ийн Цэргийн урлаг, судлалын төвийн дарга, доктор, хурандаа/

Түлхүүр үг: Тулгарах, тулгаралт, тулгарах байлдаан, тулгарах байлдааны зохион байгуулалт, тулгарах байлдааныг явуулах;

Key words: Meet (encounter), meeting, meeting engagement (encounter battle), organization of the meeting engagement, conduct a meeting engagement.

Тулгарах гэдэг үгийн утгыг Монгол хэлний их тайлбар тольд гэнэт таарах, мөргөлдөх, тулах, тулж очих, тулгардах гэж авч үзсэн байдаг бөгөөд үүнийгээ "Оройн жавар сөрөн цаст хөндийг туулж хэсэг ойн зах руу ортол гэнэт дайсны их хүчтэй тулгарав" гэсэн жишээгээр тайлбарлажээ¹.

Энэхүү тайлбараас тулгаралт нь гэнэт санаандгүй, урьдаас огт бэлтгээгүй үед тохиолддог үйл явц гэж ойлгож болох юм. Харин дайн, байлдааны үед үүсэх тулгаралтыг дэлхийн II дайны үеийн туршлага, сургамж болон онол, практикийн талаас нь ОХУ-ын хуягт танкийн цэргийн маршал П.А. Ротмистров, "Военная мысль" сэтгүүлийн судлаач С.Н.Козлов нар жанжин штабын академи дээр судлан "тодорхойлолт" өгч байсан бөгөөд ерөнхийдөө ижил төстэй боловч зарим нь зөвхөн марш, аяны журмын үед үүснэ гэж үзэж байхад, нөгөө хэсэг нь зөвхөн дайн, байлдааны ажиллагааны үед үүснэ гэж үзжээ². Тулгарах байлдааны үндсэн зарчим нь хоёр тал хоёул эсрэг чиглэлээс давшилт хийх явдал гэж бүгд үзсэн бөгөөд энэ ч зөв гэдгийг өмнөх болон өнөөгийн бүх нөхцөл байдал батлаад байна. Байлдааны дүрэм, заавар, цэргийн нэр томьёоны тайлбар тольд тулгарах байлдааныг хэрхэн тодорхойлсныг авч үзье.

Тулгарах байлдаан нь давших байлдааны нэг төрөл бөгөөд сөргөлдөгч талуудын аль аль нь тавигдсан үүргийг давшилтаар шийдвэрлэхэд үүсч болно гэжээ³. Цэргийн нэр томьёоны тайлбар тольд "Давших байлдааны нэг хэлбэр.

Байлдаж буй талууд ногдсон үүргээ давшилтаар шийдвэрлэж, дайсныг богино хугацаанд бут цохих, санаачилгыг авахаар эрмэлзэж буй үед үүсдэг байлдаан. Тулгарах байлдаан маршийн үед үүсэх ба хориглох байлдаанд сөрөг давшилт, сөрөг цохилт хийх үед, цэргийн анги, салбарууд шинэ зааг эзлэхээр хөдөлгөөн үйлдэж буй болон нэгдүгээр цуврааны цэргийг солих үед, агаарын десант буусан, буух үед үүсдэг" гэж тодорхойлсон байна⁴.

Тулгарах байлдааны зорилго нь давшиж байгаа эсвэл тэргүүн эгнээнд байгаа дайсныг богино хугацаанд бут цохиж, санаачлагыг гартаа авч цаашид байлдааныг амжилттай явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг байна. Үүний тулд дайсны сөрөг давшилтыг няцаах эсвэл хориглох байлдааны үед резерв хүчин фронтын шугамыг саармагжуулах болон дайсны давшилтад хөнөөл учруулах зэрэг шийдвэртэй үйл ажиллагааны тусламжтайгаар стратегийн зорилгод хүрэх явдал гэж байлдааны дүрмүүдэд заасан байдаг. Харин АНУ-ын тактикийн хээрийн гарын авлага (FM 3-90)-д тулгарах байлдааныг цаг, хугацаа болон орон зайны хувьд дайсанд гэнэтийн цохилтыг явдлаас хийх байлдааны ажиллагаа гэж үзэж байгаа бөгөөд ихэвчлэн тактикийн нэгж болох бригад, түүнээс доош нэгжээр явагдана гэж үзжээ.

Дайсан хөдөлгөөнт эсвэл байран байж болох бөгөөд ихэнх тохиолдолд тагнуулын мэдээ харьцангуй дутмаг үед үүсэх магадлал өндөр байдаг. Гэхдээ аль болох дайсанд гэнэтийн цохилт өгснөөр

¹ Ч.Алагсай. Алтайн зам;

² Lt Gen of the Reserves L.Skvirskiy "The Meeting Engagement in the Initial Period of a War", Aug 1961, Pg2-3;

³ Группа, авторов "Тактика" Глава пятая. Встречный бой, Воениздат, 1987; <http://militera.lib.ru/science/tactic/index.html>

⁴ БХЭШХ. "Цэргийн нэр томьёоны тайлбар толь", Улаанбаатар хот 2015 он, т-276;



давуу талыг олж авах, эс бөгөөс хоёр тал хоёул давшилтаар газар орны ашигтай заагийг эзлэн авах зорилгыг агуулж тактикийн давуу талыг олж авах, аль нэг тал нь түргэн, яаруу хориглолтод шилжих үед бат бэх хориглолтыг бий болгохгүйн тулд тулгарах байлдаан үүсч болно.


Тулгарах байлдаан нь ямар масштаб дээр явагдахаасаа шалтгаалж хүч хэрэгсэл нь харилцан адилгүй явагдаж байсан бөгөөд жишээ нь 1904 онд Орос-Японы дайны үед Шах гол дээрх 9 сарын тулгаралтад хоёр талаас нийтдээ 380 мянга хүн, 1406 буу, 44 пулемёт оролцсон байдаг⁵. Харин дэлхийн I дайны маневрын байлдааны ажиллагааны үед томоохон хэмжээний тулгарах байлдаан явагдаж, түүнд их хэмжээний бие бүрэлдэхүүн оролцсон байдаг. Жишээ нь 1914 оны 8 дугаар сарын 13-нд явагдсан Томашев дахь тулгаралтад Оросын талаас 8, Австрийн талаас 12 дивиз оролцжээ.

Тулгарах байлдаан дэлхийн II дайны эхэн үед, дайны дунд болон төгсгөл

үеүдэд явагдаж байсан бөгөөд өнөө үед онол, практикийн өргөн ойлголтод хүрээд байгаа билээ. Тулгарах байлдааныг ихэнх тохиолдолд танк болон механикжсан анги, салбаруудаар явуулж байсан бөгөөд эдгээр нь өндөр хурд болон галын хүчтэй цохилттой хослуулан тэргүүн эгнээний дайсныг бут ниргэж байжээ.

Эх орны дайны үед Зөвлөлтийн арми 55 орчим тулгарах байлдаан явуулсны 32 буюу 58 хувь нь давших байлдааны үед, үүнээс 17 нь гүний операцыг хөгжүүлэх үед, 9 нь дайсны бүслэлтийг сэтлэх үед, 6 нь дайсны хориглолтыг сэтлэх үед үүсч, бусад нь хориглох байлдааны үед үүсч байжээ⁶.

Орчин үед тулгарах байлдаан нь дээрх нөхцөл байдлуудад үүсч болох хэдий ч цөмийн зэвсэг, артиллери, миномётын хүчин чадал, алсын тусгал, танк, хуягт тээвэрлэгчүүдийн хөдөлгөөнт, маневрлах байдал, цохилтын хүч зэрэг нь ихээхэн нэмэгдэж байгаагаас шалтгаалан давших байлдаан явуулах нөхцөл боломж бий



1 дүгээр зураг. Орос-Австрийн Томашев дахь тулгарах байлдаан, 1914 он

⁵ Советская Военная Энциклопедия. Т.2. –С.405;

⁶ Развитие тактики Сухопутных войск в Великой Отечественной войне М.: ВАФ, 1981.-С.257;



болсонтой холбон үзэж байна. Иймд орчин үед тулгарах байлдаан явагдах нөхцөл боломж ихээхэн өндөр юм. Тулгарах байлдаан маршийн үед, давших болон хориглох байлдааны үед үүсч болно.

Байлдааны ажиллагааны шугам, зурвас газартай ойр марш үйлдэж байх үед тулгарах байлдаан үүсч болох бөгөөд үүнд дан ганц нэгдүгээр цуврааны анги, салбараас гадна гүн дэх салбаруудын хүч сэлбэх, байлдааны ажиллагааг хөгжүүлэх үед үүсч болно. Маршийн үед аяны толгой, авангард, тэргүүний отряд болон артиллери, зенитийн салбаруудын гол хүч дэхь байрлалуудыг зөв тодорхойлох нь чухал байдаг.

Давшилтын үед тулгарах байлдаан нь дайсны сөрөг цохилт, сөрөг давшилт, давшилтыг хөгжүүлэх, чухал заагийг эзлэх, дайсныг мөрдөн хөөх болон дайсны гүн дэхь маневрын ажиллагааны үеүдэд үүсч болно. Давших анги, салбар нь байлдааны болон байлдааны өмнөх журманд хүчээ задалсан байх бөгөөд энэ нь тулгарах байлдааныг амжилттай явуулах үндэс нь болж өгдөг. Хэдийгээр дайсны резерв, нөөц хүч нь дүрэм мэт урьдаас бэлтгэгдсэн маршрут, төхөөрөмжлөгдсөн заагт байрлаж сайн судлагдсан чиглэл рүү цохилт хийх нь тодорхой юм. Иймд захирагч, даргад давших байлдаанд бэлтгэх явцдаа тулгарах байлдаанд орж болзошгүй заагуудад дайснаас өрсөж ашигтай заагийг эзлэх, дайсны хүчийг сарниулахад анхаарах нь ихээхэн чухал юм.

Хориглолтод тулгарах байлдаан нь сөрөг давшилт, сөрөг цохилт, агаар болон тэнгисийн десантын эсрэг ажиллагааны үед болон сэтэрсэн хэсэгт хаалт хийх, чухал газар орны хэсгийг тогтоон барьж байх үед үүсч болно.

Дээрх тулгарах байлдаан үүсч болох нөхцөл байдлуудын мөн чанар нь давшилтаар тавигдсан үүргийг амжилттай биелүүлэхэд чиглэгдэж байгаад оршиж байна. Иймд тулгарах байлдааны шинж чанарыг дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд:

1. Хязгаарлагдмал цаг, хугацаанд

зохион байгуулагддаг;

2. Хурдан хугацаанд явдлаас тулгаралтад ордогт;

3. Цаг хугацаа хожих хүчтэй тэмцэл явагддагт;

4. Санаачлагыг булаан авдагт;

5. Цагийн байдал гэнэт, байнга өөрчлөгддөгт;

6. Өргөн фронт, их гүнд явагддагт;

7. Маневр хийх боломжтой нээлттэй зааг, завсарт явагддагт байна⁷.

Тулгарах байлдааныг амжилттай явуулахын тулд орчин үеийн ерөнхий цэргийн байлдааны зарчмыг мөрдлөгө болгох явдал чухал үүнд галын хүч, өндөр маневр, хөдөлгөөнт байдал болон цохилтын хүчийг зөв ашиглахад оршиж байна. Үүний тулд дайсны талаарх тагнуулын мэдээг идэвхтэй явуулснаар амжилтад хүрэх хэрэв дайсны хүч, хэрэгсэл, зорилгыг ойлгоогүй бол аль ч талаасаа цохилтод өртөж болох бөгөөд санаачлагыг дайсанд алдсанаар ихээхэн хохирол амсахад хүргэнэ.

Иймд тулгарах байлдаанд амжилт олох нэг хүчин зүйл нь цаг тухайд нь зөв шийдвэр гаргах явдал бөгөөд байлдааны үүргийг салбарууддаа хүргэх зэрэг цаг хугацааны хүчин зүйл ихээхэн үүрэгтэй юм.

Тулгарах байлдааны зохион байгуулалт.

Тулгарах байлдааныг амжилттай зохион байгуулахын тулд хэдийгээр цаг, хугацаа хязгаарлагдмал ч түүний бэлтгэлийг сайтар хангах нь чухал юм. Тухайлбал маршийн үед байлдааны тушаал авсан үе нь дайсны гол хүчнээс аль хэр зайтай болон ойртолтын хурд зэргээс шалтгаална.

Тулгарах байлдааны зохион байгуулалт нь даргын шийдвэр, салбаруудын байлдааны тушаал, харилцан ажиллагааны зохион байгуулалт, галын хөнөөл, агаарын довтолгооноос хамгаалах, бүх талын хангалт, суртал ухуулга болон байлдааны үүргийг биелүүлэх бэлэн байдлын үзлэг, шалгалт зэрэг давших байлдааныг зохион байгуулах, түүнд шаардагддаг бүх элементүүдээс бүрддэг⁸.

Захирагч, штаб тулгарах байлдааныг

⁷ Тактика встречного боя. Стр 7. <https://docplayer.ru/42463136-Taktika-vstrechnogo-boya.html>;

⁸ Содержание "Военная Литература" Военная мысль. Глава пятая. Встречный бой <http://militera.lib.ru/science/tactic/06.html>

зохион байгуулах нь тулгаралт эхлэх болон үргэлжлэх цаг, хугацаа зэрэг хүчин зүйлсийн цар хүрээнээс ихээхэн хамааралтай бөгөөд цаг хугацаанд нь байлдааны үүргээ бүрэн дүүрэн гүйцэтгэх чадвартай байх нь чухал юм.

Жишээ нь дэлхийн II дайны үеүдэд тулгарах байлдааныг үндсэн хоёр үе шаттай явуулж ирсэн байдаг. Эхний үе шат нь марш, давших болон хориглох байлдаанд урьдаас бэлтгэх явдал бөгөөд дайсантай тулгарч болзошгүй заагуудыг урьдчилан тодорхойлсноор авах арга хэмжээг шийдвэрлэх, үүний дараа аяны журам, хүч хэрэгслээ хуваарьлан байлдааны болон ар талын хангалтыг зохион байгуулахын зэрэгцээгээр суртал, ухуулгыг хийж ирсэн байна. Хоёр дахь шатанд тулгаралтад тулсан үед богино хугацаанд амжилттай явуулах эрмэлзлэлийг агуулж ирсэн байна.

Захирагч, дарга байлдааны тушаалдаа марш, аяны журмын толгойн сэргийлэх, хамгаалалтад томилогдсон бие бүрэлдэхүүнд хөдөлгөөн үйлдэх маршрут, зааг болон тулгаралтад орох цаг, хугацаа, гол хүч ирэх хүртэл барьж байх болон атакад орох үеийн журмыг нарийн заадаг байна. Үүнээс гадна хүч нэмэгдүүлсэн болон хавсрагдсан артиллерийн анги, салбаруудад аяны толгойн хамгаалалтад томилогдсон салбар, гол хүчийг артиллерийн галаар дэмжих үүрэг, галт байрын байрлал, гал нээхэд бэлэн болох хугацаа, гал нээх дохио, сигнал, гал шилжүүлэх, гал зогсоох болон галын журмуудыг зааж өгдөг.

Мотобуудлагын салбар, ротод байлдааны тушаал, атакад шилжих зааг, чиглэл, цаг хугацаа болон харилцан ажиллагааны журмыг тодорхой зааж өгдөг байна. Харин нөөц хүчинд тулгарах байлдаанд орох журам, чиглэл, бусад салбар, нэгжид хаалт хийх, гол хүчний хөдөлгөөн үйлдэх, хүчээ задлах нөхцөлийг бүрдүүлэх, байлдааны журам дахь байр болон байлдааны явц дахь шилжилтийн журмыг зааж өгдөг байна.

Танк эсэргүүцэх салбарт тэдгээрийн галт байр, хүч задлах зааг, эзлэх цаг, танкийн салбарт баруун болон зүүн жигүүрийн салбартай харилцан

ажиллагаатайгаар дайсны тэргүүн эгнээний салбаруудыг устгахад чиглэгдэнэ.

Дэлхийн II дайны үеийн тулгарах байлдааныг явуулж байсан туршлагыг судлан үзэхэд дайсны гол хүчнээс мотобуудлагын дивиз 4 км зайд, танкийн болон механикжсэн корпуст 7-8 км, мотобуудлагын хороонд 1.5 км, танкийн болон механикжсэн бригадад 3-4 км зайтай байрлаж байсан байна⁹.

Байлдааны журмын хувьд дайсанд хүчтэй цохилт өгөх боломжтойгоор зохион байгуулж байсан бөгөөд 55 тулгарах байлдааны 29 хоёр цувраагаар, 26 нэгийн цувраагаар байрлаж байжээ¹⁰.

Цувраагаар байрлахад аль болох богино хугацаанд шилжилт, хөдөлгөөн хийх нь чухал бөгөөд хэрэв 2 цаг зарцуулбал 5-30 хувийн хохирол, 3 цаг зарцуулбал 8-44 хувийн хохирол буюу 1,5 дахин нэмэгдэж байсан сургамж байдаг байна.

Нэгдүгээр цувраа дахь батальонд хоёр эсвэл гурван мотобуудлагын рот, орон тооны болон хавсрагдсан танкийн ротыг хуваарьлах ба нэгдүгээр цувраа дахь ротыг танк, танк эсэргүүцэх болон гранатомётын салбаруудаар хүч нэмэгдүүлнэ. Давшилтаар тулгаралтад ороход батальонд 2-3 км, ротод 500-1000 м-ийн өргөн зурвас газрыг зааж өгнө.

Сүүлийн үеийн 1950-иад оноос хойш явагдсан орон нутгийн дайн, зэвсэгт мөргөлдөөнүүдэд том хэмжээний тулгарах байлдаан явагдаагүй бөгөөд үүнийг зэвсэгт тэмцэл өвөрмөц нөхцөл, байдалтай явагдах болсонтой холбон үзэж байна.

Тулгарах байлдааныг явуулах.

Тулгарах байлдаан нь маршийн үед, давших болон хориглох байлдааны үед үүсч болно гэж дээр тодорхой дурдсан билээ. Тулгарах байлдааныг хэрхэн явуулж болох талаар энэ бүлэгт авч үзье.

Дайн, байлдааны ажиллагааны шинж чанар, зэвсэгт тэмцлийн хэрэгслээс шалтгаалж тулгарах байлдаан нь цөмийн болон ердийн зэвсгийн хэрэгслээр явагдаж болно.

Цөмийн зэвсэг хэрэглэх тулгарах

⁹ Развитие тактики Сухопутных войск в Великой Отечественной войне. - М.:ВАФ,1981.-С.264;

¹⁰ Мөн тэнд –С.266;



байлдааны үед дүрэм мэт ахлах даргын хүч хэрэгслээр дайсны ойрын цуваа, замын уулзвар, ус гатлалт, хавцал зэрэг давчуу газар орныг туулах явцад хэрэглэснээр үр дүн нь цаашдын байлдааны ажиллагааг шийдвэрлэхэд нөлөөлнө. Дайсан ч мөн адил өөрийн цөмийн зэвсгийг түрүүлж хэрэглэхийг эрэлхийлнэ. Иймээс дайснаас өрсөж цаг тухайд нь, чиглэл, хөдөлгөөнийг сааруулах замаар хийх нь чухал байна. Харин ердийн зэвсэг хэрэглэх үед тагнуул-цохилтын комплекс, авиац, пуужин, байлдааны нисдэг тэрэг болон алсын тусгалтай артиллерийн хүч хэрэгслээр цохилт өгч гүн галын хөнөөлийг бий болгосноор тулгаралтад ордог байна.

Галын гүн хөнөөл нь орчин үеийн тулгарах байлдааныг явуулах нэг гол хэсэг бөгөөд урьдын тулгарах байлдаанаас ихээхэн ялгаатай болсноороо онцлог байна. Галын гүн хөнөөлийг давшиж буй дайсны бүлэглэлүүд рүү явуулах явцтай зэрэгцэн өөрийн цэргийн хүчийг задлах нь чухал юм. Дайны жилүүдэд дайсны гүн рүү хүчтэй галын цохилт, хөнөөлийг зөвхөн авиацаар явуулж байсан бөгөөд тулгарах байлдааныг явуулах нөхцөлийг зарим тохиолдолд бүрэн хангаж чаддаггүй байсан байжээ.

Орчин үеийн зэвсэгт тэмцлийн хэрэгслүүд нь дайсанд цөмийн болон ердийн зэвсгийн гэнэтийн шийдвэрлэх цохилтыг өгч анги, нэгтгэлүүдийг тулгаралтад оруулах нөхцөлийг бүрдүүлэн өгч байна.

Галын гүн хөнөөлийг амжилттай явуулах, хүч задлах, атаканд шилжих зэрэгт агаарын болон газрын тагнуул, тэргүүний отряд болон аяны хамгаалалтын үйл ажиллагаагаар хангагдах нөхцөл бүрдэнэ.

Ойрын зайн галын цохилтын хэрэгслүүд болох байлдааны машин, танкуудын үүрэг, ач холбогдол улам нэмэгдсэн байна. Иймээс тэдгээрийн баг, экипажуудын чиг шагайлтын анхны буудлагыг амжилттай явуулах чадвартай байх шаардлага тавигдаж байна.

Тагнуулын салбарууд нь дайсны тагнуул, хамгаалалтыг тойрон гарч нууцаар нэвтэрснээр бүрэлдэхүүн, бүлэглэл, хөдөлгөөний чиглэл, гол чухал заагуудыг нэвтрэх цаг хугацаа, завсар,

үүзүүр, хүч задлах хугацаа, артиллерийн галт байр болон удирдлагын байрын байршил зэргээс гадна цөм, химийн зэвсэг, тагнуул-цохилтын комплексуудын байршлыг тодорхойлох үүрэг чухлаар тавигддаг байна. Тагнуулын салбар нь шаардлага тулгарсан үед дайсны тэргүүний тусгай салбар руу атаклах, баривчлах, хөдөлгөөнд саад учруулж түйвээх ажиллагааг явуулж болно. Олзворлосон мэдээ, мэдээллийг нэн даруй ахлах даргад хүргэнэ.

Тулгарах байлдаан нь өөрийн цэргийн авангард, тэргүүний отряд, аяны толгойн хамгаалалт болон дайсны тэргүүний салбаруудын хооронд гол төлөв явагдана.

Тэргүүний отряд нь заагдсан заагийг дайснаас өрсөж эзлэхийн тулд дээд хурдаар хөдөлгөөнийг үйлдэх бөгөөд дайсанд эзэлсэн заагийг алдахгүйгээр гол хүч иртэл барьж байх үүрэгтэй. Үүний тулд хөдөлгөөн үйлдэж байх явцдаа дайсны жижиг салбаруудыг өөрийн галын хэрэгслээр устгах бөгөөд ингэхдээ байлдааны машин, хуягт тээвэрлэгчээс бие бүрэлдэхүүнийг явгалахгүйгээр үйлдэнэ.

Хэрэв ашигтай заагийг эзлэх явцад тактикийн агаарын десантыг буулгах тохиолдолд тэргүүний отрядын захирагч аль болох хурдан буух бүх талын арга хэмжээг харилцан ажиллагаатайгаар зохион байгуулж хэрэгжүүлнэ.

Тэргүүний отряд дивизийн гол хүчнээс 50 км хүртэл зайд, тагнуулын салбар нь 50-130 км-ийн зайтай буюу дайснаас мөн тийм зайд байна гэж үзэж хоёр талын хөдөлгөөний хурд 40 км/цаг гэж тооцвол гол хүчнүүдийн тулгаралтад орох хугацаа 2,5-3 цаг ноогдож байна. Иймээс хөдөлгөөнийг үйлдэж байх явцдаа цагийн байдлыг ямагт тодотгож, үнэлгээ, дүгнэлтээ захирагчийн шийдвэрт оруулснаар тулгарах байлдааныг цааш хөгжүүлэх, дайснаас өрсөж санаачлагыг гартаа авахад ихээхэн үүрэгтэй байна¹¹.

Орчин үеийн байлдааны зэвсэглэл, техник, галын болон цохилтын хүч, анги, салбаруудын хөдөлгөөнт чанар, маневр нь тулгарах байлдааны агуулга, шинж чанарт зарчмын өөрчлөлтийг бий болгоод байна. Үүнд: сөргөлдөгч талуудын галын

¹¹ Түмэн. Б. "Байлдааны нөхцөлд ерөнхий цэргийн штабын алба". Улаанбаатар 2003. Т-226;



хүчний нөлөө, тэдгээрийн гүн, динамик, маневрлаг байдал болон шуурхай, хүчтэй, бат найдвартай гэнэтийн цохилт өгдөг болсноороо онцлог байна.

Байлдааны зэвсэглэл нь богино хугацаанд байлдааны журам дахь бүхэл бүтэн элементүүдийг жагсаалаас гаргах, байлдаанд орох боломжийг хязгаарладаг болоод байна. Тиймээс байлдааны чадавх болон удирдлагын системийг

дээшлүүлэх, дайснаас өрсөж цохилт өгөх зэрэг асуудлууд чухлаар тавигдаж байна. Өөрөөр хэлбэл, тулгарах байлдаанд анги, салбарыг шуурхай дэлгэн байрлуулж, дайснаас өрсөж бут цохих асуудал юм.

Дээрх бүгдээс захирагч, штабт орчин үеийн тулгарах байлдааны шинж чанар, түүнийг амжилттай явуулах бүтээлч арга замыг гүнзгий ухамсарлахыг шаардах болоод байна.

Ашигласан материал:

1. Алагсай.Ч. Алтайн зам;
2. БХЭШХ. "Цэргийн нэр томъёоны тайлбар толь", Улаанбаатар хот 2015 он, т276-;
3. Группа, авторов "Тактика" Глава пятая. Встречный бой, Воениздат, 1987; <http://militera.lib.ru/science/tactic/index.html>
4. Развитие тактики Сухопутных войск в Великой Отечественной войне М.: ВАФ, 1981;
5. Советская Военная Энциклопедия. Т.2;
6. Тактика встречного боя. Стр 7. <https://docplayer.ru/-42463136Taktika-vstrechnogo-boya.html>;
7. Содержание "Военная Литература" Военная мысль. Глава пятая. Встречный бой <http://militera.lib.ru/science/tactic/06.html>;
8. Lt Gen of the Reserves L.Skvirskiy "The Meeting Engagement in the Initial Period of a War", Aug 1961;



ТЕРРОРИЗМ ҮҮСЭЖ БУЙ УЧИР ШАЛТГААНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

С.ПҮРЭВДОРЖ /БХЭШХ-ийн Цэргийн урлаг судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, Доктор (Ph.D), дэд профессор, хурандаа/

Түлхүүр үг: Терроризм, террорист халдлага, терроризмтой тэмцэх арга, терроризмын аюулын эрсдэл, терроризм үүсэх шалтгаан, гадаад террорист дайчид

Key words: Terrorism, terrorist attack, anti-terrorist approach, terrorism threat risk, reasons of terrorism, foreign terrorist warriors

Хураангуй: Дэлхий дахинаа “Исламын улс” (ИУ) барууны орнууд болон Ойрх Дорнодын тусгай албадын хоорондын тэмцэл хамгийн харгис шинж чанартай террорист халдлагад тооцогдож байна. “Исламын улс” террорист бүлэглэлийн тусгай албадын зохион байгуулалтын талаар анх удаа францын MediaPart (Revelations sur les services secrets de l’Etat islamique)-ын сэтгүүлчид судлан 20 гаруй шүүхийн хавтаст хэрэг, мөрдөгчдийн ажлын тайлан, тусгай албадын нууц болон ил материалууд, олон зуун утасны хяналтын мэдээнд дүн шинжилгээ хийснээс гадна тусгай ажилтан, шүүгч, өмгөөлөгч, шинжээч, барьцаалагдсан жихадуудтай уулзан ярилцлага авч ИУ-ын тусгай албадын дүр төрхийг тодорхойлж гаргахыг зорьж байна.

Терроризм ямар нөхцөл байдлын улмаас, ямар хүчин зүйлийн нөлөөлөл дор өсөн нэмэгдэж, бууран сулрах учир шалтгааныг тогтоох нь чухал юм. Үүний тулд терроризм үүсэх нөхцөл байдлыг олон талаас нь харж шинжлэн судалж үзэхээс өөр арга замгүй юм. Иймд терроризм үүсэхэд нөлөөлж буй нөхцөл байдал, хүчин зүйлсийг дурдаж, эерэг ба сөрөг нөлөөллийн зарим үр дагаврыг судлан үзлээ.

Үндсэн асуудал: Терроризм гэсэн үгийнх нь үндсийг судлаад үзэхэд аюул, аймшиг, заналхийлэл гэсэн утгатай болж байгаа юм. Тэгэхээр эцсийн эцэст аливаа улс орны үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд аюул занал учруулахад чиглэгдсэн улс төрийн зорилготой бүхий л төрлийн үйл ажиллагааг терроризм, уг үйл ажиллагааг гардан хийж буй этгээдүүдийг террорист гэж ойлгож болох үндэслэлтэй

юм. Манайхан гадаадын тухайлбал, америкийн киноноос, эсвэл мэдээллийн хэрэгслүүдээс террорист үйл ажиллагааны талаар олон мэдээ, мэдээлэл авдаг. Ихэнх тохиолдолд бөмбөг дэлбэлэх, хүнийг болон онгоцыг барьцаалан биелэгдэшгүй болзол тавих хэлбэрээр ойлгож ирсэн. Цаашдаа ч ийм байдлаар ойлгосоор л байх төлөвтэй байна.

Өнөөдөр дэлхийн улс орон, хүмүүс яг л 1960-1980-аад оны үе шиг хоёр хуваагдчихаад байна. Нэгдэх нь Америкийн нэгдсэн улсыг дэмжигчид буюу НАТО-ийн гишүүн улс орнууд, харин нөгөө хэсэг нь Америкийн нэгдсэн улсыг үл дэмжигч улс орнууд. Тухайлбал Америк тивд л гэхэд Мексик буюу түүнээс урагш байрлах Латин америкийн бүхий л улс орнууд “эвсэл” байгуулчихсан АНУ-ын улс төрийн бодлогыг эсэргүүцэж байх жишээтэй. Эсвэл европ тив нь бас л хуваагдчихсан Герман, Орос, зэрэг улсууд хоорондоо сүрхий найзууд болчихсон тэр хавиараа хамтарсан байдалтай хор найруулаад л... Азийн хувьд л гэхэд Орос, Хятад зэрэг их гүрнүүд далдуур цэргийн зэр зэвсэг майлцаад л... Арабын ертөнц бол бүгдээрээ, тэр чигээрээ америкийн эсрэг үйл ажиллагаанд идэвхийлэн оролцогч, терроризмын ганц бэлэг тэмдэг нь болчихоод байх жишээтэй.

Дэлхий ертөнцийн иймэрхүү чиг хандлагатай байхад Монгол Улс Америк ба түүний холбоотон улсуудыг дагаж дэрвээд эртний насан туршийн хоёр хөршөө аль өнцөгөөс нь харж, ойлгож байгаа нь ойлгомжгүй байна. Сайтар судалж, олон талаас нь авч ярих юм бол манай улс терроризмын аюулд хамгийн амархан өртөж болзошгүй. Хил, гаалийн хяналт нь сул, хар тамхи хэрэглэгч, тээвэрлэгч

орон болж, хүн амынх нь дийлэнх хэсэг нь Улаанбаатар хотдоо төвлөрсөн, гадаадад улсаа төлөөлөгч дипломатууд контрбандын хэрэгтнүүд болчихсон байгаа нь үнэхээр харамсалтай.

Эртний түүхээс үзэхэд манай өвөг дээдэс лалын ертөнцийг жинхэнэ хүмүүн болгож байсан учраас арабууд монголчуудад тийм ч дуртай байдаггүй.

Монгол Улсын хувьд 2004 онд Улсын Их Хурлаас "Терроризмтой тэмцэх тухай" хуулийг батлан гаргаснаар терроризмын эсрэг үйл ажиллагаа явуулах үндэсний эрх зүйн орчин бүрдэж эхэлсэн байна. Уг хуульд зааснаар Монгол Улсын Засгийн газар нь терроризмоос сэргийлэх ажлыг хариуцан зохион байгуулах үндсэн субъект бөгөөд хууль хэрэгжүүлэх бодлогын үйл ажиллагааг Монгол Улсад терроризмтой тэмцэх ажиллагааг Зохицуулах зөвлөл гүйцэтгэж байгаа юм. Гэсэн хэдий ч тус хуульд 2012 онд зарим нэг нэмэлт оруулж, 2019 онд "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай" Монгол Улсын хуулийг батлан мөрдүүлж эхлээд байна.

Тус хуулийн 3 дугаар зүйлийн 1.8-д "терроризмын суурь нөхцөл бүрдэх, террорист үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хохирол, хор уршгийг арилгахаар авч хэрэгжүүлж байгаа улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны нэгдлийг терроризмтой тэмцэх"¹ ажиллагаа гэж тодорхойлсон.

Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх арга хэмжээний үндсэн чиглэлд Төрөөс зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгажээ². Үүнд:

1. Терроризмын нөхцөл байдал, түүний суурь нөхцөлийг үнэлэх;
2. Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;

3. Терроризмын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, терроризмоос ангид байх үзлийг төлөвшүүлэх;
4. Терроризм үл нутагших, террорист этгээд нэвтрэхгүй, орогнохгүй байх орчин нөхцөлийг бүрдүүлэх;
5. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бэлэн байдлыг хангах;
6. Хүн, хуулийн этгээд, улсын онц чухал объект, хүн ам олноор төвлөрсөн газрыг террорист үйлдлээс сэргийлэн хамгаалах;
7. Террорист үйлдэлд өртөх эрсдэлийг бууруулах, түүнээс үүсэх хохирол, хор уршгийг багасгахад чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
8. Зэвсэг, бодис, хэрэгсэл, юмсыг террорист үйлдэлд ашиглахаас сэргийлэх;
9. Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх чиглэлээр олон улсын болон гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах;
10. Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхэд хүн, хуулийн этгээд, хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагын оролцоог нэмэгдүүлэхээр заасан болно.

Терроризмын нөхцөл байдлыг үнэлэхдээ бүс нутаг, улс оронд үйлдэгдсэн, үйлдэгдэж болзошгүй терроризм, түүний чиг хандлага, арга хэлбэр, аюул занал, эрсдэлд дүн шинжилгээ хийж, олон улсын байгууллагын зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх бодлого, үйл ажиллагааг харгалзан дүгнэлт гаргахаар хульчилсан билээ.

Терроризм үүсч буй болохоос сэргийлэх, түүнтэй тэмцэх ажиллагаанд төр засгаас эрх олгогдсон гүйцэтгэх засаглалын тагнах, сөрөн тагнах, шуурхай эрэн сурвалжлах, мөрдөх, цэргийн болон тусгай арга ажиллагаа багтдаг. Тэдний үйл ажиллагаа дараах асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэж байна:

- Террорист үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан

¹ "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай" Монгол Улсын хууль. 2019 он., 3.1.8 дахь заалт;

² "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай" Монгол Улсын хууль. 2019 он., 6.1 дэх заалт;



зогсооход;

- Террорист шинжтэй гэмт хэргийг илрүүлэх, мөрдөхөд.

Терроризмтой тэмцэхэд чиглэсэн зохион байгуулалтын үйл ажиллагаа нь нэлээд иж бүрэн шинжилгээ, хандлага шаарддаг бөгөөд тухайлбал, террорист ажиллагаа явуулж болзошгүй субъект, эх сурвалж нэг бүрээр шинжилгээ хийх, терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын байршил, ажил үүргийн чиглэл зэргээс хамаарч тэдэнд хариуцлагын бүсийг тогтоох, тавигдсан үүргийг шийдвэрлэхэд хамгийн чухал, гол зангилгаа асуудлыг нь оновчтой тодорхойлох, терроризмтой тэмцэх чиг үүрэг хүлэсэн шуурхай эрэн сурвалжлах, мөрдөх, шуурхай бүлгийн болон цэргийн байгууллагуудын харилцан ажиллагааг нэгдсэн штабаар дамжуулан удирдах, нөөцийн хуваарилалтыг хийх, автоматжуулсан удирдлагын тогтолцоо, программ хангамжийн ажиллагааг жигдрүүлэх г.м.-ийг дурдаж болно.

Монгол Улсад терроризмын гэмт үйлдэл гарахад нөлөөлж болзошгүй шалтгаан нөхцөлийг авч үзвэл: сүүлийн 10 жилд манай улсад терроризмын шинжтэй 19 удаагийн гэмт хэрэг бүртгэгджээ. Хүний эрүүл мэнд, амь насанд аюул занал учруулж болзошгүй дээрх хэргүүдийн ихэнхийг ТЕГ, ЦЕГ-ын ажилтнууд урьдчилан илрүүлж, таслан зогсоосон байдаг.

Олон улсын терроризмын эсрэг эвсэлд нэгдэж Иракийн сэргээн босголтын үйл явцад оролцуулахаар цэргээ илгээсэн Монгол Улсын хувьд энэ аюул хийсвэр мэт хэн нэгэнд санагдаж байсан бол харин эдүгээ бодитой заналхийлэл болж болзошгүй нөхцөл байдал үүсэн гэж үзэж болохоор байна.

Шашны үндсэрхэг үзэл, улс төрөөс үүдэлтэй сөрөг үзэгдлүүд, нийгмийн тогтворгүй байдал, зохион байгуулалттай гэмт хэрэг даамжрах нь терроризмын үйл ажиллагаа үүсэн бий болох таатай хөрсийг бүрдүүлдэг.

Тухайлбал: Ислам шашны олон улсын "Таблиги Жамагат" хөдөлгөөний үйл ажиллагааг ОХУ, Казахстан, Тажикистан зэрэг хэд хэдэн улсад хоригложээ. Тус хөдөлгөөний гишүүд Монгол Улс руу төлөөллөө илгээн, манай ислам шашинтай

иргэдийг өөрийн үзэл номлолд итгүүлж, хөдөлгөөнийхөө гишүүнээр элсүүлэх оролдлого хийх болсныг холбогдох албаныхан мэдээлэх боллоо. Монгол Улсад 2012-2013 онд тус хөдөлгөөний 30-аад төлөөлөгч ирсэн гэх албан бус мэдээлэл байгаа бөгөөд тэдгээрийн олонх нь Киргизстан, Казахстан улсын иргэд байсан.

Монгол Улсад террорист үйлдлийн зэвсэг, хэрэгсэл олж авах эрсдэлийг их буюу улаан түвшинд Монгол Улсын тагнуул, хууль сахиулах байгууллагын терроризмтой тэмцэх чадвар бага хэмжээнд чадвартай буюу улаан түвшинд байгаа гэж үзсэн.

ОХУ-ын иргэд манай улсад визгүй зорчихоос дараах аюулын эрсдэл нэмэгдэж байна. Үүнд:

- Гэмт хэрэгтнүүд хяналтгүй олноор орж ирэх, орж ирсэн хойно хяналтаас гарах магадлалтай;
- Оросын мафиуд, хар тамхичид, тэдгээрийг дамжуулагчид орж ирэх боломжтой;
- ОХУ одоогийн батлагдсан судалгаагаар, зургаан сая хар тамхи хэрэглэгчтэй байна.

Терроризмтой тэмцэх олон улсын 19 баримт бичиг байдгаас Монгол Улс 13 баримт бичигт нэгдсэн орсон бөгөөд бусад баримт бичигт нэгдэн орох чиглэлээр ажиллаж байна.

Терроризмтой хийж буй тэмцлийн хэлбэрийг үндсэнд нь хүч хэрэглэх болон хууль эрхзүйн хүрээний, гадаад болон дотоод гэж ангилан шинжлэн хувааж байна. Дэлхийн ихэнх орнууд сүүлийн 30 жилийн хугацаанд хүч хэрэглэх байдлаар терроризмтой тэмцэж байгаа боловч төдийлөн үр дүнд хүрэхгүй байна. Зөвхөн хууль эрх зүйн арга хэрэгслээр энэ асуудлыг шийднэ гэвэл ойрын ирээдүйд бүтэхгүй шинжтэй. Энэ хүрээнд хийсэн анхны оролдлого бол 1937 онд Үндэстнүүдийн Лигээс "Терроризмыг таслан зогсоох болон террорист ажиллагаанд шийтгэл ногдуулах" тухай Конвенци батлан гаргасан явдал юм.

Харин орчин үеийн түүхэнд буюу 1985 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас "Олон улсын терроризм"-ын тухай тогтоол гаргаж, терроризмын ажиллагаанд



оролцохгүй, ийм ажиллагаанд туслахгүй байхыг уриалга гаргасан.

Терроризм үүсэх үндсэн шалтгаануудыг улс төрийн, нийгэм-эдийн засгийн, эдийн засгийн, шашны, оюун санааны гэж ангилдаг. Шалтгаануудын эх сурвалжийг хөөн дурдвас, улс төрийн тогтворгүй байдал гэдэг бол терроризм үүсэх үндсэн шалтгаан болж байна.

Терроризм газар авах нийгэм-эдийн засгийн шалтгаан бол тухайн улс орны ард иргэдийн амьдрал ядуурч ахуй байдал доройтсонтой шууд холбоотой. Өөрийн гэсэн өмчлөх зүйлгүй болсон хүнд террорист халдлага хийх сэдэл амархан төрдөг бөгөөд эл үйлдлийг ямар ч эргэлзээгүйгээр хийдэг байна. Халдлага хийхээр шийдсэн хүний хувьд "хэрвээ би үхвэл миний гэр бүлийнхний төлөө бусад хүмүүс санаа тавих нь гарцаагүй" гэсэн итгэл үнэмшилтэй болчихсон байдаг.

Терроризм үүсч бий болох эдийн засгийн үндэсийн тухайд гэвэл: Алан хядах террорист ажиллагаа нь түүнийг зохион байгуулж буй хүмүүст их ашиг авчирдагтай холбоотой. Тэдний олдог мөнгөний хэмжээ нь газрын тосны наймааны орлоготой дүйцэхүйц бөгөөд дээр нь зэвсэг, хар тамхи нууцаар наймаалах, барьцааны хүмүүсийг мөнгөөр солих зэрэг өөр бусад олон эх сурвалжууд бий болоод байна.

Шашны сөргөлдөөний сэдэлтэй терроризмын үүслийн хувьд дэлхий дээр хүчирхийллийг сурталчилсан шашны урсгалууд маш олон бий. Тухайлбал, Саудын Аравид 18 дугаар зууны үед хүчээ авч эхэлсэн ваххабизм гэдэг исламын шашны урсгал гэх мэт.

Оюун санааны үндэс шалтгаан нь орчин үеийн нийгэмд дэгдсээр буй хямрал, хууль эрхзүй, хүн төрөлхтний нийтлэг үнэ цэнэт зүйлсийг гажуудуулж буй явдал болно. Оюуны хүчийг бус харин хар бярыг дээдлэх үзэл санааг хүүхэд багачуудын оюун санаанд суулгасан нь терроризм улам хүчээ авах нэгэн шалтгаан болох төлөвтэй байна.

"Террористууд яагаад ингэтлээ харгис хэрцгий үйлдэл хийдэг байдаг юм бэ?" гэсэн асуулт гарч ирэх нь зайлшгүй. 1900-аад оны эхэн үед Иван Каляев гэгч этгээд гэрт нь бөмбөг дэлбэлэх замаар Оросын Цагаан хааныг хөнөөх ёстой байсан хэдий

ч энэ үүргээ гүйцэтгээгүй байна. Иймээс анархист бүлгийнхэн цуглараад бөмбөг тэслээгүйн шалтгааныг түүнээс асуун байцаахад Каляев "тэнд хүүхдүүд байсан учраас яаж ч чадаагүй" гэж хариулсан гэдэг. Үүнийг террористууд "аргагүй шалтгаан мөн байна" гэж үзээд Каляевт зэм шийтгэл ногдуулаагүй өнгөрчээ. Гэтэл орчин цагийн террористуудын хувьд хүүхэд хөгшид, энгийн номхон иргэдийг аль болох олноор нь барьцаанд авч, аль болох олноор нь хөнөөж л байвал улс төрийн зорилго нь тэр хэрээр амархан, хурдан хэрэгждэг болсон байна. Үүгээрээ өнөө цагийн террористууд нь 1900-аад оны үеийн зорилго нэгтнүүдээсээ эрс ялгарах шинж төлөвтэй болжээ.

Урьд өмнө нь хувь хүн болон хэсэг бүлэг хүмүүс хязгаарлагдмал орон зайд террорист ажиллагаа үйлддэг байсан бол өдгөө "терроризмын даяаршил" гэж хэлж болохоор үзэгдэл газар авчээ. Террорист бүлгүүдэд янз бүрийн үндэстэн ястны, янз бүрийн улс орны хүмүүс нэгдэж, тухайн оронд төдийгүй хилийн чанадад тив алгасан алан хядах ажиллагаа үйлддэг болсон байна.

Америкийн нэрт улс төр судлаач З.Бжезинский терроризмын тухайд "энэ бол улс төрийн айлган сүрдүүлэлт хийхийн тулд энгийн ард иргэдийг алан хядаж буй уучилж болшгүй арга хэрэгсэл. Терроризм нь соёлт ертөнцөд аюул занал учруулж байна. Гэхдээ эл үзэгдэл нь дэлхий ертөнцийн янз бүрийн хэсэгт өөр өөр шалтгаанаар бий болдог. Лондонд болсон халдлага бол АНУ болон Их Британийн зүгээс явуулсан бодлогын нөлөөгөөр Ойрх Дорнодод бий болсон дайсагнал хонзогнолтой илт холбоотой" гэж дүгнэсэн байдаг. Түүнчлэн Чеченийн асуудлыг олон улсын террористууд Орос улсад халдах гэсэн оролдлоготой холбон үзэж болох эсэх тухайд тэрбээр: "Энэ асуудал бол Оросын цэвэр дотоод асуудал. Оросын нэг хэсэг байхаас үргэлж татгалзсаар ирсэн чеченчүүдийг Кремлийн ордныхон 200 жилийн туршид эрхэндээ оруулах гэж оролдсоор ирсэн" гэдгийг дурдсан байна.

Чеченчүүд Оросоос салмагц оросууд Грозный хотыг бөмбөгдөж үнсэн товрог болгосон төдийгүй Масхадов зэрэг аядуу үзэлтнүүд гал зогсоохоор оролдмогц



түүнийг хөнөөсөн. Үүний улмаас террористууд Чеченийн тэмцэлд голлох үүрэгтэй оролцох болсноор терроризмын үзэгдэл Кавказ, түүний дотор Дагестанд хүчээ аван тархаж эхэлсэн хэмээн Бжезинский дүгнэж байна. Дашрамд дурдахад, тэрбээр Оросын эсрэг байр суурь баримталдаг гэдгээрээ нэлээд зард гарсан судлаач юм.

Пуэрто-Рикогийн тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэхийн тулд зарим хүмүүс Ерөнхийлөгч Трумэны амь насанд халдах оролдлого хийж байсан удаа бий. Үүний дараа АНУ-ын эрх баригчид Пуэрто-Рикод ардчилсан чөлөөт бүх нийтийн санал асуулга явуулсан. Эндээс харахад, ер нь бол исламын шашны эсрэг соёл иргэншил хоорондын мөргөлдөөн дэгдэх магадлал нэгэнт бий учраас лалын аядуу үзэлт удирдагчидтай хамтран ажиллах хэрэгтэй, тэднийг өөрсдөөсөө холдуулан түлхэх хэрэггүй болох нь ойлгомжтой байна.

Геополитикч, судлаач С.Хантингтон "9 дүгээр сарын 11-ний террорист халдлага болон түүний хариу болгож америкчуудын хийсэн дайн нь иргэншил хоорондын мөргөлдөөн мөн" гэсэн нь дүгнэлтийг хийсэн юм. Ер нь аливаа сөргөлдөөн нь "Хүйтэн дайн"-ы дараах үеийн олон улсын харилцааны тодорхойлогч хүчин зүйл болох магадлалтай" байдаг хэмээн зарим судлаачид үзээд байна. Гэтэл харин ихэнх судлаачид "Нью-Йорк дахь Олон улсын худалдааны төвийг нисэх онгоцоор мөргөж нураах үед халдлагын золиос болсон хүмүүсийн дотор лалын шашинтнууд олон байсан, лалын шашинт хэд хэдэн орон терроризмын эсрэг эвсэлд нэгдсэн, лалын хэт давруу үзэлтнүүдийн террорист ажиллагаа нь шашны сэдэлтэй бус харин улс төрийн зорилготой байсан" гэх зэрэг хэд хэдэн үндэслэлийг гарган тавьсан байдаг.

Үнэхээр терроризм ба түүнээс улбаалсан иргэншил хоорондын мөргөлдөөн дэгдэх аваас хүн төрөлхтний ирээдүй нэлээд гамшигийн аюул дагуулж болзошгүй юм.

Хөрш хоёр их гүрэнд улс төрийн эмх замбараагүй байдал бий болбол манайд улс төрийн том аюулын эрсдлийг дагуулна. Тиймээс хоёр хөршийн улс төр, эдийн

засгийн тогтворгүй байдал нь манайд улс төр, эдийн засгийн аюулын эрсдэлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйлсийн нэг болно. ОХУ, БНХАУ гэсэн үндсэн хоёр хөрш манайхтай харилцахдаа эдийн засгийн хувьд харилцан ашигтай байхыг хичээхийн хамт өөр өөрсдийн ашиг сонирхлыг илүүтэй дээдэлж, хоорондоо тохиролцож байхыг үгүйсгэх аргагүй юм. Улс төрийн эрсдэл дагуулсан түүхэн үйл явдлууд үүнийг гэрчилнэ. Харин бид үүнийг мэдэрч, геополитикийн бодлогод нь "идэвхтэй" оролцож, "ухаалаг шийдэлтэй нүүдэл"-ийг ойрын занал, алсын аюулыг харгалзан явуулж байвал болзошгүй аюулын эрсдэлийг нь бууруулж болно.

Ийм "ухаалаг шийдэлтэй нүүдэл" хийхэд улсын гол мэдрэхүй бологч тагнуулын байгууллагын үүрэг нэн чухал юм. Үүнийг АНУ, ОХУ, БНХАУ, Израил зэрэг улсын судлаачдын болон Их Монгол улсын тагнуулын үйл ажиллагааны тухай нээлттэй баримт, материалаас гаргалгаа хийж, улс төрийн аюул, заналхийллийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд тагнуулын байгууллагын үүрэг, оролцооны талаарх онол, арга зүй чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Оросын холбооны улс дахь терроризмын өнөөгийн нөхцөл байдлыг шинжлэн үзвэл: дотоод дахь террорист байгууллага, этгээдүүдийн үйл ажиллагаатай ОХУ тууштай тэмцэж байгаагийн сацуу олон улсын терроризмтой тэмцэх явдлыг бэхжүүлэх, түүнд тусламж дэмжлэг үзүүлэх чиглэлээр ихээхэн хүчин чармайлт гаргана ажиллаж байна.

Дэлхийд өнөөдөр 600 шахам томоохон террорист бүлэглэл байгаагийн зохион байгуулалттай 40 шахам бүлэглэл ОХУ-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа нууцлагдмал, идэвхтэй явуулж буй судалгаа байна³. Мөн ОХУ-д халдлага үйлдэж байгаа гол этгээдүүд Чечений зохион байгуулалттай бүлэглэлүүд, салан тусгаарлагчид байдаг. Тэд гадаадын алан хядагч байгууллагуудаас санхүүжиж, алан хядах бусармаг ажиллагаагаа явуулдаг.

Зөвхөн 2013-2018 оны хооронд ОХУ-д 60 гаруй томоохон террорист халдлага гарч 1400 гаруй иргэн амь насаа алдсан байна.

³ Global Terrorism Index, GTI. URL: <http://www.globalterrorismindex.org> (accessed 01.10.2018);

Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ)-ын нэг гол зорилт нь терроризмтой тэмцэх ажиллагаа байдаг. Казахстанд хэт даврах болон террорист гэмт хэрэг үйлдсэн хэргээр шүүхээс ял авсан иргэдийн тоо өсөх хандлагатай болсон. Албан ёсны мэдээллээр Казахстанд 2017-2018 онд хууль сахиулах байгууллагууд болзошгүй 7 террорист халдлагыг таслан зогсоосон нь энэ аюул улс оронд хэдийнээ нүүрлэснийг харуулж эхэлсэн юм. Сүүлийн үед Казахстаны олон иргэд гадаадын улс орны террорист байгууллагын гишүүн болж байна. Албан бус тоогоор Афганистан, Пакистан дахь террорист бүлэгт 200 орчим казах иргэд байгаа Сири болон бусад Арабын улс оронд хэд байгааг тогтоох боломжгүй юм. Казахстаны хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээр гарч байгаа мэдээллээр бол тус улсаас "Исламын улс" алан хядах бүлэглэлд элссэн хүмүүсийн дотор олон тооны "монгол" байгаа аж. Казахстаны Ерөнхийлөгчийн хэвлэл мэдээллийн алба энэ асуудалд нэлээд эмзэглэж байгаагаа илэрхийлсэн байна. Хэрвээ Сири дэх "Ислам улс" бүлэглэлд үнэхээр Казахстанд суурьшин амьдарч байгаа Монголын казахууд олноор элсэн орж, дайтаж байгаа нь үнэн бол аюул, заналхийлэл үүсэх шалтгаан болно.

Тэдгээр Монголчууд исламын интернационалист үзэл санаагаа төрж өссөн газраа дэлгэрүүлэхээр Баян-Өлгий аймагт ирвэл манай улсад ч гэсэн Исламын улсын үзэл суртал халдварлах аюултай. Дэлхий даяар лалын шашинтнууд амьдардаг бүхий л улс орнууд энэ асуудалд анхаарлаа хандуулж байгаа цагт манай улс ч гэсэн анхаарлаа хандуулж Сир, Ливан хавиас буцаж ирж байгаа Монголчуудад хяналт тавих шаардлагатай юм.

Терроризмын аюул, занал хувьсан улс бүс нутгийн түвшингээс дэлхийн хэмжээнд тогтвортой байдал хангах асуудал болон хувирсан. Сири, Иракийн нутаг дэвсгэрт байлдсан "Исламын улс" (ИУ) террорист бүлэглэлийн гадаад террорист дайчид (foreign terrorist fighters-FTF) нутаг буцаж байгаа нь манай улсын аюулгүй байдалд сорилт болж болзошгүй. Технологийн хурдацтай хөгжил, исламын шашны хэт даврах үзлийн гуравдагч орныг чиглэсэн

ажиллагаа, уг үзэлд автаж болзошгүй оюутан залуучуудын тоо, ажилгүйдэл, хэт ядуурал зэрэг нь терроризмын эрсдэлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйлийн нэг болж байна.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга илтгэлдээ ядуурал, нийгмийн тэгш бус харилцаа нь терроризм, хүчирхийлэл дагуулсан экстремист үзэлд хүргэдэг. Террорист бүлэглэл маргаантай бүс нутгаас засаглал-хөгжлийн доройтолтой улс орноор хүрээгээ тэлж, интернет орчин, нийгмийн сүлжээ нь экстремизмын суртал ухуулгыг түгээх, гишүүн элсүүлэх, мөнгө олох гол хэрэгсэл нь болж байгааг анхааруулж дурдсан байна.

Зөвхөн 2011-2018 онд дэлхийн 140 орчим улсын 50 мянга гаруй иргэн эх орноо орхин "Исламын улс" (ИУ)-д нэгдсэн судалгаа байдаг. ИУ нь айдас, харгислал дээр тогтсон дэг журам, Шариатын (Sharia) хатуу хууль цаазаараа бусад террорист байгууллагуудаас ялгарч байна. Тэд Халифатын засаглалыг 2014 онд тунхагласнаас хойш дэлхийн 30 орчим улсад 150 удаагийн террорист халдлага үйлдсэн байна⁴.

Террорист бүлэглэлд элсэгчдийн дийлэнх олонх нь *Facebook*, *Twitter*, *LinkedIn*, *Youtube*, *Blog*, *ВКонтакте* зэрэг интернет орчны нийгмийн сүлжээгээр явуулж буй суртал ухуулгад автсан бөгөөд нийт гадаад террорист дайчдын 90,0 хувийг 18-27 насныхан эзэлж байжээ.

Тэд эх орноо орхихдоо аялал жуулчлалын зорилгоор явж буй мэтээр үйлдлээ халхавчилж, улмаар гуравдагч улс орноор, дийлэнхдээ БНТурк Улс, Хойд Африк, Төв Азийн орнуудаар дамжин өнгөрдөг байна. Нутгаа орхих болсон гол шалтгаанд ажилгүйдэл, хэт ядуурал, түүнээс улбаатай эд мөнгөний ашиг сонирхол, мэдлэг боловсролын түвшин, насны онцлогоос болж үзэл суртал, суртал ухуулгад амархан автдаг зэргийг дурдаж болно.

"Исламын улс"-ын амжилтын нууцад иргэд, тодорхой улс орнуудын тусгай албадын дэмжлэг, олон эх үүсвэрээс (газрын тос, хар тамхи, зэвсгийн наймаа г.м.) санхүүжилт авдаг, армийн хэмжээний зэвсэглэл, гадаадын тусгай албадын

⁴ <https://ikon.mn/n/1oeg>;



түвшний зохион байгуулалт бүтэц, цахим орчин дахь өргөн хэмжээний суртал ухуулга, элсүүлэлтийн ажиллагаа явуулсан зэрэгт оршиж байна.

Сүүлийн үед явуулсан ОХУ-ын Сири дэх цэргийн ажиллагааны үр дүнд "Исламын улс" террорист бүлэглэлийн 27000 гадаад террорист дайчид утсан мэдээ байдаг бол үлдсэн нь аажмаар шахагдан 2018 оны 5 дугаар сарын байдлаар нийт 8200 орчим дайчид⁵ 41 улс руу буцсан байна⁶. Эхний ээлжийнхэн нутагтаа ирмэгцээ террорист халдлага зохион байгуулан шинэ гишүүн эгнээндээ элсүүлээд эхэлсэн тул тусгай албад тэднийг хараа хяналтдаа байлгахгаар тусгай ажиллагаа явуулж эхлээд байна. "Исламын улс" (ИУ) террорист бүлэглэлийн гадаад террорист дайчдын нутаг буцсан тоон үзүүлэлтийг графикаар үзүүлэв.

Дэлхийн нэлээд улс хилээр нэвтрэхдээ баривчлагдсан этгээдийг Сирид байлдсан нь тогтоогдсон тохиолдолд иргэншлийг нь түдгэлзүүлэх, 20 хүртэл жилээр хорих

оны Афганы дайны дараагаар терроризм, хүчирхийллийн тоо эрс нэмэгдсэн талаар Лондонгийн их сургуулийн доктор Муса Абубакарын хийсэн судалгаа байдаг нь дээрх чиг хандлага, төлөв ОХУ-ын Сирийн ажиллагааны дараа ч ажиглагдаж болзошгүйг үгүйсгэх аргагүй юм.

Хэдийгээр "Халифатын засаглал"-ын эзэлсэн бүс нутгийн хэмжээ хумигдаж байгаа ч "ИУ"-ын хилийн чанад дахь гар хөл бологчид, буцаж буй дайчдынхаа дэмжлэгээр зорилго, уриагаа хадгалах, цаашид үйл ажиллагаагаа цахим орчинд тэлэх магадлалтай байна. Хар тамхи, мансууруулах бодисын эсрэг тэмцдэг цагдаагийн шинжээчдийн дүгнэлт (case) болгон иш татдаг the balloon effect буюу бөмбөлөгний нөлөөгөөр терроризмын эсрэг хатуу, үр дүнтэй тэмцэл явуулж буй улс оронд терроризмын гэмт хэргийн тоо буурах хэрээр манай улс шиг цахим орчны хяналтгүй улсад эсрэгээрээ нэмэгдэх магадлалтай юм. Тиймээс олон улсын



1 дүгээр график. Гадаад террорист дайчдын нутаг буцсан тоон үзүүлэлт⁷

эрүүгийн шийтгэл ногдуулах болсноор тэд гуравдагч орон руу илүүтэй зорьж байна. Террорист дайчид Европ, ОХУ, Зүүн Өмнөд Ази гэсэн үндсэн 3 чиглэлд зугтаж буйгийн ОХУ, Төв Азиас гаралтай нь нутаг буцах, гуравдагч улс орнуудад нэвтрэн террорист халдлага үйлдэх аюултай юм. 1979-1989

терроризмын үүсэж буй нөхцөл байдал, цаашдын чиг хандлагыг зөв тодорхойлон, гаднаас чиглэсэн хувьсан өөрчлөгдөж буй терроризмын аюул заналын нөлөөллөөс хамгаалах оновчтой бодлогыг боловсруулж, үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь чухал байна.

⁵ НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 2014 оны 2178 дугаар тогтоолоор "Foreign Terrorist Fighter" буюу "гадаад террорист дайчин" гэж өөрийн төрөлх нутгаа орхин хямралт бүс нутагт (Ирак, Сири зэрэг) зорчсон, улмаар террорист байгууллага, бүлэглэлд элссэн хүнийг хэлнэ гэж заасан;

⁶ Global Terrorism Index, GTI. URL: <http://www.globalterrorismindex.org> (accessed 01.10.2018); <https://ikon.mn/n/1oeg>;

⁷ Мөн тэнд;

Нэгд, Монгол Улсын эдийн засгийн үсрэнгүй хөгжил нь цаашдаа улс төрийн аюул, түүний эрсдэлийг нэмэгдүүлэх нэг эх сурвалж байхаар болж байна. Төсвийн хэт тэлэлт, инфляцийн өндөр түвшин, баян хоосны хэтэрхий ялгаа, зөрөө нь эрсдлийг улам л нэмэгдүүлж байна. Уул уурхайгаас улам их хамааралтай болж, улс орны эдийн засаг ганц тулгууртай болох хандлага байгаа нь аюулыг төрүүлж байна. Улс орны хөгжлийг олон тулгууртай болгож, импортлогч орноос экспортлогч, үйлдвэрлэгч орон руу хэр хурдан шилжихээс хамаарч манай улсад учирч болзошгүй эрсдлийн хэмжээ, хэмжүүр багасаж, улс орны хөгжил, дэвшлийг түргэтгэнэ. Хөгжлийн бодлого жигд өсөлттэй, хэт савалгаагүй, тогтвортой байх нь эрсдлийг бууруулах боломжийг олгоно. Үндэсний эдийн засгийг нээлттэй болгох нь хамтрагч нарт нөөцөд чөлөөтэй нэвтрэх, олз ашиг олох, хамгаалалтгүй шинэ орон зайг улам бүр хүсэмжилдэг. Үүнээс улбаалж "кессоны өвчин" тусч болзошгүй байна.

Хоёрт, төрийн захиргааны төв байгууллагуудад бодлого боловсруулах дээд албан тушаалын төрийн мэргэшсэн алба хаагч нарыг тогтвортой ажиллах боломж олгохгүй байгаа, эх орныхоо өмч, баялгийг хамгаална гэсэн "үндсэрхэг популистууд" төрсөн, улс төр, бизнесийн хүрээнд дэх "олгархи бүлэглэл" бий болсон үзэгдэл багтаж байна. Энэ нь улс төрийн шийдэл гаргах ул суурьтай үндэслэл боловсруулах боломжийг олгохгүй байна. Бас мэргэжилтнүүдийн боловсруулсан санал, зөвлөмжүүдийг хүлээн авахгүй, "үндсэрхэг популистууд", улс төр, бизнесийн хүрээнд дэх "олгархи бүлэглэл"-ийн ашиг сонирхлыг хамгаалах хандлага давамгайлах боломжийг олгох төлөв ажиглагдаж байна.

Гуравт, Монголын улс төрийн намууд төлөвшөөгүй, олон нийтийн санал бодлыг нэгтгэж, хууль, дүрэм, журам тогтоож, зохицуулалт хийх чадвараар ядмагхан байгаатай холбоотой байна. Энэ нь сөрөг хүчингүй, нэгдсэн Засгийн газар байгуулах, үйл ажиллагаа нь нийгэмд нээлттэй бус явагдах, ашиг сонирхлоо аваа өгөө дээр нэгтгэх боломжийг бүрдүүлж байна. Мөн төр засгийн удирдлагад "олгархи бүлэглэл" бий болох, тэдний эрх ашгийг дээдлэх зарчим үйлчлэх хандлагыг агуулах

боллоо байна.

Дөрөвт, төрийн дээд хүрээнд бодлого, үйл ажиллагааны залгамж чанар алдагдсан, төрд цөөн хэдэн хүн, тэднийг тойрон хүрээлэгч-үр хүүхэд, тэдний танил тал, нутаг усны хүмүүс "сургалж", нийгмээс тасарсан явдал орж байна. Энэ нь төрийн бодлогыг чин шударгаар явуулахад саад тогтор учруулж байна. Төрийн бодлого, үйл ажиллагаанд үр өгөөжтэй ажил, үйлс бүтээгчдийн үнэлгээ шударга бусаар явагдаж, тойрон хүрээлэгчдээ илүүтэй үнэлж дүгнэх нь нийгэмд мэдрэгдэх түвшинд хүрсэн байна. Төрийн үнэлгээ, дүгнэлт бол түүний шударгын илэрхийлэл гэсэн зарчим үйлчлэхгүй болжээ.

Тавд, Монголын төр, захиргааны байгууллага дахь хүнд суртал, хүчирхийлэлд суурилсан үйл ажиллагаа орж байна. Энэ нь манай улсад тохиолдоод буй хамгийн ноцтой асуудал болох авлига (коррупци)-ийг төрүүлэх эх үндэс болж байна. "Transparency International"-аас гаргасан судалгаагаар авлигад хамгийн их идэгдсэн орнуудаас Монгол Улс 2008 онд 102 дугаарт бичигдэж байсан бол 2009 онд 120 дугаарт, 2010 онд 116 дугаарт бичигдсэн байна. Нийгмийн хэв журам сахиулах, нийгэмд үйлчлэх үүрэгтэй хууль, хяналт, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, гааль, татварын байгууллагуудын үйл ажиллагаа хууль, дүрэм, журмаа дагахаас илүүтэй иргэдэд шахалт, дарамт үзүүлэх, хүчирхийлэх арга барилтай болжээ. Иргэдээ хамгаалах төрийн үүрэг, хүлээх хариуцлага суларч байгаа нь иргэний, хүмүүнлэг нийгмийнхээ шинж, мөн чанартай зөрчилдөх боллоо.

Ийм дүр төрх дэлхий дахинаа түгээмэл болчихсон байгаа тул НҮБ-аас Ази, Номхон далайн хамгаалалтын хариуцлагын төвийг байгуулан жил тутамд энэ асуудлын нөхцөл байдал, иргэдийг үй олноор хоморголон харгислах, аймаглан устгах, хилсдүүлэхийн эсрэг хамгаалалтыг хэрхэн явуулах асуудлыг онцгойлон авч үзэж байна. Энэ бүхэн нь төр, засаг нь нийгэмд улс төрийн аюулыг ихэсгэх, багасгах гол хүчин зүйлийн нэг болж байгааг харуулж байна.

Олигархижсан, авлигыг шүтэгч "хэсэг бүлэг"-ээс нийгэм нэн даруй салж хэмээн улс орны хөгжлийг хойш татагч нар үгүй болж, төр төдий чинээ хурдан цэвэршиж,



төрийн бодлогод тохиолдож болзошгүй улс төрийн аюул, эрсдэл буурах болно.

Төрийн цэгцтэй, туйлбартай, хариуцлагатай, бие даасан, нээлттэй ил тод, хуулийг чандласан бодлого тодорхойгүйгээс болж төрийн бодлого сонгуулийн 4 жилийн хугацаагаар хязгаарласан, богино настай, өнөө маргаашаа аргацаасан байдалтай байгаа нь манайд улс төрийн аюулын гол эрсдэл дагуулагч болох боломж үүсээд байна.

ДҮГНЭЛТ. Манай улсад Олон улсад үйл ажиллагааг нь хориглосон, ислам шашны хэт хуучинсаг үзэл номлолыг сурталчилдаг "Таблиги жамагат" хөдөлгөөний гишүүд болох Казахстан улсын иргэд Монголд ирэх хөдөлгөөн идэвхжсэн. Дээрх гадаадын иргэд Монгол Улсад шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авалгүй жуулчны визээр ирээд буцдаг. Энэ зам, сувгаар дамжин манай улсын ислам шашинт иргэд аюул заналд ч татагдан орох магадлал өндөр байгаагаас улбаалан олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр террорист ажиллагааны талаар ухуулга сурталчилгаа хийхгүй байх, харин түүнээс сэрэмжлэх, урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Харин хоёр хөрш ОХУ, БНХАУ-д гарч байгаа террорист үйлдлүүд нь салан тусгаарлах үзлийн үндсэн дээр хийгдэж байна. Иймд энэ үзэл бодол манай улсад баруун хязгаарт байгаа ислам шашинт иргэдэд сөрөг нөлөөлөл үзүүлэх боломжтой. Мөн хөрш орны террорист байгууллага, этгээдүүд нь өөрийн бааз сууриа манай улсад бэхжүүлж болзошгүй юм.

Манай улсад терроризм үүсэж

болзошгүй нийгэм, улс төр, эдийн засаг, зохион байгуулалтын зарим шалтгаан нөхцөл байна гэж дүгнэж болох юм. Монгол Улс терроризмын эсрэг эвсэлд нэгдсэн, геополитикийн хувьд терроризмын идэвхтэй бүсэд оршдог, хууль сахиулах байгууллагын хяналт сул, түүнтэй тэмцэх удирдлага, зохион байгуулалтын ажил дутагдалтай байгаа зэрэг нь терроризм үүсэх бодитой шалтгаан нөхцөлд орно.

Иймээс терроризм үүсэхээс сэргийлэх иж бүрэн арга хэмжээг хэрэгжүүлж, түүнтэй тэмцэх төрийн байгууллагуудын харилцан ажиллагааны уялдаа, зохион байгуулалтыг сайжруулах, гадаад хамтын ажиллагааг идэвхжүүлэх нь өнөөгийн шаардлага, хэрэгцээ болж байна. НҮБ-ын Терроризмтой тэмцэх хорооноос манай улсад 38 зүйл бүхий зөвлөмж гаргасан. Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх замаар нэгдэн ороогүй терроризмтой тэмцэх олон улсын 6 баримт бичигт нэгдэн орох чиглэлээр ажиллах шаардлагатай байна. Алан хядагчид буюу террорист ажиллагааг зохион байгуулагчид нь үйл ажиллагаагаа явуулах аятай нөхцөлийг байнга эрэлхийлж, цаг хугацаа, орон зайн болон арга тактикийн боломжийг хлээж байдаг.

Ийм ч учраас алан хядах ажиллагаа болон террорист ажиллагаа нь санаанд оромгүй газар, хэний ч хүлээгээгүй цагт, урьдчилан төсөөлөөгүй арга хэлбэрээр явагддаг гэдгийг Монгол иргэдэд байнга анхааруулж байх хэрэгтэй байна. Учир нь манай орон аль хэдийнээ өөрсдийн хийж байгаа гадаад нөхцөл байдлаасаа олон улсын болон хөрш орны экстремист, террорист байгууллагын халдагын бай болох нөхцөл бүрдсэн байна.

Ашигласан материал:

1. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 2014 оны 2178 дугаар тогтоол;
2. "Олон улсын терроризм ба Монгол Улс" (Онол практикийн бага хурлын эмхтгэл). УБ., 2004;
3. Пүрэвдорж. С. "Зэвсэгт хүчний тусгай томилгоот анги, салбарын террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны сургалтын туршлага, сургамж". Илтгэл. УБ. УБХИС. 2019 он.
4. "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай" Монгол Улсын хууль. 2019 он;
5. Global Terrorism Index, GTI. URL: <http://www.globalterrorismindex.org> (accessed 11.28.2018);
6. <https://ikon.mn/n/1oeg>;